

Ө.Цэндсүрэн, Р.Бигэрмаа, П.Жаргалсайхан, У.Нямхүү

# МОНГОЛ ХЭЛ

## III

Ерөнхий боловсролын сургуулийн  
3 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
M-692

Монгол хэл III: Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурах бичиг.  
/Цэндсүрэн Ө., ба бус; Ред. Өнөрбаян Ц. -УБ. 2014. -152х./

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-23-9

## ГАРЧИГ

1. Захидал бичих үү?	5
2. Хүсэл мөрөөдлөө яаж биелүүлэх вэ?	16
3. Тоочин жагсааж бичиж суръя	24
4. Уншиж ойлгосноо дуурайн бичицгээе	38
5. Баатрын хэлэх үгийг төсөөлье	55
6. Чухал хэсгийг ялгаж ойлгоё	73
7. Үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлая	85
8. Зохиолын үйл явдлыг таамаглая	96
9. Баатруудын зан чанарыг жишээгээр тайлбарлая	104
10. Төлөөлөн уншиж, дүрд тоглоцгооё	117
11. Уншсанаа хэлэлцэж сурцгаая	136
12. Уншиж ойлгох, бичих чадвараа хөгжүүлцгээе	141

Таних тэмдэг



Унших чадвар

Х.3

Хэл зүй



Ярих сонсох чадвар



Бичих чадвар



Бүлгийн дүгнэлт

## СУРАХ БИЧГИЙН АГУУЛГА

	Унших чадвар	Хэлзүй, үгийн сан	Бие дааж тогтмол хийх ажлууд
<b>Захидал бичих үү?</b>	Энгийн ба талархлын захидал унших Захидлын агуулгаас асууж ярих Талархсан утгатай захидал бичих	9+9 зөв бичих Хэн, юу, яав, яаж, яагаад, ямар учраас гэсэн асуултад хариулагдах үгийг олох	Бусдад талархсан захидал бичих
<b>Хүсэл мөрөөдлөө яаж биелүүлэх вэ?</b>	Төлөвлөгөө ямар бүтэцтэй байдгийг уншиж мэдэх Асуултаар ярилцах тодруулан асуух Хүсэл мөрөөдөл зорилгодоо нийцүүлж төлөвлөгөө зохион бичиж сурах	Эгшигт гийгүүлэгчийг ямагт эгшигтэй бичиж сурах	Өөртөө зорилготой болох зорилгодоо хүрэхийн тулд жилийн төлөвлөгөө хийж хэрэгжүүлж сурах
<b>Тоочин жагсааж бичиж суръя</b>	Таних тэмдэг, заавар уншиж ойлгох Шошгын тайлбарыг тоочин жагсааж бичих	Юу? гэсэн асуултад хариулагдах үгийг жагсаан бичих	
	Номын тэмдэглэл уншиж ойлгох Санаа бодлоо чөлөөтэй хэлэх бүтцийн дагуу уншсан номоо тэмдэглэн товч бичих	Алдаагүй зөв бичих	“Уншлагын түүх” номын тэмдэглэл хөтөлж сурах. Өөрөө бүтэц зохиож болно.
	Жагсаалт байдлаар бичсэн мэдээллийг уншиж ойлгох Бусдын хэлснийг тогтоох Жорыг үгээр тоочин жагсааж бичих Хоол хийх аргыг өгүүлбэрээр тоочин жагсааж бичих	Ялгах эгшгийг гээхгүй бичиж сурах Яах? гэсэн асуултад хариулагдах үйл үгээр өгүүлбэр төгсгөх	“Бие даах дэвтэр” дээрээ ялгах эгшгийг гээхгүй бичсэн жишээ 15 -ыг олж бичих
<b>Уншиж ойлгосноо дуурайн бичигчээ</b>	Шүлгийг ойлгож, мэдэрч унших Шүлгийн хэлбэрийг дуурайн зохиож бичих “Ертөнцийн гурав”-ын хэлбэрийг дуурайн бичих	Нүдэлж тогтоож зөв бичих үгс: мярс мярс, өчиггүй, хөрөнгө, хатингар, хэчнээн, цоморлог	“Бие даах дэвтэр”-тээ 2 шүлэг, “ертөнцийн гурав” - 4-ийг зохион бичих
	Өгүүлэг уншиж учир шалтгааныг ойлгох учир шалтгааны асуулт зохиох Асуултаар учир шалтгааныг олж тайлбарлах Бусдын хэлснийг сонсож ойлгох	Яах гэж, ямар учраас? юуны учраас, яагаад, юунаас болж зэрэг асуултыг хэрэглэх Үйлт нэрийн “-х” -г зөв бичих утга ялгасан үгсийг нүдлэн тогтоох	“Бие даах дэвтэр”-тээ “-х”-тэй үг 30-ийг бичнэ. (аргадах, ярганах, зандрах, архирах, үерлэх, дүрэлзэх, эрчлэх г.м)
<b>Баатрын хэлэх үгийг төсөөлье</b>	Зохиолын баатрын үгийг ургуулан бодож төсөөлөх Асуултад оновчтой хариулж ярих Төсөөлөн бодож зохион бичих	Эгшигжүүлэх үүрэгтэй эгшгийг гээхгүй бичиж сурах Анхааруулах өгүүлбэрийг зөв хэрэглэх, цэг тэмдгийг мэдэх	“Бие даах дэвтэр” дээрээ эгшигжүүлэх үүрэгтэй эгшгийг гээхгүй бичих үг 20-ыг олж бичих
	Зохиогчийн ба баатрын үгийг ялгах Асуултад оновчтой хариулж ярих Сонссон, харснаа тодорхой ярих Болсон явдал бичих	Болсон явдал зохиохдоо хэн, юу, яав, яаж, яагаад, ямар учраас зэрэг асуултыг зөв хэрэглэх	Л.Түдэв “Мөнхийн ус” зохиолыг уншиж тэмдэглэл хөтлөх.
<b>Чухал хэсгийг ялгаж ойлгоё</b>	Уншсанаас чухлыг ялгах, чухал гэж үзэж байгаа шалтгаанаа тайлбарлах Чухлыг тэмдэглэж унших аргыг эзэмших Төрсөн бодол сэтгэгдлээ хэлэх Уншсан зүйлийн талаар сэтгэгдлээ илэрхийлж бичих	Хоолойн “г” -ийн ялгах эгшигтэй үгийг зөв бичиж сурах Томоор эхэлж бичдэг үгсийг тогтоох	СБ-ийн 77-р хуудсанд байгаа номын нэрсээс 3 -аас доошгүйг сонгож уншаад, “Уншлагын түүх” дээрээ төрсөн сэтгэгдлээ бичнэ.
<b>Үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлая</b>	Уншсан зохиолын учир шалтгааныг тайлбарлах Зохиолыг сонсож ойлгох Бусдын өмнө тодорхой ярих	Шалтгааныг бичихдээ яагаад гэвэл, тийм учраас, гм холбох үгийг хэрэглэж сурах	“Богинохон нөхөрлөл”, “Жинхэнэ найзууд” үлгэрүүдийг “Уншлагын түүх” тэмдэглэлдээ бичнэ.
	Сонссон зохиолыг ойлгож учир шалтгааныг тайлбарлах Асуултаар агуулгын дарааллыг ярих Хурааж бичих	Үгийн утга мэдэх: төсөөрөх, уур нүүдүүр, хөгшчүүл, хэвтэй, эзэгтэй, холтлоод, ааг,	
<b>Зохиолын үйл явдлыг таамаглая</b>	Ургуулан бодож таамаглан ярих Бусдын таамаглан ярьсныг лавшруулж тодруулан асуух Таамаглан ба зохиолын үйл явдлыг харьцуулан бичих	Зөв бичиж сурах үгс: агуй, ааруул, эзэгний, шуурга, бодъё, дуудъя, явъя, тачигнатал, хашхирах, уушги	Бие даах дэвтэртээ “шуурга” гэсэн үгтэй адил бичлэгтэй үг 8-ыг, бодъё, дуудъя, явъя- гэсэн үгтэй адил бичих үг 15 -ыг бичнэ.
<b>Баатруудын зан чанарыг жишээгээр тайлбарлая</b>	Үйл явдлын дарааллыг ойлгож унших Баатруудын хэлсэн үг, хийсэн үйлдлийг ялгах Баатрын зан чанарыг зохиолын жишээгээр тайлбарлах Асуултад бүтээлчээр хариулах Зан чанарыг тодорхойлж бичих	Оноосон нэрийг зөв бичих	“Нугасны муухай дэгдээхэй”, “Үнсгэлжин” зохиолуудаа “Уншлагын түүх” номын тэмдэглэлд бичнэ. Баатрын зан чанарыг жишээгээр тайлбарлаж бичнэ.
<b>Төлөөлөн уншиж дүрд тоглоцгоё</b>	Дуу хоолой, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлж унших Баатруудыг төлөөлөн хэлэхэд төрсөн сэтгэгдлээ бичих	Дараалсан 3 гийгүүлэгчтэй үгийг зөв бичиж сурах Ойролцоо эсрэг утгыг бататгах	
	Үлгэр уншиж ойлгох Үлгэр зохиож бичих		
<b>Уншсанаа хэлэлцэж суръя</b>	Өгүүлэг, оньсогыг уншиж ойлгох Бусдын ярианаас лавшруулж асуух, хэлэлцэх	Алдаагүй зөв бичих	

## ЗАХИДАЛ БИЧИХ ҮҮ?

Захидалдаа баярласан сэтгэлээ илэрхийлэн бичиж болох юм болов уу?

Захидлыг яаж бичдэг юм бол оо!

Найз минь багшийнхаа зан ааш, байдал төрхийг дүрслэн бичсэн байна шүү дээ.




## ЗАХИДЛЫН ТУХАЙ ЮУ МЭДЭХ ВЭ?

Захидал уншиж талархсан захидал бичих  
Талархсан утгатай үг хэллэг хэрэглэж сурах



## ЗАХИДАЛ ЯАЖ БИЧДЭГИЙГ МЭДЭЖ, ЯРИЛЦАЦГААЯ

Найзын чинь төрсөн өдөр удахгүй болно. Түүнд баяр хүргэж мэндчилгээ бичээрэй.



### Ахад ирсэн захидал

Миний ах тавдугаар ангид сурдаг. Түүнд нэгэн захидал иржээ. Ах минь захидлаа дахин дахин унших юм. Тэр их баярласан царайтай байлаа.



Ах аа! Хэн танд захидал бичсэн юм бэ?



Уучлаарай!  
Захидалд юуны тухай бичсэн байна? Сонирхолтой юм уу?  
Ах аа!



За, баярлалаа. Ах аа!



Найз минь бичжээ.  
Зусланд амарч байгаа юм.



Сонирхолтой байна. Юуны тухай бичсэнийг нь уншаад мэдээрэй.

#### 1) Захидлыг уншиж ойлгоё.

- 1) Захидал ямар, ямар хэсэгтэй байгааг мэдэж, уншъя.
- 2) Хэсэг бүрд юу, юуны тухай байна вэ?



2013 оны 8 дугаар сарын 1

Сайн уу? Найз аа.

Эхлэл хэсэг

Найз нь зусланд ирээд, сайхан амарь байна. Оглөө эрт ойд хөхөө шувуу донгодно. Бас буга урамдан, шувууд жижигдэг. Урнийг сонсоход нэг л сайхан байх юм.

Энд амрах гэж ирсэн хүүхдүүд бие биедээ туслан, тоглож наадаж, санаа зовох зүйлгүй байна. Тийм болохоор хүүхэд бүр тайван амгалан, хэгнэн сайхан гээг.

Гол хэсэг

Манай багшийг Туул гэдэг. Туул багш өндөр нуруутай, хар үстэй, их эелдэг, сайхан сэтгэлтэй. Багш минь бидэнд шинэ дуу, шүлэг, тоглоом заадаг. Бид сайн сурь байгаа. Улам сайн сурья гэж боддог.

Багш "Та нар бүгдийг гадна." гэж бидэнд хэлдэг нь надад их гоё санагддаг. Саяхан бид нэг тамиргны тухай ном уншсан. Тэр тамиргин багадаа шатар тоглодог байсан тул тэвгээртэй болсон гэсэн байсан. Хөёулаа даам тоглодог шүү дээ. Одоо шатар тоглож байна. Бид одоо 21 хононо. Сонин ихтэй хариу захиа бичээрэй.

Төгсгөл хэсэг


Хүндэтгэсэн:

Найз Долгоон гинь



Захидлыг ойлгохын тулд асуултад хариулж, ярилцъя.

- 1) Байгалийн байдлыг дүрсэлсэн хэсгийг найздаа ярьж өгье.
- 2) Багшийгаа яаж дүрслэн бичсэн байна вэ? Нөхдөдөө чанга уншиж өгье.
- 3) Яагаад шатар сурахыг хүссэн бэ? Ярилцъя.
- 4) Захидлын бүтцийн загварыг гүйцээж бичээрэй.





Ахын бичсэн хариу захидал

1) Ах минь найздаа хариу захидал бичжээ. Түүний юу бичсэнийг уншиж, ойлгоё.

- 1) Аавынх нь хэлсэн үг Билгүүнд юу бодогдуулсан бэ?
- 2) Яагаад шатар сурахаар шийдэв?



2013 оны 8 дугаар сарын 5

Сайхан амарг байна уу? Миний найз аа!

Тийм гоё газар амарг байгаад гинь баяр хургэе.

Би аавд шатар тоглодог байсан талмиргны тухай ярьсан. Аав надад хигээл эхлэхээс өмнө шатар авч өгнө гэсэн шүү. Хөёулаа гамайг үрэхээр шатар тоглоноо.

“Шатар тоглохдоо оюун ухаан сайн хөгждөг” гэж аав хэлсэн. Тэвгээртэй, хүлээцтэй болдог гэж байна. Бас их ухаантай болдог гэнэ.

Тоглохдоо ноён, бэрс, тэрэг, морь, тэмээ, хүү гэсэн зургаан өөр хэлбэр дүрсээр, жаран дөрвөн нүд бүхий хөлөг дээр тоглодог гэсэн. Аав надад зааж өгнө. Харин би гамайг үрэхээр зааж өгье. Хурдан үрээрэй.

Миний найз:  
Билгүүн гинь

Үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
хөлөг	.....	тоглоомыг өрж тоглох, хүснэгт бүхий тавиур

2) Захидалд юу юу өгүүлснийг мэдье.

- 1) Асуултад хариулагдах үгсийг захидлаас түүж бичье.

хэн?	юу?	ямар?	хэдэн?	яах?
Билгүүн	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....

- 2) Дараах асуултад зөв хариулж бичье.



Билгүүн хэнд захидал бичсэн бэ?

Захидалдаа юуны тухай бичсэн бэ?

Найзууд ямар тоглоомоор тоглодог байсан бэ?

Аав нь хэзээ шатар авч өгөх вэ?



Шатар тогловол ямар болох вэ?

Хэдэн өөр дүрсээр тоглодог вэ?



Яагаад шатар тоглох хэрэгтэй вэ?

Шатар ямар хэлбэр, дүрстэй вэ?

Яаж тоглодог вэ?

Ямар өнгөтэй вэ?

### 3) Захидлыг уншиж ойлгоё.

- 1) Баярласан сэтгэлийн үгийг түүж бичье.
- 2) Отгоо эгчдээ ямар зорилгоор захидал бичсэн бэ? Асуулт зохиоё.

2013 оны 6 дугаар сарын 15

Сайн уу? Хайрт эгч минь.

Миний төрсөн өдөрт зориулж, таны бэлэглэсэн түүхийг авч их баярлалаа. Надад яг таарч байна. Та намайг хорин зургаан размер эмсдөгийг мартаагүй байна ичч. Өнгө нь л их зориж байна.

Би биеийн тамирын хилээлд орсч бүрдээ танд баярлаж, таныг боддог. Миний энэ баярласан сэтгэлд та л бас баярлах байх аа.

Таныгаа хүндэтгэсэн  
Дүү Отгоо минь

- 3) Билгүүний найздаа бичсэн захидал, Отгоогийн эгчдээ бичсэн захидал хоёрын ялгааг хүснэгтэд бичье.

Энгийн захидал	Талархлын захидал
1. _____	1. _____
2. _____	2. _____

### 4) Захидал бичиж сурахын тулд заавал байх хэсгийг гүйцээж бичье.

- 1) Зохиолч М.Горькийн хүүдээ бичсэн захидлыг уншъя.
- 2) Аав нь хүүдээ захисан захиасыг чи юу гэж ойлгов? Ярилцъя.
- 3) Орхигдсон хэсгийг зохих байранд нь нөхөж бичье.
- 4) Талархсан захидал гэдгийг яаж мэдэв?

## Зохиолч М.Горькийн хүүдээ бичсэн захидал



Зүрхний хайртай .....

Чи хол явсан боловч чиний тарьж ургуулсан цэцэг ургасаар байна. Үүнийг харах бүр надад сайхан сэтгэгдэл төрөх юм. .... аавыгаа сайхан цэцэг харж байг гэж үлдээсэн хэрэг шүү дээ.

Хүү минь чи хэзээ, хаана ч явсан өөрийн амьдралынхаа туршид хүмүүст ийм л .....

Ямагт авах, идэхийг бодсоноос ямагт өглөгч, тусч байсан нь эрхэм гэдгийг битгий мартаарай.

1905 оны 1 сарын 9 өдөр

хүү минь сайн байна уу?

сайхан цэцэг, сайн үйл үлдээж яваарай.

Хүү минь

Хайрт аав нь



### ЗАХИДАЛ БИЧИХ АРГЫГ СУРЦГААЯ

#### 1 Юуны тухай бичихээ сонгоё.

- Найз чинь яг юу мэдэхийг хүсэж байгааг төсөөлөн бодоорой.
- Яаж дүрслэн бичих вэ?

Амжилт гаргасан найздаа баяр хүргэсэн захидал


Чи зуны амралтаараа баян бүрд үзжээ. Хол байгаа найз чинь баян бүрдийн тухай мэдэхийг хүсэв. Түүнд бичсэн захидал

Гөлөг бэлэглэсэн найздаа бичсэн талархсан захидал

Эхний ноорог

Миний найз надад бэлэглэсэн

Өдөржин иддэг



Банхар

Байнга хуцдаг

Хөөрхөн

## 2 Бичсэнээ уншаад, засаж сайжруулъя.

Зассан хоёр дахь ноорог.

Миний найз надад бэлэглэсэн.

Найзынхаа сайхан сэтгэлийг байнга бодож байгаа.

Яагаад гээч! Чи, миний юу хүсдэгийг ойлгодог учраас л тэр.



Сэгсгэр шар үстэй

~~Өдөржин иддэг~~

Хөөрхөн хар нүдтэй, богинохон хөлтэй.

~~Байнга хуцдаг~~

## 3 Нооргоо харж, захидлаа засаж бичье.

2013 оны 08 сарын 15  
Сайн уу? Хайрт найз Туяа!

*Түүнд Банхар гэдэг нэр өгсөн. Банхар маш хурдан гүйдэг. Бас их өндөр үсэрч надтай байнга тоглож байгаа. Тэр байнга хуцдаг бас өдөржин иддэг. Түүний хар нүд, богино хөл, сэгсгэр шар үс нь надад их таалагддаг. Улам л хөөрхөн болоод байгаа. Их хөөрхөн хав шур. Дараа чамд зургыг нь явуулья.*

Хүндэтгэсэн Найз  
Болд чинь

Өө! Тэр байнга хуцдаг бас өдөржин иддэг. өгүүлбэрийг хасах юм байна.



## 4 Захидлын алдаатай өгүүлбэрийг засаж зөв бичье.



Дараа чамд зургийг явуулья.  
Дараа чамд зургийг явуулья.

Харах хэсэг

Дараа нь чамд зургыг нь явуулья. Дараа нь чамд \_\_\_\_\_ нь явуулья.

5 Орхисон санаа байгаа эсэхийг шалгая.

Найздаа талархсан тухай бичээгүй байна шүү дээ.



Өө, тийм байна. Би одоо нэмээд оруулчихъя.

- 1) Найздаа ямар сэдвээр захидал бичиж байгааг ярилцъя.
- 2) Талархсан утгатай өөр ямар үг хэллэг нэмж болох вэ?

6 Зөв болгон бичицгээе.

2013 оны 08 сарын 15  
Сайн уу? Хайрт найз Туяа!

*Түүнд Банхар гэдэг нэр өгсөн. Чи надад хөөрхөн гөлөг бэлэглэжээ. Чиний сайхан сэтгэлийг үргэлж боддог. Яагаад гээч! Чи, миний юу хүрдэгийг ойлгодог учраас л тэр. Банхар маш хурдан гүйдэг. Бас их өндөр үсэрч надтай байнга тоглож байгаа. Түүний хар нрд, богино хөл, сэгсгэр шар үс нь надад их таалагддаг. Улам л хөөрхөн болоод байгаа. Их хөөрхөн хав шүү. Дараа чамд зургийг нь явуулъя.*

Хүндэтгэсэн Найз  
Болд чинь

- 1) Зассан захидлаа дахин уншиж, засаж сайжруулъя.

Өө! Эхний өгүүлбэрийн байрыг солих нь зөв юм байна.



*Чим хөөрхөн амьтантай найз болгосон чамд баярлалаа гэж талархсанаа бичье.*

2013 оны 08 сарын 15  
Сайн уу? Хайрт найз Туяа!

*Чи надад хөөрхөн гөлөг бэлэглэжээ. Түүнд Банхар гэдэг нэр өгсөн. Чиний сайхан сэтгэлийг байнга бодож байгаа. Яагаад гээч! Чи, миний юу хүрдэгийг ойлгодог учраас л тэр. Банхар маш хурдан гүйдэг. Бас их өндөр үсэрч надтай байнга тоглож байгаа. Түүний хар нрд, богино хөл, сэгсгэр шар үс нь надад их таалагддаг. Улам л хөөрхөн болоод байгаа. Их хөөрхөн хав шүү. Чим хөөрхөн амьтантай найз болгосон чамд баярлалаа. Дараа чамд зургийг нь явуулъя.*

Хүндэтгэсэн Найз  
Болд чинь

1 Заримдаг гийгүүлэгчтэй үгийг яаж бичдэгийг ажиглаж мэдье.

бусад	бусдад	нөхөд	нөхдөд	зочид	зочдод
малчид	малчдад	төлчид	төлчдөд		

Би үүнийг мэднэ.

Эдгээр үгс нь бүгд заримдаг гийгүүлэгчээр төгссөн, бас бүгдэд нь заримдаг гийгүүлэгч “-д” залгаж бичжээ. Заримдаг гийгүүлэгчийн дараа орсон заримдаг гийгүүлэгчийн өмнө нь заавал эгшиг бичдэг.

Тийм байна. Гэхдээ нэг чухал зүйл байна. Хоёр заримдаг гийгүүлэгч нэг дор орж байгаа учраас л эгшиг бичих ёстой.

Миний мэдсэн зүйл.

Би үүнийг мэдлээ.

“бусдадаа, нөхдөдөө, зочдодоо” гэж бичнэ шүү дээ. “а, о, ө” эгшгүүд нь эгшигжүүлэх үүрэгтэй учраас гэж болохгүй юм байна.

2 Захидлаа хаяглах аргыг мэдье.




Ах аа! Захидлаа яаж хаяглах вэ?




Миний дүү, энэ дугтуйг аваад өөрөө сайн ажигла даа. Яаж хаягласан байна?

Хаанаас

Хаана



МОНГОЛ ШУУДАН ХАЯГ БИЧИХ ЗАГВАР



**3 Найздаа талархлын захидал бичье.**



Юунд талархаж байгаагаа бичнэ.

Талархсан сэтгэлээ янз бүрийн үгээр илэрхийлж болно



Болд хүү хотын нэгэн сургуулийн 3 дугаар ангид сурдаг. Багш нь захидлыг алдаагүй зөв бичих тухай заажээ. Болд хүү сайн ойлгов. Тэгээд Говь-Алтай аймагт амьдардаг найз Туяадаа талархсан захидал бичихээр боллоо. Учир нь Болд өнгөрсөн зун тэнд амарсан юм. Тэр үед Туяа, Болдод олон сайн үйлээр тусалжээ. Тэр талархсан сэтгэлээ яаж илэрхийлэх вэ?

**4 Захидал бичихдээ хэрэглэх үгсийг ярилцаад, бичье.**

Эхлэл хэсэгт:	Гол хэсэгт:	Төгсгөл хэсэгт:
Хайрт Хүндэт Эрхэм } найз, аав, ____		Захидал бичсэн: Ёсолсон: Хүндэтгэсэн: } найз хүү, Болд, ____

Амар байна уу?  
Сайн байна уу?  
Тавтай сайхан уу?  
Энэ өдрийн мэнд хүргэе.  
Амрыг айлтгая.

Юуны тухай буюу гол зүйлээ бичнэ.  
Талархах үг:  
... гялайлаа  
... сэтгэлд сайхан ...  
... ямар гайхалтай ...

... дараа ...  
... удахгүй ...  
... мөдхөн ...  
... баяртай ...  
... байгаарай ...

*Талархлын захидал*

---



---



---



---

5 Зөв, бурууг ярилцъя.

Сэтгэлээ нээж, ойлголцохын тулд захидал бичдэг.

Хүмүүс баярласан талархсан сэтгэлээ илэрхийлэхийн тулд захидал бичдэг.

зөв буруу

Захидалыг алдаагүй бичдэг.


Бичсэний дараа уншиж үзээд, алдаагаа засдаг.

Талархсан үг хэллэг ашиглаж бичдэг.


Захидал бичихдээ эхлэл, гол, төгсгөл хэсгийг бичихгүй байж болно.

6 Сонирхолтой даалгавар хийж гүйцэтгэе.

- 1) Энгийн захидлыг 60 хувь гэж үзвэл, талархлын захидал хэдэн хувь байгааг графикаас уншиж ярилцъя.
- 2) 1994, 2004 онд бичсэн захидал нэмэгдсэн үү? багассан уу?



3) Графикаас уншиж ойлгоё.



Ойлгох зүйл нь юу вэ? .....



Чиний зорилго юу вэ?



Чи юу хүсэж мөрөөддөг вэ?

### ТӨЛӨВЛӨГӨӨ БИЧИЖ СҮРЪЯ?

Юу хүсэж мөрөөдөж байгаагаа сайн бодож, түүнд хүрэхийн тулд юу, юу хийхээ төлөвлөн бичиж сурцгаая





## ХҮҮХДҮҮД ЮУ, ЮУ ХҮСЭЖ МӨРӨӨДДӨГИЙГ МЭДЭЦГЭЭ

### 1 Хүсэл мөрөөдлийг мэдэхийн тулд уншиж ойлгоё.

1 Хүн бүхэн хүсэл мөрөөдөлтэй байдаг.



2 Хүүхэд бүр би тийм юм хийж сурна, тийм хүн болно, тийм юм бүтээнэ гэж мөрөөддөг.

3 Бага насны хүүхэд бол байнга тоглож наадахыг хүснэ.

4 Зарим хүүхэд том болоод хэн нэгнийг дуурайж тэгнэ дээ, ингэнэ дээ гэж ирээдүйнхээ талаар бодож мөрөөддөг.

- 5 Хүсэл мөрөөдөл янз бүр байна.
- Шинэ программ зохионо.
  - Уран зураач болно.
  - Бүтээлээрээ үзэсгэлэн гаргана.
  - Борооны ус хураадаг сав бүтээнэ.
  - Говь нутгийг ногоон болгоно.

6 Бид хүсэл мөрөөдлөө биелүүлэхийн тулд тодорхой зорилго тавина.

1) Асуултаар ярилцъя.

1. Хүн яах гэж хүсэж мөрөөддөг вэ?
2. Явал хүсэл мөрөөдөл биелэх бол?

### 2 Өөрийнхөө болон бусдын хүсэл мөрөөдлийг ярилцъя.



Шинэ технологи бүтээнэ.



Өөрийгөө зоригтой байлгах

Хүсэл мөрөөдөлдөө хүрэхийн тулд төлөвлөгөө хийж байх



Ихийг сурч мэдэн эрдэмтэй хүн болно.





Найрал дууны дугуйланд  
явж олон найзтай болох



Олон найзтай  
болох

- 1) Миний хүсэл мөрөөдөлтэй адил зүйл байна уу? Бодъё.
- 2) Өөрийнхөө болон найзуудынхаа хүсэл мөрөөдлийг жагсааж бичье.



Чи олон хүсэл  
мөрөөдлөөсөө  
энэ жил юуг нь  
биелүүлэх вэ?




- Шинэ программ зохионо. } **ЗОРИЛГО**
- Ном их унших } **ЭНЭ ЖИЛ ХИЙХ АЖИЛ**
- Компьютер сайн сурах }



### 3 Аав охин хоёрын харилцан яриаг уншаад, асуултад хариулцгаая.

- Туяа, миний охины энэ жилийн зорилго юу билээ?
- Энэ жил би илүү сайн хүүхэд болно. }
- Аа тийм үү. Ямар хүүхдийг сайн хүүхэд гэдэг юм бэ?
- Ээжийнхээ үгэнд сайн орж, дүүтэйгээ муудалцахгүй байх болно. Дүүдээ сайн эгч болохын тулд цагаа зөв зохицуулна. }
- Үнэхээр зөв зүйл бодсон байна.
- Дүүдээ 7 хоногт 4 удаа ном уншиж өгнө. Бас түүнийгээ ярилцана. }
- Гэрийн ажлаа дүүтэйгээ хамтарч хийнэ.
- Түүнд бүжиг зааж өгье. }



1) Асуултаар ярилцъя.

1. Туяа энэ жил ямар, ямар зорилго тавьсан бэ?
2. Зорилгоо яаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бэ?

## Бодох зүйл

Хүсэл мөрөөдлөө зорилго болгож бодно. Тэр зорилгоо биелүүлэх төлөвлөгөө хийнэ.



## ТӨЛӨВЛӨГӨӨ САЙН БИЧИХ АРГЫГ СУРЦГААЯ

### 1) Мандахын төлөвлөгөөний тухай уншаад, төлөвлөгөөнд юу бичиж болохыг төсөөлөн бодоорой.

Мандах ээжийнхээ тусламжтайгаар төлөвлөгөө хийсэн. Харин аав нь “Хэцүү төлөвлөгөө битгий хийгээрэй.” гэв. Мандах хоёр ажил л төлөвлөжээ.

Эрүүл байхын тулд дасгал сайн хийж байна. Үүний тулд 6 цагт босож байх ёстой гэж бодсон. Гэвч өдөр бүр дасгал хийх төлөвлөгөөгөө биелүүлж чадаагүй. Яагаад гэвэл 6 цагт босох нь хэцүү байсан.

Бас шинэ найзтай болохын тулд хичээх хэрэгтэй гэж бодсон. Мандах зуны сургалтад яваад таван найзтай болсон. Тэр төлөвлөгөө бичихэд амар боловч хэрэгжүүлэхэд хэцүү гэдгийг ойлгосон.

#### 1) Асуултаар ярилцъя.

1. Мандах ямар, ямар ажил төлөвлөсөн бэ?
2. Тэр төлөвлөсөн зүйлээ хэрэгжүүлж чадаагүйн учир нь юу вэ?
3. Төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд яах ёстой вэ?

Зорилго маань юу билээ гэж бодох хэрэгтэй.  
Зорилгоо биелүүлэхийн тулд төлөвлөгөө хийнэ.

### Бодох зүйл:

Хийсэн төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд өөрөө хичээх хэрэгтэй.

### 2) Хоёр хүүхдийн тухай уншаад, ялгааг тайлбарлая.

(А) Уйдсан хүүхэд

(Б) Зорилготой хүүхэд

- 1) Зорилготой төлөвлөгөөтэй нь аль вэ?
- 2) Яагаад тэгж бодож байна?



Юу хийе дээ?  
Уйдаад байх юм

Юу хийе дээ?  
Өнөөдрийн төлөвлөж  
бодсоноор бол би цаасаар  
цэцэг хийх ёстой.





Найзуудтайгаа тоглодог юм бил үү? Хичээлээ хийх үү? Юу хийх вэ?

Яагаад гэвэл би цаасаар олон дүрс хийж сурахыг хүсдэг. Цаасаар хийсэн бүтээлээрээ сургууль дээрээ үзэсгэлэн гаргана.



Хичээл тарснаас хойш 3 цаг өнгөрчээ. Би байн байн орж гарч, нэг сууж, нэг босож сэлгүүцсээр ийм цаг өнгөрснийг мэдээгүй гэж үү?

7 хоногийн төлөвлөгөө хийдэг. Миний аав надад тусалдаг.



Хичээлээ хийх үү, өвөөтэй ярих уу? Зурах зурах уу? Хэсэг бодов. Цаг харвал дахиад л 2 цаг дэмий өнгөрчээ.

### 3 Зорилгоо сайн бодоод, хийхийг хүссэн зүйлээ бичиж үзэцгээе.

- |                              |                             |
|------------------------------|-----------------------------|
| 1) Юуг хүсэж мөрөөдөж байна? | - Зорилгоо бичнэ.           |
| 2) Мөрөөдөлдөө яаж хүрэх вэ? | - Юу хийхээ төлөвлөж бичнэ. |
| 3) Хэзээ, яаж хийх вэ?       | - Яаж хэрэгжүүлэхээ бичнэ.  |

### 4 Төлөвлөхөд заавал бичих зүйлүүд юу вэ?

Зорилго

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

### Төлөвлөгөөнд өөр юу оруулж бичвэл зүгээр вэ?

- Юуг илүү сурмаар байна, юуг сайн хийж чаддаг болмоор байна, бусдын сайн сайхны төлөө юу хиймээр байна гэдгээ бодож бичнэ.
- Бас өөрийнхөө сул талыг засахын тулд юу хийхээ төлөвлөж болно.

Сурмаар байгаа зүйл

- Цаасан урлал хийх тухай ном унших
- Цаасаар шувуу, машин хийж сурах

Бусдын төлөө хийх ажил

- .....
- .....

Илүү их хичээж хийх ажил

- .....
- .....

5 Энэ төлөвлөгөөг гүйцээж бичье.

зорилго	хийх ажил	хугацаа
цаасан урлал хийж сурах бас найздаа сайн сэтгэлээр ханддаг болох	цаасан урлал хийх тухай ном унших	энэ долоо хоногт
.....	.....	.....
.....	.....	.....



Зорилгоо биелүүлэхийн тулд яах ёстойг бодъё.

Надад өдөр бүр заавал хийх гурван чухал ажил бий гэж бодож байвал дараах байдлаар бичиж болно.

- Хичээл хийх
- Спортоор хичээллэх
- Бусдад сайн хандах
- \* Ном унших
- \* Дугуй унаж сурах
- \* Өөрийнхөө тухай тунгаан бодох



АЛДААГҮЙ ЗӨВ БИЧИЦГЭЭ

Ямагт эгшигтэй бичигддэг 7 гийгүүлэгч:

М	Н	Г	Л	Б	В	Р
ахмад	эмнэг	үлгэр	хэвлэл	самбар	үзвэр	аврал
хайлмаг	зөгнөл	энгэр	урлаг	бөмбөр	загвар	төгрөг
засмал	хэвнэг	бүргэд	урлал	элбэг	гүрвэл	цацраг
хоормог	эхнэр	тэнгэр	бяслаг	бөмбөг	үйлдвэр	мэдрэл

1) Үргэлж эгшигтэй бичдэг 7 гийгүүлэгчтэй үгийг олж өг.

- 1) Үг бүрийн балархай эгшгийн үүргийг тайлбарла.
- 2) Өгүүлбэрийг уншаад, алдаатай бичсэн үгийг зөв болгож бичье.

Надд олон хүсл мөрөөдл байна. Гэхдээ хүсэл мөрөөдлөө яаж биелүүлэхээ бодох хэрэгтэй. Энэ жил би цаасан урллаа сайн хийж сурна. Харин дараа жил сургууль дээрээ “Миний шувуу нисэх болно” гэсэн нэртэй цаасан урллын үзэсгэлн гаргана. Хийх ажлын дарааллаа зөв бодох ёстой.

Би үүнийг мэдлээ.

надд, хүсл, мөрөөдл, урллаа, урллын, үзэсгэлн эдгээр үгэнд байгаа «-д» заримдаг гийгүүлэгч, «-л», «-н» эгшигт гийгүүлэгч эгшиггүй байгаа нь буруу байна. Ер нь «м,н,г,л,б,в,р» гэсэн эгшигт гийгүүлэгч нь ямагт эгшигтэй бичигддэг шүү дээ. Бас заримдаг гийгүүлэгчийн дараа орсон заримдаг гийгүүлэгч заавал эгшигтэй бичигдэнэ.

Тэгвэл эдгээр үгэнд “-ы, -ий, -ын, -ийн, -ыг, -ийг” нөхцөл залгавал балархай эгшгийг бичих болов уу?

Надад асуулт байна.

2) Нөхцөлийг залгаж бичье. Яаж бичсэнээ ярилцъя.

хайлмагийн амт



- хэвнэг... өнгө
- үлгэр... баатар
- сэвлэг... үнэр
- самбар... алчуур
- гүрвэл... зулзага
- аврал... зар

ахмадыг хүндлэх



- эмнэг + ийг .....
- энгэр + ийг .....
- хэвлэл + ийг .....
- бөмбөр + ийг .....
- үзвэр + ийг .....
- цацраг + ийг .....

3) Төлөвлөгөөгөө цэгцэлж, алдаагүй бичье.

Зорилго	Хийх ажил	Хугацаа
цаасан урлал хийж сурах бас найздаа сайн сэтгэлээр ханддаг болох	цаасан урлал хийх тухай ном унших	энэ долоо хоногт
	цаас нугалж шувуу, цэцэг, машин хийж сурах	1 улиралд
	найздаа уншсан номоо ярьж өгч, цаасаар шувуу хийхийг зааж өгөх	11 сард

4) Би ямар хүн болох билээ. Зорилгоо эхлээд бичье. Зорилгоо биелүүлэхийн тулд энэ жилийн төлөвлөгөө хийе.



## ТӨЛӨВЛӨГӨӨ БИЧЭЭД БУСДАД ТАНИЛЦУУЛЪЯ

### 1 Яаж хийхээ бодож 1 жилийн төлөвлөгөө зохиоё.

- Зорилгодоо хүрэхийн тулд юу юу хийхээ бичье.
- Хэзээ хийх нь зөв болохыг бодож бичье.
- Төлөвлөгөөгөө яаж хэрэгжүүлэхээ ч бичиж болно.

### МИНИЙ ЗОРИЛГО

Цаасан урлал хийж сурах бас найздаа сайн сэтгэлээр ханддаг болох

Сурмаар байгаа зүйл

.....

Бусдын төлөө хийх зүйл

.....

Илүү сайн сурах зүйл

.....

### 2 Танилцуулахдаа яаж ярихаа сайн бодоод, гэр бүлдээ ярьж өгье.



Миний зорилго бол ..

.....

Тод чанга  
дуугаар хэлнэ.



Энэ зорилгодоо хүрэхийн  
тулд ..... сурна.

Баяртай байгаагаа  
харуулж хэлнэ.



.....

.....

Биелүүлж чадахаа  
харуулж хэлнэ.



.....

.....

Бага зэрэг итгэлтэй  
байдлаар хэлнэ.

# 3

## ТООЧИН ЖАГСААЖ БИЧИЖ СУРЪЯ



Зарим нэг таних тэмдгийг сайн мэдэх билүү

Ямар зүйлийг тоочин жагсааж бичих юм бэ?

### ТАНИХ ТЭМДГИЙГ ОЙЛГОН ТАЙЛБАРЛАЖ, ЗӨВ ХЭРЭГЛЭЕ.

Таних тэмдэг, шошгыг тоочин жагсаах аргаар бичиж сурна  
 Номын тэмдэглэл бичиж сурна  
 Алдаагүй зөв бичнэ





## ШОШГОНЫ ТАЙЛБАРЫГ НӨХДӨДӨӨ ОЙЛГУУЛАН, ЯРЬЖ ӨГЬЕ

### 1 Эхийг уншиж ярилцъя.

#### Ээжийн цамц


Нэгэн өдөр Сувдаа охины ээж ажил ихтэй байсан болохоор цамцаа угааж чадалгүй ажилдаа явсан байв. Тэр цамц ээжийнх нь хувцасны дотроос хамгийн гоёмсог нь байлаа. Сувдаа ээждээ туслахаар цамцыг угаав. Угаалгын машинд хийн угааж, хэцэн дээр тохлоо. Оройхон цамцаа үзтэл дүүд нь таарахаар жижиг болсон байв. Ээж удахгүй ажлаасаа ирнэ. Сувдаа охин сандран, цамцыг авч индүүдэн сунгаж татсан боловч том болсонгүй. Хаалга тогшив. Тэр ээжээсээ айгаад цамцаа нууж орхижээ.

#### 1) Асуултаар ярилцъя.

- |  |   |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> <li>• Сувдаа ээжийнхээ цамцыг яагаад угаасан бэ?</li> <li>• Цамцыг яаж угаасан бэ?</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Чи яаж угаах вэ?</li> <li>• Цамцан дээр чинь ямар нэгэн тэмдэг байдгийг мэдэх үү?</li> </ul> |
|--|---|

### 2 Хувцасныхаа шошгыг уншиж ойлгоё.

- Шошгон дээр ямар, ямар тэмдэг байна вэ?
- Дээр нь байгаа тэмдгүүд ямар хэрэгтэй вэ?



#### 1) Энэ тэмдгүүдийн аль нь бидний хувцасны шошгон дээр байгааг найзтайгаа ярилцъя.

### 3 Илүү сайн ойлгохын тулд «Хувцас арчлах таних тэмдэг» -ийг уншиж ямар утгатайг мэдье.

#### Хувцас арчлах таних тэмдэг

Баяр эгчээсээ сурсан индүүний тайлбарыг Алимаад зааж өгчээ. Харин хувцасны таних тэмдгийг шошго гэж нэрлэдэг юм байна.

- |  |                              |  |                                |
|--|------------------------------|--|--------------------------------|
|  | Цайруулагч хэрэглэж болно.   |  | Индүүдэж болно.                |
|  | Хими цэвэрлэгээнд өгч болно. |  | Индүүдэж болохгүй.             |
|  | Өлгөж хатаана.               |  | 110 хэмийн халуунаар индүүднэ. |
|  | Усны халуун нь 30 хэм байна. |  | 150 хэмийн халуунаар индүүднэ. |
|  | Гараар угаах ёстой.          |  | 200 хэмийн халуунаар индүүднэ. |


#### Өгүүлбэрүүдийн төгсгөл ямар байна вэ?

Таних тэмдэг бүр нь утгатай. Тэр утгыг тоочин жагсааж бичдэг юм байна.

4 Тайлбарыг дэвтэртээ бичээд, таних тэмдгийг зуръя.

- Ах 30 хэмийн халуун усанд угаана. ....
- Өлгөж хатаав. ....
- 150 хэмийн халуун индүүгээр индүүднэ. ....

5 Таних тэмдгийн дугаарыг тайлбарт тохируулан бичье.



Индүүдэж болно.

Индүүдэж болохгүй.

200 хэмийн халуунтай индүүгээр индүүднэ.

3

110 хэмийн халуунтай индүүгээр индүүднэ.

Хими цэвэрлэгээнд цэвэрлэж болно.



ШОШГОНЫ ТАНИХ ТЭМДГИЙГ ЗӨВ ОЙЛГОЖ ХЭРЭГЛЭЭ

1 Цамцаа зөв угаах аргыг уншаад ярилцаарай.

Цэвэрч хүү

Болдоо цамцныхаа шошгоны тайлбарыг сайн мэддэг учраас өдөр бүр цамцаа угаадаг. Түүний хичээлдээ өмсдөг цагаан цамц дээр тэмдэг бий. Тэр цамцаа 30 хэмийн усанд угаадаг. Түүний цамцаа угаадаг дараалалтай танилцъя.

- Усанд угаалгын нунтгаа хийж сайн уусгадаг.
- Цайруулагч бодисыг хэмжиж хийдэг.
- Сайтар хутгадаг.
- Дараа нь цамцаа хийдэг.
- Усанд 30 минут байлгаад угаадаг.
- Угааж, мушгиад, сэгсэрч гаргадаг.
- Хамгийн сүүлд нь цэвэр усаар зайлдаг.



Бүх өгүүлбэр ижил төгсгөлтэй байна аа даа?

Болдоо цамцаа дандаа ингэж угаадаг болохоор цамц нь байнга цэвэр байдаг юм. Ангийнхан нь түүнийг “Цэвэрч хүү” гэж хэлдэг.

2 Чиний цамцан дээр дараах тэмдэг байгаа тохиолдолд цамцаа яаж угаах дарааллыг бичээрэй.





- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....
- 5.....



## ШОШГО, ЗААВРЫГ ЗӨВ ОЙЛГОЖ ХЭРЭГЛЭЭ

1) Таних тэмдгийг уншиж, тайлбарыг тоочин жагсааж бичье.



Хонгорзул ингэж бичжээ.



Би энэ тэмдгийг тайлбарлаж өгье. Ма нарын өмссөн аль нэг хувцасны шошгонд индүүг тэмдэглэсэн шиг тэмдэг байгаа бол 200 хэмийн халуунтай индүүгээр индүүдэж хэрэглэнэ. Индүүн дээр нэг цэг байвал 110 хэм, хоёр цэг байвал 150 хэмийн халуунтай индүүгээр индүүднэ гэсэн үг.



2) Таргийг уухын өмнө эндээс ямар мэдээлэл авч болох вэ?

- 1) Орц, найрлагыг яаж бичсэн байна вэ?
- 2) Орц найрлагыг хуулж бичье.



3) Тарагны ач холбогдлыг яаж мэдэх вэ?

- 1) Тараг тохиромжтой эсэхийг хайрцаг дээрээс нь мэдэж болох уу?

4) Чи өөрийнхөө хувцаснуудын шошгыг үзээрэй. Таних тэмдэг бүрийг зураарай. Тэдгээрийн утгыг тоочин жагсааж бичээрэй.



## НОМЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧИЖ СУРЦГААЯ

### 1 Эхийг уншаад, юу мэдсэнээ найзтайгаа ярилцаарай.

1) *Номын тэмдэглэл яаж хийдгээ бусадтай хуваалцъя.*

#### Уншлагын түүх болно

Ном уншсан бол чамд юу үлддэг вэ? Уншсанаа тэмдэглэж сурах нь нэг ёсондоо чиний “Уншлагын түүх” болно. Тэгвэл яаж тэмдэглэл хөтлөх вэ?

- ✓ Яг юуны тухай байсныг
- ✓ Юуны талаар ятган ойлгуулсныг
- ✓ Юуг тайлбарласныг
- ✓ Ямар үйл явдалтай байсныг гэх зэргээр өөр, өөрөөр бичиж болно.

Тэмдэглэл хийхдээ дараах зүйлийг бодоорой.

Зохиогчийн анхны ном уу эсвэл ийм төрлөөр байнга бичдэг үү? Хэрэв бичдэг бол төстэй өөр номыг нь олж уншаарай. Энэ номыг бусдад санал болгож болно.

Чухал санагдсан өгүүлбэрийг бичдэг тусгай дэвтэртэй байж ч болно. Номын тэмдэглэл хийх арга олон янз. Чиний бичсэн номын тэмдэглэл нь “Уншлагын түүх” чинь болно. Номын тэмдэглэлээ товч, тодорхой, тоочин жагсааж бичээрэй.

### 2 Номын тэмдэглэл хийх аргыг мэдье.

#### Номын тэмдэглэл - 1

Баатруудын хийсэн үйл, хэлсэн үгээр хөөн бичиж болно.



#### Номын тэмдэглэл - 2

Номд юуны тухай байсныг бичиж болно.

Зохиогчийн тухай

Номын агуулга

Энэ ном чамайг ямар нэг зүйлд ятгасан уу?

Ямар нэг юм, үйл явдлын тухай тайлбар өгсөн үү?

Баатруудын үйл явдлыг өгүүлсэн үү?

### Номын тэмдэглэл - 3

- Зохиолын баатрууд, гол дүр зэргийг тэмдэглэж болно. Тэдний нас, төрх байдал, санаа бодол, хийсэн үйл хөдлөл, үг яриа зэргийг товч бичиж болно.
- Утгыг нь сайн мэдэхгүй үгийг бичиж тайлбарыг тэмдэглэж болно. Номын хэсэг бүрд юуны тухай байгааг бичиж болно.

### Номын тэмдэглэл - 4

Уншсан номын нэр, бүтэц	Баатруудын үйл явдал, үг ярианаас чухлыг нь	Яагаад чухал санагдсан	Зохиогчоос асуух асуулт
.....	.....	.....	.....

### Зохиогчийн тухай бичиж болно.

- Өөр ямар, ямар ном бичсэнийг судлах
- Асуух зүйлийг тэмдэглэх
- Ойлгохгүй үг хэллэг, үйл явдал, газар орны нэр зэргийг бичиж ч болно шүү дээ.

Номын тэмдэглэлд бүгдийг бичих боломжгүй. Тэгвэл яаж бичих вэ? Товч тоочиж, жагсааж бичиж болно.

### 3 Уншсан номынхоо тухай сонирхолтойгоор бичээрэй.

1) Номын хуудас зузаан байсан уу? Хэрэв нимгэн болгоё гэвэл юуг нь хасмаар байв?

.....

.....

.....

.....

2) Номын хуудас нимгэн байсан уу? Хэрэв зузаан болгоё гэвэл ямар үйл явдал нэммээр байв?

.....

.....

.....

.....

### Ном унших чухал гэж үү?


Амжилттай хүмүүсийн зарим жишээг хар даа.

**Жишээ 1:** Франклины өөрийгөө хөгжүүлэх байнгын ажил нь ном унших байлаа. Ном авах мөнгөгүй байхдаа тэрээр бусадтай хамтрах санаа төрж бусад хүмүүсийг ятгасны дүнд мөнгөө нийлж номоо худалдан аваад ээлж дараалан уншдаг байв. Энэ санаа нь гэрээр уншлагад ном өгдөг хамгийн анхны үндэсний номын санг байгуулахад хөтөлсөн аж. (*“Америк хүн бүр үүнийг мэднэ” өгүүллээс*)

**Жишээ 2:** Хичээлийн эхний өдөр ангид хүлээгээд сууж байв. Багш тор дүүрэн ном барьж орж ирээд ширээн дээр давхарлан тавихад мухар дэлэм хэртэй өндөр харагдав. “Энэ улиралд эдгээр номыг уншиж барахгүй гэж бодож байгаа хүн байна уу?” гэв. Багш над руу ёжтой инээмсэглэх шиг болов. Намайг сурч чадахгүй гэж бодоогүй байгаа даа. Тэгэх ч үгүй шүү. Бүх номыг уншина аа гэсэн бяцхан аархал төрөв. Багшийн хэлсэн бүх номыг уншлаа. Ингэж би түүхийг гүнзгийрүүлэн судалсан юм. (П.Наранбаяр)

- 4 Сурагч болоод гуравхан жил болж байгаа ч уншсан номынхоо тухай тэмдэглэл хөтөлдөг хүүхэд олон бий. Тэдний тэмдэглэлээс сонирхъя.

**Билгүүний хийсэн номын тэмдэглэл.**



**Номингийн хийсэн номын тэмдэглэл.**

“Бодит амьдралын түүхүүд” П.Буяндэлгэр УБ., 2014

*Хэр удаан амьдрах нь гухал уу, хэрхэн яаж амьдрах нь гухал уу.  
Энэ ном бол алдартай хүмүүсийн л тухай юм. Тэгдээ тэд яаж амжилтад хүрснийг мэдэх боломжтой.*

*Тэдэн шиг амжилтад хүрэх боломж нагд ь байгааг би ойлгосон.*

*Харин энэ номыг уншилтуут монголынхоо алдартнуудыг судлах сонирхол төрсөн шүү.*



## ХООЛНЫ ЖОРЫГ ЯАЖ БИЧДЭГ БОЛ?

### 1 Монгол үндэснийхээ хоол хүнсний тухай уншиж мэдье.



Их даарсан үед махан хоол идэх ч аятайхан шүү. Өвлийн цагт бүхэл мах, бууз, хуушуур, бантан, будаатай шөл, гурилтай шөл гээд мах ихтэй хоол иддэг. Харин миний дүү шиг жаахан хүүхдүүд бол бантан, бас будаатай шөл, гурилтай шөл иднэ дээ.

Эмээ өвөө маань ядарсан үедээ олгойн шөл, битүү шөл, битүү чанасан толгой зэрэг хоол хийж иддэг. Банштай цайг сүү, мах, гурилтай болохоор цай гэх үү, хоол гэх үү, би гайхдаг юм аа. Чи юу гэж бодож байна.

1. Уншаад ойлгосноо ярилцъя.
2. Монгол үндэсний махан хоолонд ямар, ямар хоол ордог вэ? Бүтэн өгүүлбэрээр хариулж бичье.
3. Ядарсан үедээ яагаад битүү хоол иддэг вэ?
4. Битүү хоолны нэрсийг алдаагүй зөв хуулж бичье.

### 2 Сайн ойлгохын тулд мэдэхгүй үгийнхээ утгыг тайлбарлая.

- 1) Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай уншъя.
- 2) Үгийн утгыг өөрийнхөө ойлгосноор бичье.
- 3) Өөрийнхөө бичсэнийг толь бичигт байгаа утгатай харьцуулан ярилцъя.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
Бүхэл мах	.....	хэрчиж жижиглээгүй мах
Олгойн шөл	.....	хонины гэдэсний шувтрах хэсэгт хэрчиж амталсан мах хийж битүү чанаж болгосон хоол
Битүү шөл	.....	хэрчиж амталсан махыг аяганд хийж гурилаар битүүлэн чанасан шөл
Битүү чанасан толгой	.....	.....

- 4) Утгыг мэдсэн бол үгээ оролцуулаад өгүүлбэр зохиож бичье.

Хонины толгойг битүү чанагч юм уу, эсвэл саванд хийж битүүлэн чанадаг.

3 Хоёр хүүхдийн яриа нь ямар хоолны тухай байгааг уншиж мэдье.



Чиний шүд гоё цагаан өнгөтэй юм аа.



Тийм үү. Би цагаан идээ их иддэг болохоор л ийм гоё цагаан шүдтэй болсон байх. Сүү, ааруул, бяслаг, өрөм, эззгий, хайлмаг, шар тос, хоормог, аарц гээд л бараг бүгдийг нь идэх дуртай.

Аа мэдлээ, мэдлээ. Би ч гэсэн байнга цагаан идээ идээд байвал илүү цагаан шүдтэй болох нь байна шүү дээ.



Монголчууд зуны цагт цагаан идээгээр хооллодог. Махан хоол бараг хэрэглэдэггүй байсан гэнэ лээ. Бас айраг гэж биед сайн ундаа байдаг.



Яагаад дан цагаан идээ иддэг юм бол оо. Цагаан хоол идэх нь чухал юм аа даа.

Чанартай сайн хоол шүү. Гэдэс дотрыг эрүүл болгодог.

1. Цагаан хоолонд юу, юу ордгийг нэрлэе.
2. Жагсааж бичье.

4 Монгол үндэсний хоол хүнсний талаар тайлбарлан ярилцъя.

1) Махан хоол, цагаан хоолны ялгааг бичье.

Махан хоол	Цагаан хоол
.....	.....

2) Цагаан идээгээр хооллохын ач тус юу вэ?

3) Хүүхдүүдийн асуусан асуултад хариулж бичье.



Ямар хоолыг махан хоол гэдэг вэ?  
.....

Ямар хоолыг цагаан хоол гэдэг вэ?  
.....



Монгол үндэсний хоолыг махан хоол, цагаан хоол гэж хоёр хуваадаг.





## ХООЛНЫ ЖОР ЗОХИОХДОО ТООЧИН ЖАГСААЖ БИЧИЦГЭЭ

### 1 Хүснэгтэд байгаа мэдээллийг уншиж ойлгоё.

- 1) Мэдээллээс ойлгосноо найзтайгаа ярилцъя.
- 2) Яаж бичсэнийг тайлбарлая

№	Товчилсон үг	тайлбар
1	ц/х	цайны халбага
2	х/х	хоолны халбага
3	1/4	дөрөв хуваасны нэг
4	ц/х 1/4	цайны халбагаар дөрөв хуваасны нэг
5	г	грамм
6	кг	килограмм
7	ш	ширхэг

Хоолны жоронд юу, юу орсныг өгүүлбэрээр бичээгүй байна. Харин юу, юу орохыг тоочин жагсааж бичсэн байна.

№	Орц	Хэмжээ
1	Хонины мах	100 г
2	Гурил	90 г
3	Сонгино	20 г
4	Хар чинжүү	ц/х 1/4
5	Давс	ц/х 1/3
6	Ус эсвэл ясны шөл	800 г



### 2 Эхийг уншиж ойлгоё.

#### Монгол үндэсний уламжлалт шөлтэй хоол



Монгол үндэсний уламжлалт шөлтэй хоолны нэг нь битүү шөл юм. Битүү шөлийг нэг хүний жороор бэлдэхэд хонины мах 180 грамм, гурил 60 грамм, бөөрөнхий сонгино 15 грамм, ногоон сонгино 5 грамм, давс цайны халбагаар 1/2, ургамлын тос цайны халбагаар 1, ясны шөл 400 г орно. Битүү шөлийг хийхдээ махаа нимгэн хярж, сонгиноо тал цагариг хэлбэртэй хэрчинэ. Гурилыг бүлээн усаар зуурч, нухаж амраагаад нимгэн дугуй элдэнэ.

Аяганд ясны халуун шөл хийж, дараа нь хэрчсэн махаа, давс, хар чинжүү бусад амтлагчаар амтлан, нимгэн элдсэн гурилынхаа нэг талыг тосолж, тослоогүй талаар

нь шөл хийсэн аягыг бүтээж жигнүүрт 20 минут жигнэнэ.

Аяган шөл гэж бас нэрлэдэг. Битүү шөл нь ядаргаа тайлж, хүч тамир оруулдаг шингэц сайтай хоол юм.

- 1) Энэ эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
- 2) Битүү шөлөнд юу юу ордог вэ?

**3) Битүү шөлний жор болон хийх аргыг ялган бичье.**

№	орц	хэмжээ
1	мах	180гр
....	.....	.....
....	.....	.....
....	.....	.....

Тоочин жагсааж бичнэ шүү дээ.

**Битүү шөл хийх арга**  
 Махаа нимгэн хярна  
 .....  
 .....  
 .....

**4) Хуушуурын жорыг мэдэхийн тулд уншиж ойлгоё.**

**Ингэж хийвэл**

Аз жаргалыг мэдрүүлэх амттай хуушуур хийж сурмаар байна уу? Тэгвэл жорыг нь л зохиож чаддаг байхад хангалттай. Гурил, мах хоёроор л хуушуур хийдэг гэж үү? Илүү амттай болгохын тулд яаж хийдгийг жороос мэдье.

<b>Гурилын зуурмагт:</b>		<b>Маханд:</b>	
Гурил	450гр	Татсан мах	450гр
Давс	5гр	Сонгино	100гр
Сүү	250мл	Тараг	80гр
		Давс, перц	амталгаагаар
		Өндөг	1ш

**Хийх арга:** Сүүндээ давс хийж хутгана. Дээр нь гурилаа бага багаар нэмж зуурна. Зуурмагаа гялгар уутанд бооно. Хөргөгчинд 30 минут амраана.

Махаа сонгино, тараг, өндөг болон давс, перцээр амтална. Амраасан гурилаа 12 тэнцүү хэсэгт хуваана. Гурилаа элдэнэ. Гурил дээрээ тааруулан махаа тавьж бэлтгэнэ. Амсрыг нийлүүлэн чимхэнэ. Хуушуураа тосонд шарна эсвэл шарах шүүгээнд жигнэнэ.



**Тоочин жагсаасныг яаж мэдэх вэ?**

**Өгүүлбэрүүд -на<sup>4</sup> гэсэн адил төгсгөлтэй байна.**

- 1) Тэгвэл жорыг яаж бичсэнийг тайлбарлаарай.



## ҮЙЛИЙГ ТООЧИН ЖАГСААЖ БИЧИЦГЭЭ

### 1 Хуушуур хийх аргад байгаа үйл үгийг түүж бичээрэй.

**Хийх арга:** Сүүндээ давс хийж хутгана. Дээр нь гурилаа бага багаар нэмж зуурна. Зуурмагаа гялгар уутанд бооно. Хөргөгчинд 30 минут амраана.

Махаа сонгино, тараг, өндөг болон давс, перцээр амтална. Амраасан гурилаа 12 тэнцүү хэсэгт хуваана. Гурилаа элдэнэ. Гурил дээрээ тааруулан махаа тавьж бэлтгэнэ. Амсрыг нийлүүлэн чимхэнэ. Хуушуураа тосонд шарна эсвэл шарах шүүгээнд жигнэнэ.

Тухайн хоолонд орох бүтээгдэхүүний нэрийг тоочин жагсааж бичдэг. Бас яаж хийх аргыг бичихдээ ямар, ямар үйлийн дарааллаар хийхийг бодож үйлийг тоочин жагсааж бичдэг.

### 2 Шөл ба хуурганы хийх дарааллыг уншаарай.

1) Хоёр эхээс хийх дарааллын дагуу үйлийг түүж бичээрэй.

Жишээ нь: а хэрчинэ

чанана

.....

б чанана

халаана

.....

#### а Загас, бяслагтай шөл

Төмсөө дундаж хэмжээтэй хэрчинэ. Гал дээр болтол нь чанана. Төмс чанасан усандаа бяслагаа хийнэ. Загасаа жижиглэж хэрчинэ. Шөлөндөө загасаа хийнэ. Загасаа болтол нь буцалгана. Галыг нь унтраана. 5 минут байлгана. Тавагласны дараа дээрээс нь укропноос цацна.







#### б Мөөгний шанзтай нарийн махан хуурга

Гоймонгоо усанд чанана. Хайруулын тавгаа халаана. Цөцгийн тосхийнэ. Мөөг, сонгиноо хийнэ. Зөөлөн галаар шарна. Дараа нь өөр саванд хийнэ. Бэлдсэн шөлөндөө бага зэрэг гурил нэмнэ. Тэгээд хутган өтгөртөл нь буцалгана. Дээрээс нь зөөхий, сонгинотой мөөгөө хийнэ. Давс болон перцээр амтална. Гоймонгоо таваглана. Мөөгтэй махны соусаа дээрээс нь хийнэ.



- 3 Дараах зургуудыг сайн ажиглаад, зөв дараалалд оруулаарай. Яаж хийх үйлийг тоочин жагсааж бичье.

### Гурилтай шөл хийх дараалал



- 4 Жорыг ашиглан, гурилтай шөл хийх дарааллыг жагсааж бичье.

№	Орц	Хэмжээ
1	Хонины мах	200г
2	Гурил	200г
3	Төмс	200г
4	Ногоон сонгино	15г
5	Бөөрөнхий сонгино	20г
6	Лууван	15г
7	Давс	ц/х 1/3
8	Ус	450г

#### Гурилтай шөл хийх дараалал:

1. ....
2. ....
3. ....
4. ....

Тоочин жагсааж бичихдээ ЮУ ЮУ гэдгийг дэс дараалалтай бичсэн байна. Бас хийх аргыг ЯАХ ЯАХ гэсэн асуултаар дарааллуулан бичсэн байна. Энэ нь хийхэд хялбар, уншигчдад ойлгомжтой юм.



## АЛДААГҮЙ ЗӨВ БИЧИЖ СУРЦГААЯ

### 1 Эхийг уншиж ойлгоё.

#### Өрөм

Түүхий сүүг аргалын зөөлөн галаар хөөрүүлбэл сайн. Хорголын гал ширүүддэг. Дараа нь галаа цогшуулан, сүүгээ сайтар самарна. Цог нь удаан төөнөвөл дарайсан шаргал өрөм загсана. Хэрэв ширүүн галаар сүүгээ хөөрүүлбэл сүү түлэгдэн, өрөм сайхан загсахгүй.

1) *Найзаасаа асуух асуулт зохиоё.*

### 2 Онцолсон үгсийг ялгаж бичээд ажиглая.

Би үүнийг мэднэ.

**аргал, хоргол, шаргал** гэдэг үгс нь 2 үетэй байна. Хоёрдугаар үед нь “ – га, -го” орсон байна.

«хорголын» гэж бичсэн байна. Тэгвэл **аргал, шаргал гэсэн** үгсэд «– ын, - ыг» залгаж бичвэл яаж бичих юм бол? Адилхан бичих юм уу?

Надад асуулт байна

Би үүнийг мэдлээ.

«**аргалын, хорголын, шаргалын**» гэж бичнэ шүү дээ. Эдгээр үгийг харвал «г» гийгүүлэгчийн дараа орсон «а, о» богино эгшгүүд нь ялгах бас эгшигжүүлэх хоёр үүрэгтэй учраас гээж болохгүй юм байна.


Дараах үгсийг холбож зөв бичье.

1) *Эдгээр үгийн утгын ялгааг ярилцъя.*

сан - сана  
зөн - зөнө

он - оно  
хон - хоно

2) *Зөв холбон бичье.*



- 1) *Бичсэнээ шалгая.*
- 2) *Найздаа тайлбарлан хэлж өгье.*

“н” - гийгүүлэгчийн дараа орсон богино “а, о, ө, э” эгшгүүд ялгах үүрэгтэй тул гээхгүй бичнэ.



**ҮГИЙН УТГЫГ МЭДЭХ НЬ ЗОХИОЛЫГ ОЙЛГОХОД ХЭРЭГТЭЙ ШҮҮ ДЭЭ.**

Шүлгийн утгыг мэдэрч мэдрэмжээ илэрхийлэн уншиж сурна  
Шүлгийн хэлбэрийг дуурайн бичиж сурна  
Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн бичиж сурна




## УНШИЖ ОЙЛГОХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ

1 Төл мал яаж дуугардаг вэ? Ярилцаад, зөв холбож бичье.

- |          |             |
|----------|-------------|
| 1. Ботго | а. майма    |
| 2. Хурга | б. янцгаана |
| 3. Ушиг  | в. майма    |
| 4. Унага | г. мөөрмө   |
| 5. Тугал | д. буйма    |

2 “Бяцхан найз” зохиолд ямар найзуудын тухай гарах бол ярилцъя.

Загварын дагуу хурдан унших дасгал хийе.



### Бяцхан найз

(Өгүүллэг)

1.

Хотоос ирсэн жаахан охин Сувдааг гадаа гарахад, бяцхан цагаан ботго аргамжааны гадсаа тойрон алхахдаа жингэнэтэл “уйлж” байв. Сувдаа нүдээ бүлтийлгэн гайхан зогсов.



Чи яагаад уйлаад байгаа юм бэ?

гэж нарийхан дуугаар бас л жингэнүүлэн асуув. Ботго түүнийг хараад толгойгоо сэгсэрлээ.

Зураг	Үг	Толь бичигт байгаа утга
	аргамжаа	малыг тогтооход хэрэглэх гадаснаас уясан сур, дээс

3 Сувдаа охин цаашид юу гэж хэлснийг төсөөлөн бодож уншъя.

2.

“Аа мэдлээ, мэдлээ. Чи уйлаагүй дуулж байгаа юм уу? Майлаад ч байгаа юм уу?” гэж уянгалуулан дуулах мэт асуулаа. Ботго толгойгоо бас л сэгсчин, гадсаа тойрон өөвөг сөөвөг алхална.


“Хүүе, бүжиж байна!” гээд Сувдаа “ход ход” инээв. Гараараа зааж дэвхцэв.

Ботго түүнийг ажин харж, толгойгоо гудайлган зогслоо.

Чи дүрсгүйтээд уяулчихсан уу? Над шиг томоотой байх хэрэгтэй!

гэж Сувдаа хэлэв. Ботго дахиад л уйлав.

Түүнд яаж тус хүргэх вэ? «Нулимсаа арч» гэж алчуураа өгөх үү! гэж бодлоо.



4 Тэд юу, юу хийснийг бичиж үзье. Ярилцаад хоёрдугаар баганад нөхөж бичээрэй.

Ботго	Сувдаа
Аргамжаагаа тойрч алхсан	Аав нь юу гэж захисныг бодсон.
Жингэнэтэл уйлсан	
Толгойгоо сэгсэрсэн	
Гадсаа тойрон алхсан	
Толгойгоо гудайлган зогссон	

3.

Тэгээд “Аав минь, намайг хөдөө явахад юу гэж захилаа даа. Эмээ ээжидээ тустай, малд хайртай байгаарай!” гэсэн шүү дээ. Яагаад тэгж байгаа юм бэ? гэж асуухад: “Малд хайртай байвал сүү нь их гардаг юм. Чи сүү, тараг, ааруулд ухаангүй дуртай шүү дээ” гэсэн. Аав ийм их юм ярьсан мөртлөө бяцхан цагаан ботгоны ингэж хачин дуулдгийг надад яагаад яриагүй юм бол оо! гэж бас бодлоо.

Сувдаа ботгоны дэргэд очмоор санагдав. Тэгээд “Юу гэж асууя даа” гэж нэг хэсэг гайхан зогсоноо:

“Чи юунд мөөрөөд байгаа юм бэ?” гэв. Ботго охиныг харж толгойгоо шилгээнэ.

“Үхэр л мөөрдөг болохоос биш тэмээ мөөрдөггүй шүү дээ!” гэхэд, бяцхан Сувдаа юу гэж асуувал таарах бол гэж баахан бодсоноо:

Чи яагаад майлаад байгаа юм бэ?

Еэ, хэзээ тэмээ майлж байсан юм бэ?

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
шилгээх	.....	морь мал, бие толгойгоо сэгсрэн хөдөлгөх

5 Энэ хүртэл уншаад, юу ойлгосноо бичье.


1) Үйл явдлыг дарааллаар бичье.

4.

“Манай тэнд чам шиг жижигхэн тэмээ байдаггүй. Өндөр тэмээ хааяа явдаг юм. Тэр



ээж чинь байх аа” гэхийг бяцхан ботго сонсонгоо, бас л уянгалуулан дуугарч бүлтгэр хар нүднээсээ нулимс унагалаа. Сувдаа охин бяцхан ботгоны толгойг нь илж:



Битгий уйл даа.  
Ижий чинь хаачсан юм бэ?  
Би дуудаад ирье.

Манай ижий бэлчээрт  
явсан байх. Халуун нар  
шараад ам цангаад байна.



гэхэд Сувдаа гэр лүүгээ гүйж, эмээгээсээ баахан юм асууснаа, хувинтай ус дааж ядан өргөж, ботгоны дэргэд ирээд:

“Би цөмийг нь ойлгосон, чи сонсооч! Ботго буйлна, хурга майлна, ишиг бас майлна, унага янцгаана, тугал мөөрнө, тийм ээ?” гэхэд ботго ус уунгаа, инээмсэглэх мэт хошуугаа шомболзуулан:

“Хүний хүү ийм их ухаантай байх юм. Хоромхон зуур бүгдийг мэдчихлээ. Хүн бүгдийг чаддаг. Чи над ус авчирч өглөө. Бас өвс өгнө гэсэн. Би ийм сайхан найзтай болсондоо баярлаж байна. Би дахин уйлахгүй, дандаа баяртай байна” гэжээ.

Д.Дамбийжанцан

- 1) Сувдаа охин юу мэдэж авсныг нөхдөдөө ярьж өгье.
  - 2) Төл малын тухай ойлгосноо бичье.
  - 3) Ямар учраас “Бяцхан найз” гэж нэрлэсэн бэ?
  - 4) Чамд үүнтэй төстэй явдал тохиолдож байсан уу? Найздаа ярьж өгөөрэй.
- 6) Сувдаагийн зан чанарыг юу гэж хэлж болох вэ? Зохиолоос жишээ татаж хэлээрэй.
- 7) “Бяцхан найз” өгүүллэгийн хоёр баатрын үгийг ялгаж бичээрэй.



.....  
.....  
.....  
.....



.....  
.....  
.....  
.....

- 8) Үлдсэн хэсгүүд нь хэний хэлсэн үг байх вэ?



1) Зургийг сайн ажиглая. Хурга, хүүхэд хоёр ямар холбоотойг таамаглан ярилцъя.

- 1) Шүлгийн утгыг ойлгож, цээжлээрэй. Яаж уншвал хүмүүсийн сэтгэлд хүрэх бол?
- 2) Шүлгийн мөр яаж эхэлсэн байна?

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
хэнз	.....	төрөх хугацаанаасаа оройтож төрсөн төл мал
зурвастай	.....	нарийн урт дүрс
хот	.....	мал хэвтэшлэх газар

### Миний хэнз хурга (Шүлэг)

Д.Нацагдорж

Миний хэнз хурга  
Магнай халзан зурвастай  
Мянган хонины дундаас  
Би хармагц таньдаг  
Мярс мярс майлж  
Намайг чиглэсээр ирдэг.

Дун цагаан үстэй  
Дуран хар нүдтэй  
Түмэн хонины дунд  
Түүнээс хөөрхөн амьтан үгүй  
Төрсөн хотон дотроо  
Тэр бид хоёр тоглодог.

Өвдөг юугаа сөгдөөд  
Өөрийнхөө эжийг хөхдөг  
Өвөр дээр минь гараад  
Өхөөрдмөөр өхөөрдмөөр эрхэлдэг  
Нааш цааш дэгдэн  
Малчин хүнийг баясуулдаг.

Юуны  
тухай вэ?

Энэ хэсэгт хурга,  
эзэн хоёрын холбоог  
дүрсэлсэн байна.

Энэ хэсэгт хурганы  
гадаад төрхийг  
дүрсэлсэн байна.

Энэ хэсэгт хурганы  
ааш, үйл хөдлөлийг  
дүрсэлсэн байна.

Юу мэдэрдэг  
байна.

Эзэн нь хармагц  
таньдаг учраас бие  
биедээ хайртай юм  
байна шүү дээ.

Гадаад төрхийг  
мэдэрч байна.

Өхөөрдмөөр үйл  
хөдлөлийг мэдэрч  
байна.

Хөөрхөн ааштай, эзнээ баярлуулдаг, бие биедээ хайртай  
найзынхаа тухай уншиж байгаа тул итгэлтэй, хөгжилтэй, уран  
тодоор уншина.

2 Шүлгийг цээжлээрэй. Юуны тухай байна вэ? Шүлгээс юуг мэдэрсэн бэ?

**Тугал**

/Ардын аман зохиол/

Мойл хөөрхөн нүдтэй  
Моодгор нарийхан сүүлтэй

Оодон хатган давхидаг  
Онцгой хөөрхөн ааштай  
Хулан тахийн зүстэй  
Хурдан шалмаг хөдөлгөөнтэй

Хулмайн хяран хэвтдэг  
Хөөрхөн хүрэн тугал  
Манай мал сүрэг  
Миний хайртай тугал

Гадаад төрхийг  
дүрсэлсэн.

Хөдөлгөөн, зан  
чанарыг дүрсэлсэн.

Зохиогчийн үг.

Өхөөрдөм хөөрхөн  
санагдаж байна.

Хөнгөн хөгжилтэй  
санагдаж байна.

Бахархах сэтгэл төрж  
байна.

Өөртөө итгэлтэй, баясгалантай цоглог уншиж өгнө.

3 Хайртай амьтныхаа хөдөлгөөн, зан чанарыг дуурайн бичээрэй.

4 Шүлгийг дуурайн бичих аргыг мэдье.

1

Эхлээд сэдвээ сонгон авах юм байна. Тэгээд хэлбэрийн дагуу бичих зүйлээ урьдчилан төлөвлөнө.

Гадаад  
байдал

Хөдөлгөөн

Ааш зан

Идэш  
тэжээл



2 «Тугал» шүлгээ дахин уншиж, өөрийн бичих амьтныхаа тухай төсөөлөн бодъё.

3

Төсөөлсөн зүйлээ бичихдээ «Тугал» шүлгээ дуурайлган бичнэ.

4

Бичсэн шүлгээ ангийнхандаа уншиж өгье. Тэгээд тэдний саналыг сонсъё.

5

Найз нарынхаа саналыг сонсоод, шүлгээ дахин засаж сайжруулъя.

6

Ангийнхандаа дахин уншиж, өгье.




5 “Тугал” шүлгийн хэлбэрийг дуурайн, дуртай амьтныхаа тухай бичье.

6 “Хэрэв би” шүлгийг уншихдаа цэгийн оронд үг нөхөж уншъя.

- 1) Цэгийн оронд байж болох үгийг бодъя.
- 2) Бодсон үгээ хэлээд тод дуугаар уншъя.

**Хэрэв би**

<p>Хэрэв би нар болчихвол Хэнийг <b>илчээрээ</b> ээх вэ? Гэртээ өвчтэй хэвтэж байгаа Гэрэлээ найзынхаа ..... л ээнэ Халуун жин тавивч бүлээцдэггүй Хатингар жаахан ..... нь ээнэ. Нараар ээж дулаацуулахгүй бол Найз минь хичээлдээ мөд явахгүй</p>		<p>Гэнэт би нар болчихвол <b>Гэрлээрээ</b> өөр юуг ээх вэ? Цонхны тавцан дээр тавиатай байгаа Цоморлогоо хумьсан ..... л ээнэ Хэчнээн уславч ер сэргэдэггүй Хилэн зөөлөн ..... нь ээнэ Нараар ээж эмчлэхгүй бол Найздаа барих цэцэг минь ургахгүй</p>
---	---	---

*С.Надмид*

7 Нөхөж уншсан үгийг дэвтэртээ бичье. Тэр үгэндээ асуулт зохиоё.

Нөхөж бичих үгийг мэдэхийн тулд асуулт тавьж үзэж болно. Энэ шүлэгт “ээнэ” гэсэн үгийн өмнө **юуг?** гэж асуувал утга нь тодорхой болж байна.

8 Үг нөхөхийн тулд асуулт тавьж үзье. Адилхан асуултад хариулагдах үгийг нөхөж бичээд, шүлгийг гүйцээе.

**ямар?**

Хэрэв би нар болчихвол  
Хэнийг илчээрээ дулаацуулах вэ?  
..... бяцхан дүүгээ дулаацуулна  
..... ээжийнхээ гарыг дулаацуулна  
..... ачтай эмээгээ дулаацуулна.

**ямар?**

Хэрэв би нар болчихвол  
Хэнийг гэрлээрээ гэрэлтүүлэх вэ?  
..... гэрийг .....  
..... сургуулиа .....  
..... шөнийг .....

**яхах вэ?**

9 “Хэрэв би ....” бол ямар сайн үйл хийх байсан тухайгаа бодож шүлэг зохиоё.



Хэрэв чи шидтэн бол  
хамгийн түрүүнд хэнд  
туслах вэ?

.....  
.....



**Шүлгийг дуурайн бичихийн тулд:**

- Мөрүүд яаж эхэлснийг ажиглана.
  - Мөрүүд яаж төгссөнийг ажиглана.
  - Бас сонирхолтой ямар үг хэллэг хэрэглэснийг ажиглана.
- Тэдгээрийг дуурайн бичиж болно.

10 Дараах шүлгийн утгыг ойлгож уншаарай.

**Нохойн арван араншин**

(Д.Пүрэвдорж)

Өрөөл бусдын аргадахад  
Өчиггүй ярзганах мөртөө  
Өөрийн эзний зандрахад  
Өөдөө харж тэлчилнэ.

Хоол олдсон зоргоор  
Ходоодны хорхой баярлуулж  
Хор үмхсэн хойноо  
Ховдгийн гайд гасална.

Хүртээлгүй хөрөнгөд гинжлүүлж  
Хүзүүгээ зулгалж долоолон  
Хүйтэн шөлтэй идүүрээ  
Хүнээс харамлаж архирна.

Юуны тухай вэ?

Юу мэдрэгдэж байна.

11 Дээрх шүлгийг дуурайн зохиож бичээрэй.



**ЕРТӨНЦИЙН ГУРВЫН ХЭЛБЭРИЙГ ДУУРАЙН БИЧИЦГЭЭ**

1 Дараах “Ертөнцийн гурав”-ын утгыг ойлгон, уншаад цээжилье. Ямар нэг зүйлийг сонгон авч, дуурайлган, зохиоё.

Туухад гахай нэг хэцүү \_\_\_\_\_

Туулахад тал нэг хэцүү \_\_\_\_\_

Тоолоход од нэг хэцүү \_\_\_\_\_

2 Дээрх “Ертөнцийн гурав”-аас “яах?” гэсэн асуултад хариулагдах үг хаана нь байгааг ажиглая.

3 Цэгийн оронд тохирох үйл үгийг нөхөж бичье.

1) Утгыг ярилцъя.

2) (а) ба (б) -д байгаа ертөнцийн гурав нь ойролцоо утгатай байгааг тайлбарлая.

а. Үерлэн ..... нь ус хэцүү

Дүрэлзэн ..... нь түймэр хэцүү

Эрчлэн ..... нь салхи хэцүү

яах? яах? яах?

(хийсэх, шуугих, асах)

б. Чулуун дээр ногоо ..... нэг бэрх

Усан дээр гал ..... нэг бэрх

Үхрийн эвэр дээр цас ..... нэг бэрх

яах? яах? яах?

(тогтоох, түлэх, ургуулах)

3) Дээрх хэлбэрээр ертөнцийн гурав зохион бичээрэй.

4 Ертөнцийн гурвыг гүйцээе.

1) Ойролцоо утгатай үгсээс тохирохыг нөхөж бичээд, цээжлэн тогтооё.

**Нөхөх үг:** сайхан - гоё, хурдан - түргэн,

Арван тавны сар нэг .....

Атар газрын цэцэг нэг .....

Аав ээжийн сургаал нэг .....

Салхитай тэнгэрийн үүл нэг .....

Саруул ухаантны санах нэг .....

Сайн морины давхих нэг .....

5 **Ертөнцийн гурвыг дуурайн зохиож бичье.**

Эх хүний санаа нэг цагаан

Эрдэмтэй хүний мөр нэг цагаан

Энхрий дүүгийн минь сэтгэл нэг цагаан

..... нэг цагаан

..... нэг цагаан

..... нэг цагаан

6 **Ертөнцийн гурван амрыг уншаад утгыг ойлгоорой. Дуурайн зохиож бичээрэй.**

Олонд тус хүргэгчийн бие амар

Олз гарз үл бодогчийн эдлэл амар

Осол мууг тэвчигчийн санаа амар

*Хэлбэр нь дээрх хоёроос өөр байна. Яах? яах? гэсэн асуултад хариулагдахгүй харин хэний хэний гэсэн асуултад хариулагдахаар байна.*

7 **Ертөнцийн гурвыг уншиж утгыг ойлгоорой.**

1) *Асуултаар ярилцаарай.*

- Юу, юу бэрх байна вэ?  
Тэгвэл юу, юу хялбар байж болох вэ?
- Юу, юу харанхуй байна вэ?  
Тэгвэл юу, юу гэгээтэй байж болох вэ?

2) *Эсрэг утгаар нь бас зохиож бичээрэй.*

Замгүй давааг давахад бэрх

Зангилсан үгийг тайлахад бэрх

Зааны соёог залгахад бэрх

Номгүй бандийн цээж харанхуй

Хоньгүй айлын хот харанхуй

Хойшоо харсан нүх харанхуй

Сал онгоцноос салбал далай дунд

Саадаг нумнаас салбал дайсны дунд

Сайн морьноос салбал талын дунд

Худгийн усанд загас үгүй

Хууч үгэнд худал үгүй

Хөндий тэнгэрт шат үгүй

Өндөр тэнгэр үүлэн давхаргатай

Өвсөн дэлхий цасан давхаргатай

Өргөн далай мөсөн давхаргатай

8 **Дуурайн зохиож бичээрэй.**



## АСУУЛТААР ЯРИЛЦАЖ, УЧИР ШАЛТГААНЫГ МЭДЬЕ

### 1 Зургийг ажиглаад, эх ба үр зулзагыг оноож холбон бичье.

- 1) Аль нэг амьтныг сонгож ярилцъя.
- 2) Бидний унших гэж байгаа зохиолд эдгээр амьтдаас аль нь байна вэ?
- 3) Түүний тухай юу мэддэгээ ярилцъя.



### 2 Эхийг уншиж ойлгоё.



#### Бор туулай яагаад цагаан болов?

(Өгүүлээг)

1.

Манай аавын танил Дорж гуайнх туулайн бөжин тэжээдэг байв. Өнгөрсөн зун, тэднийх манай хамар хашаанд зуссан юм. Хүүд минь тэдний бяцхан бор бөжин тун “зугаатай” тоглоом байв. Өглөө босмогц л туулайн байрны хажууд очиж зогсоно. Байцайны хальс, лууван зөөж идүүлэх гэж оролдоно. Ингэсээр тэр хоёр сүүлдээ ижил дасал болж, бие биеэсээ салахаа болив. Сэрүү орж зуслангаас буух болтол тэр хоёр найзалж билээ.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
ижил дасал	.....	хоорондоо дасах
сэрүү орох	.....	.....

### 3 Энэ хүртэл ойлгосноо асуултад хариулж бичье.

- 1) Хүү хэнтэй найзалсан бэ?
- 2) Хүү, туулайн бөжинтэй найз болсон шалтгааныг тайлбарлаарай.
- 3) “Тэр чинь бор шүү дээ. Энэ чинь цагаан юм байна.” гэж хэлсэн шалтгаан нь юу юм бол?

2.

Анхандаа хүү минь тэр бөжингөө байн байн ярьдаг байв. Сүүлдээ хааяа нэг дурсдаг боловч аажимдаа мартжээ. Харин энэ өвөл цагаан сараар Дорж гуайтай золгохоор хүүгээ дагуулж, тэднийд очсон юм.

Тэгтэл нөгөө бөжин нь гэнэт орон дороос гарч ирээд цогнойн суув. Хүү маань бүр алмайртлаа гайхан зогсож харагдлаа.

- “Чиний найз бөжин чинь байна шүү дээ.”
- “Биш ээ, биш” гэж шууд мэлзэв.
- “Яагаад биш байдаг билээ?” гэсэнд:

- “Тэр чинь бор шүү дээ. Энэ чинь цагаан юм байна.” гэж үнэнээсээ хэлэхийг сонсоод, Дорж гуай, толгойг нь илэн: “Манай туулай дээлээ солиод өмсчихсөн юм байхгүй юу. Цагаан сараар гангалах хэрэгтэй шүү дээ.” гэж өхөөрдөн инээмсэглэв. Хүү минь ойлгосонгүй бололтой, над руу гайхан харав. Тэр үнэхээр туулайн зүс цагаан болсны учрыг ойлгохгүй байлаа.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
мэлзэх	.....	үгүй хэмээн зүтгэх
зүс	.....	амьтны өнгө

#### 4 Би нөхдөөсөө учир шалтгааны тухай яаж асууж болох вэ?

Тэд Дорж гуайнд золгохоор очсоныг юу гэж асуух вэ?

Тэд Дорж гуайнд **яах гэж** очсон бэ?  
Тэд Дорж гуайнд очсон **шалтгаан нь** юу юм бол гэх зэргээр асууж болно.

Учир шалтгааныг мэдэхийн тулд зөв асуулт асууна.

? Ямар учраас

? яах гэж

? яагаад

? юуны учир

? юунаас болж

? шалтгаан нь юу юм бол.

#### 5 Бор туулай яагаад цагаан болсныг одоо уншиж ойлгоцгооё.



3.

Туулайд дайсан мундахгүй ажээ. Хүн, үнэг, чоно, нохой, махчин шувуу бүгд л түүнийг отно, мөрдөнө, дайрна. Тийм учраас туулай бүх юмнаас айн, өөрийнхөө дайснаас дэгдэн зугтдаг. Хөөрхий туулай амиа хамгаалах өөр арга байхгүй гэж үү, тэгвэл тийм биш ээ. Тэр нь түүний дээлний өнгөтэй холбоотой. Хэрвээ туулай өвлийн цав цагаан цасан дээр “бор” дээлтэйгээ харайлгаж явбал яах байсан бэ? Хавар, зуны улиралд “цагаан дээлтэйгээ” явж байвал ямар вэ? Тэгвэл туулай өвлийн цагт шинэхэн дэвтрийн цаасан дээр дусаасан бэх шиг холоос торойж харагдах байсан. Энэ нь түүнд

аюул авчирч магадгүй.



ЯАГААД

бүх юмнаас айдаг вэ ?

дэгдэн зугтдаг вэ ?

цагаан цасан дээр бор дээлтэйгээ явж болохгүй вэ ?

хавар, зуны улиралд цагаан дээлтэйгээ явж болохгүй вэ ?



4.

Туулай хавар болмогц газрын өнгөтэй ижилсэн, бор халтардуу зүстэй болдог нь аюулаас нуугдах боломж өгдөг байна. Ийм учраас туулайн дээлийг байгаль эх сольж өмсгөдөг ажээ.

Одоо цастай өвлийн цаг. Тийм болохоор Дорж гуайн хашаан дахь туулайн зүс цагаан болж шүү дээ. Энэ бол байгалийг дагаж зохицож байгаа хэрэг гэж хүүдээ учрыг тайлж өгтөл: Тэгвэл зун болохоор туулай ногоон болох уу? Цагаан үс нь яачихдаг юм бэ? гэж инээдтэй бөгөөд хэцүүхэн асуулт тулгав.

Зун болохоор цаанаас нь шинэ үс ургаж гарахад, цагаан үс нь гуужаад ойчдог юм. Ноднин зун, энэ туулай бор сааралдуу зүстэй байсан. Тийм л үстэй болно. Туулай дэрс бутан доор хярж хэвтэхэд энэ зүс нь газрын хөрснөөс бараг ялгарч харагддаггүй. Тийм учраас биеийг нь хамгаалах өнгө болж чаддаг юм.



Г.Ловор

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
гуужих	.....	амьтны хуучин үс зулгаран унах
хярах	.....	нуугдан бүгж, хөдөлгөөнгүй хэвтэх

6 Туулайн онцлогийг ялгаж бичье.

Өвөл	Хавар	Зун	

7 Дараах өгүүлбэрүүдэд шалтгааны асуулт зохиоё.



*Туулай хавар болмогц газрын өнгөтэй ижилсэн, бор халтардуу зүстэй болдог.*

*Энэ нь аюулаас нуугдах боломж өгдөг.*

*Байгаль эх туулайны дээлийг сольж, амаа хамгаалахад нь тусалдаг.*

.....  
.....





## УЧИР ШАЛТГААНЫГ ОЛЖ БИЧЬЕ

Учир шалтгааныг олбол уг зүйлийг ойлгох нь хялбар болно. Учир шалтгааныг мэдэхийн тулд асуултаар тунгаан бодох нь чухал.

### 1 Зургийг ажиглаад, үлгэрийг уншъя.

- 1) “Тарвага, бор шувуу хоёр” үлгэрийн утга яагаад ойлгогдохгүй байгааг ярилцъя.
- 2) Хэсэг тус бүр дэх холбоо үгийн утгыг бодъё.
- 3) Үгийн утгыг ойлгоё.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
идээшлэх	.....	ногооны амттайг идэх
ийн	ингэж	.....

### Тарвага, бор шувуу хоёр (Үлгэр)

Тарвага халуун зунаар нүхэндээ **орохыг** мэдэхгүй идээшилнэ. Бор шувуу түүнтэй ийн ярилцжээ.



1. **амрах** завгүй, Тарвага гуай та, юунд ингэж, ажиллана вэ?

*Тарвага гуай та юунд ингэж амрах завгүй ажиллана вэ?*



2. Өвс ногооны, олж авалгүй, өвлийнхөө хүчийг, өлтэй дээр, горьгүй.

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



3. Өвөл, байхад, яараад яана даа?, яагаа ч үгүй,

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



4. Яаралгүй яахав. Өвөл, хаяанд гэж мэд. амжиж тэнхэрч **авахгүй** бол, Зуны гурван сард, миний «нойрны улирал», намар өвөл хаврын, есөн сар бол, шүү дээ.



5. Ингэж, **элээснээс**, насаа, ел хоолгүй, **явах** минь, өвөл ч бол, тэнэж, дээр.

6. Ээ...

- 2) Тарвага амрах чөлөөгүй ажиллаж байгаа шалтгааныг олж бичье.
- 3) Зөв дараалалд оруулан найруулж бичье.
- 4) Тарвага, бор шувуу хоёрын тухай юу мэдэхээ бичье.

Асуулт	Тарвага	Бор шувуу
Хаана амьдардаг вэ?		
Юугаар хооллодог вэ?		
Хаана өвөлждөг вэ?		
Ямар ач тустай вэ?		

- 1) Дараах зургууд яагаад ийм дараалалтай байгаа учрыг бичье.

1) Чиний мэдэх ямар амьтан арван хоёр жилд ороогүй вэ?



- 2) Зохиолыг уншиж ойлгоё.


## Тэмээ үнсэнд хөрвөөх болсны учир (Монгол ардын үлгэр)

Эрт урьд цагт Бурхан багш арван хоёр жилд адгуусан амьтны нэр оноон өгч байжээ. Арван нэгэн амьтны нэрийг шууд хэлэв. Харин үлдсэн нэгд ямар амьтны нэр **өгөх** вэ? гэхэд тэмээ, хулгана хоёр хоёул “Би, би” гэжээ. Бурхан, аль алиныг нь гомдоохгүйн тулд “Өөрсдөө шийд” гэж гэнэ.

Тэр хоёр маргааш өглөөний мандах нарны туяаг хэн түрүүлж харсан нь арван хоёр жилийн тэргүүн **болохоор** болж гэнэ.

Тэмээ нь нар **гарах** дорно зүг харж, нар **мандахыг** хүлээн зогсов гэнэ. Харин хулгана тэмээний бөхөн дээр гарч, уулын орой ширтэж байв. Тэгж байтал нар **гарах** цаг болж, **ургах** нарны анхны туяа баруун уулын оройд туссанд хулгана нарны туяаг түрүүлж хараад, “Нар гарлаа” хэмээн хашхираад, үнсэн доогуур орчихжээ. Тэмээ мэлзээгээ алдсандаа уурлаж, хулганыг **дэвсэх** гэж ухасхийн үнсэн дээр хөрвөөв гэнэ.

Тэр цагаас хойш тэмээ үнс асгасан газар **харагдах** бүрд өнөө өстөн хулганыг хөнөөх санаатай үнсэнд хөрвөөх болсон гэнэ.



Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
хөрвөөх	.....	амьтан газар хэвтэж, биеэр налах үйл
мэлзээ	.....	болзол тавьж тэмцэлдэх

### 3 Асуулт зохиож суръя.

**ЯАГААД?**

1. .... ?

2. .... ?

3. .... ?

1) Би зөвхөн хулганы хэлсэн, хийснийг уншъя.

*Эхлээд «Би, би» гэж хэлжээ.  
Дараа нь тэмээний бөхөн дээр гарчээ.  
Ингээд уулын орой ширтэж байв.  
Тэгээд нарны туяаг түрүүлж харжээ.  
Тэнэт «Нар гарлаа» гэж хашхирсан.  
Түүний дараа үнсэн доогуур орчихжээ.*



2) Тэмээ юу хэлсэн, хийснийг бичье.



\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

2.

Тэмээ арван хоёр жилд багтаагүй боловч арван хоёр жилд багтсан бүх амьтны шинж төрхийг биедээ агуулсан байдаг ажээ.

Тэр нь: Хулгана чихтэй, үхэр гэдэстэй, бар тавагтай, туулай хамартай, луу биетэй, могой нүдтэй, морин дэлтэй, хонин ноостой, мичин бөхтэй, тахиа өрөвлөгтэй, нохой гуятай, гахай сүүлтэй байдаг гэнэ.

4) Үлгэрээс уншиж ойлгосноо товч бичээд нөхдөдөө ярьж өгөөрэй.

- 1) Эхлээд юу болсон бэ?
- 2) Дараа нь яав?
- 3) Төгсгөлд нь яасан бэ?

5) Тус бүрд нь нэг, нэг шалтгаан олж бичээрэй.



..... түрүүлж харжээ.  
 ..... үнсэн доогуур оржээ.



..... мандахыг хүлээв.  
 ..... үнсэн дээр хөрвөөв.

Х.3

### АЛДААГҮЙ ЗӨВ БИЧИЖ СУРЪЯ

1) Тодруулсан үгсийг ажиглаж зөв бичье.

- 1) “Тарвага бор шувуу хоёр”, “Тэмээ үнсэнд хөрвөөх болсны учир” үлгэрээс тодруулсан үгийг хуулж бичье.
- 2) Яах? гэсэн асуултад хариулагдах эдгээр үгсээ өгүүлбэрт оруулж бичье.

бол

бол**о**х

өг

өг**ө**х

урга

урга**х**

Би үүнийг мэдлээ.

Эдгээр нь үйл үг байна. Бас бүгдэд нь “-х” залгавар залгаж бичжээ. Үйл үгийн “-х” залгаврын өмнө эгшиг бичсэн байна.

3) Дараах үгсийг холбож зөв бичье.

өгөх болох гарах мандах ургах дэвсэх харагдах	+	- ын - ийн - ыг - ийг		..... ..... ..... ..... ..... .....	1) Бичсэнээ шалгая. 2) Найздаа тайлбарлан хэлж өгье.
---	---	--------------------------------	--	--	---

Гэхдээ нэг чухал зүйл байна. Үйл үгийн «-х» залгаврын өмнө орсон эгшгийг гээхгүй бичдэг юм байна гэдгийг мэдлээ.

Миний мэдсэн зүйл

2) Дараах зургийн нэрийг хэлээд үзье. Адилхан сонсогдох ямар үгс байна вэ? Бичиж авъя.

Нэр үг	Үйл үг	
 <p><b>торх</b> Зөгийн балыг <u>торхонд</u> хадгалдаг.</p>	 <p>..... Нүдэнд юм торох үед яаж авах вэ?</p>	торх - торох
 <p><b>өрх</b> Ээж <u>өрхөө</u> татав.</p>	 <p>..... Тоглохын өмнө шатраа зөв өрөх хэрэгтэй.</p>	..... - .....
 <p>Гурваас дээш настай эр ямааг <u>сэрх</u> гэдэг.</p> <p><b>сэрх</b></p>	 <p>..... Эрт сэрэх нь биед сайн.</p>	..... - .....
 <p>Хоолондоо <u>чимх</u> давс нэмчих.</p> <p><b>ЧИМХ</b></p>	 <p>Сүлд модоо чимэх сайхан шүү.</p> <p>.....</p>	..... - .....



### ЗОХИОЛЫН ҮЙЛ ЯВДЛЫГ ӨӨРЧИЛЖ БОЛОХ УУ?

Үйл явдлыг уншихдаа баатруудын хэлэх үгийг ургуулан бодож төсөөлөх  
 Баатрын ба зохиогчийн үгийг ялгах  
 Анхааруулах өгүүлбэрийг зөв хэрэглэх



1) Багшийн хэлсэн үгийн утгыг төсөөлөн бодъё.



Багш бидэнд «Хагацашгүй сайн найздаа марташгүй муу үг бүү хэл» гэж хэлдэг. Энэ юу гэсэн үг юм бол?



1) Төсөөлөн бодсоноо бичье.

2) Эхийг уншихдаа хүүхдүүдийн хэлсэн үгийг төсөөлөн бодож гүйцээе.

**Нэг ангийнхан**

Амар тав хоног эмнэлэгт хэвтээд хичээлдээ оров. Эмнэлэгт байхад ангийнхнаас нь хэн ч эргэж ирсэнгүй. «Өөр ангиас шилжиж ирээд удаагүй болохоор л тоохгүй байна. Хуучин ангид байхад мөн ч сайхан байжээ. Ноднин жил хэвтэхэд Хүрэлээ маань хүртэл долоон гөөхий авчирч өгсөн. Алимаа хайрцаг шоколад өгч байсан.

- Пээ Ложоог яаж эргэсэн гэж бодно. Халуун савтай цай, таван хуушуур өгч байгаа биз дээ. Чихэр өгөөгүй хүүхэд байхгүй. Гэтэл манайхан... Бараг мэдээгүй байх. Яамай даа» хэмээн бодож байлаа. Амар баахан урам муутайхан ангидаа оров. «Би та нарт гомдсон шүү» гэсэн бичгийг нүүрэн дээрээ наачихсан юм шиг орж ирээд уруулаа унжуулан суув.

Нөхөд нь:

Нөхөд нь юу гэж хэлсэн байж болохыг төсөөлөн бодож хэлье.

- ..... гэхэд ангийн дарга Бүзмаа:

- ..... гэж хэлэв.

Амар огт дуугарахгүй байлаа. Ээж, аавдаа тунирхахаар ийнхүү дуугаа хураан уруулаа унжуулан суудаг хүүхэд ажээ. Тэр, ангийнхандаа нэг юм хэлмээр санагдаад байв.

Амарын хэлмээр санагдсан зүйлийг төсөөлөн бодоод хэлээд үзье.

“.....”. Энэ үгээ золтой л хэлчихсэнгүй. Амар бас ч азтай хүү юмсанжээ. Ангийн дарга Бүзмаа багшийн ширээний дэргэд очиж, том хүн шиг хоолойгоо засаад:

Ангийн дарга юу гэж хэлсэн бол? Төсөөлөн бодоод хэлье.

.....  
..... гэв.

Тэгээд бас хоолойгоо засаж:

- Үлдсэн төгрөгөөр нь дэвтэр авч Амарынхаа бүх хичээлийг хуулсан. Бид чамайг хичээлээсээ хоцрох вий гэж айж байлаа. Одоо дэвтрүүдийг нь хүлээлгэж өгье гэв. Салаан дарга Золжаргал хүүхдүүдээс дэвтрийг хураан авч, Амарт өгөв. Амарын нүдэнд ичсэн, баярласны гэрэл сүүдэр сүлэлдэн байв.

*С.Надмид*



### 3 Асуултын дагуу ярилцъя.

- |  |  |
|--|--|
| 1. Амар яагаад урам муутайхан ангидаа орсон бэ?          | 1. Чиний төсөөлөн бодсон чинь зөв байсан уу? Яагаад?                                       |
| 2. Амарын нүүрэн дээр юу гэж биччихсэн юм шиг байсан бэ? | 2. Амарт тохиолдсон шиг явдал чамд болон найзад чинь тохиолдож байсан уу?                  |
| 3. Амар яагаад ичсэн бэ? Чи юу гэж бодож байна?          | 3. Танай ангийнхан чамд тусалдаг уу? Хэзээ яаж тусалж байсан бэ? Дурсан бодоод ярилцаарай. |

### 4 Найздаа баярласнаа яаж хэлэх вэ? Төсөөлөн бодож бичье.

1) Найзынхаа сайн чанарыг бичье.

#### Тэр миний найз

Дугар найз минь	Ямар боловч
Дутагдал гаргажээ.	Миний найз.
Яах вэ? Яах вэ?	Дугар найздаа
Миний найз.	Дуртай тусална.

*Д.Давааням*

#### Баярлалаа, найз аа!

.....

.....


.....

.....



### 1 Үлгэрийг уншиж ойлгоё.

Загварын дагуу хурдан унших дасгал хийе.



#### Гурван тааварчин (Монгол ардын үлгэр)



суулгаад, жаахан идэх юмаа боож баглаад, аян замд гарч гэнэ.

Гурван хүүхэд ингээ эрж явсаар нэгэн ноёнд очтол тэдний гадна ингэ нь уяатай байж гэнэ. Тэгээд ноёноос ингээ авъя гэтэл:

- Энэ ингийг чононд бариулах гэж байхад нь манай тэмээчин олжээ. Та нарын тэмээ мөн бишийг мэдэхгүй.

Урьд ботготой ганц ингэтэй, гурван өнчин хүүхэд байжээ. Ингэний сүүг гурван хүүхэд ууж, ботго нь эхийгээ хөхөж амьдардаг байв. Нэгэн өдөр ингэ нь бэлчээрт гараад эргэж ирсэнгүй. Гурван өдөр хүлээсэн боловч ирсэнгүй. Гурав дахь өдөр нь болоход ботго нь харангадах шахаж, бага дүү нь сүү нэхэж уйлж гэнэ. Ах дүү хоёр хоорондоо зөвлөөд, ингээ олж ирэхээр болж, эрх танхил бага дүүгээ

б о т г о н  
д э э р э э



- Та нар таавар таахдаа хэр вэ? гэвэл тэд бид таахдаа л таадаг гэв. Ноён хэлэв:  
- “Би та нараар юм таалгана. Таахгүй бол энэ тэмээ та нарынх биш гэж үзнэ шүү.” гэж хэлэв. Та нар гэрээс гарч байгтун гээд ноён гурван аяганд юм хийж хөмөрч тавиад:  
- Одоо ороод ир! гэв. Тэднийг орж ирсэнд хаан асуусан нь: “Хамгийн дээд талын аяганд юу байна вэ? гэсэнд:

- Ах нь: Юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн бичье.

..... юм байна гэв.

Дунд ах нь: Юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн бичье.

..... юм байна гэв.

Бага дүү нь: Бөв бөөрөнхий бөгөөд шав шар өнгөтэй юм бол болжморын өндөг биз ээ гэлээ.

1) *Том ах, дунд ах хоёр нь юу гэж хэлсэн байж болохыг ярилцъя.*

2) *Ярилцсанаа бичье.*

Ноён аягыг аваад харуулбал үнэхээр болжморын өндөг байлаа.

- За одоо дунд аяганд юу байна вэ? гэж ноён асуусанд:

Том ах нь: Ув улаан юм байна гэв.

Дунд ах нь: Ав амттай юм байна гэлээ.

Бага дүү нь: Юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн ярилцъя.

..... гэсэн чинь бас л таачихжээ.

- Сүүлийн аяганд тэгвэл ямар юм байна гэж ноён асуусанд:

Том ах нь: Дүгрэг хэлбэртэй юм байна гэхэд

Дунд ах нь: Дундаа дөрвөлжин нүхтэй юм байна гэсэнд,

Бага дүү нь: Юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн ярилцъя.

..... гээд, гурван аяганы дотор байгааг бүгдийг нь таачихжээ.

Тэгэхэд нь ноён гурван хөвгүүний эрдмийг биширч, хонь төхөөрч, айргаар дайлж, тусгай гэр бариулан, найр наадам хийв. Хөвгүүд:

- “Айраг нь ч айраг юм. Өөр юмтай холилдсон айраг байна. Мах нь мах юм, нохойны мах амтагдаж байна. Ноён нь ч ноён юм, ядуу бидний төрөл бололтой” хэмээн ярилцаж байна гэнэ. Үүнийг зарц сонсоод ноёндоо ирж хэлэхэд, ноён их уурлаж, бас их гайхаж гэнэ. Уурласан ноён хоньчин дээрээ очиж:

- Чи надад нохойн мах өгөв үү? гэхэд хоньчин:

Хоньчин юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн хэлье.

..... ГЭЖ ХЭЛЭВ.

Ноён адуучин дээр очоод:



- Чи айрганд юу хольж өгөв? гэсэнд, адуучин:

Адуучин юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн хэлье.

..... гэж гэнэ.

Ноён гэртээ ирээд эхээсээ асуусан нь:

- Бидний төрөл садан хаана байдаг юм бэ? гэлээ. Эх нь:

Ноёны эх юу гэж хэлсэн бэ? Төсөөлөн хэлье.

..... гэж хэлжээ.

Ноён гурван хүүхдийн ингийг буцаан өгч эд хөрөнгө, адуу мал бэлэглэж, ахан дүүсээ олсны найр наадам хийж, амар сайхан жаргажээ.

## 2 Ургуулан бодвол юу байж болох вэ?



### 1 Дараах эхийг уншаад ярилцъя.

1) Зүйр цэцэн үгсийг хуулж бичье.

2) Онцолсон үгсийн эгшгийг гээхгүй бичсэний учрыг тайлбарлая.

### Найзууд

Багаасаа үерхсэн хоёр охин нэг сургуулийн нэг ангид, бүүр нэг ширээнд сууцгаана. Нэгийг нь Номин, нөгөөг нь Хулан гэдэг. Нэг удаа багш монгол хэлний хичээл дээр цээж бичиг хийлгэлээ.

Багш их л эелдгээр:

- «Багшийнхаа хэлэхийг эхлээд сайн сонсож, дараа нь бичнэ шүү!» гэв. Тэгээд намуухнаар:

**“Жаргалын** дээд сэтгэл амар

Нөхрийн дээд үл атаархагч

**Тэнгэрийн** муухай арилна

Хүний муухай арилахгүй

**Ахмадын** үгийг дуулж яв

**Албатын** үүргийг биелүүлж яв” гэж хэлж бичүүлээд, утгыг тайлбарлахыг сануулав.

Харин Номин тохой залган суусан найздаа дохио өглөө. Найздаа “хуулуул л даа” гэж гуйсан юм аж. Учир нь тэр цээжээр бичихдээ тааруухан юмсанж. Хулан үргэлж л түүний хичээлд тусалж, гэрийн даалгавраа хамт хийдэг. Харин Номин болохоор тийм ч сайн бичиж сураагүй л байлаа. Бичсэнээ харуулсангүй гэж Номин найздаа ихэд гомджээ. Хичээл тараад тэр Хулантай хамт явсангүй. Орой нь Хулан гэрийн даалгавраа хамт хийхээр очиход нь, Номин гэртээ ч оруулсангүй... Хэний зөв бэ?

Номин, Хулан хоёрын үерхэл цаашид яах бол? Төсөөлөн бодоод үргэлжлүүлэн зохиож бичье.

2 Шүлгийг уншаад, “Найзууд” эхийн утгатай холбон ярилцаарай.

Найз

Тоогоо бодсоноо  
Хуулуулаач гэхээр  
Толгой сэгсрээд  
Тоохгүй байсан.  
Харин маргааш нь  
Математикийн давтлаганд  
Хажууд суугаад заагаад өгсөн.  
Өнөөдөр би  
Тооны шалгалтдаа  
Өндөр цамхаг шиг “А” авлаа



Ойлгож ухаарахгүй  
Хуулсан бол  
Онц дүн  
Авахгүй л байж дээ  
Үнэнч сайн  
Найз маань намайг  
Өөрийгөө хуурахаас  
Аварсан байна шүү.

О.Сундуй

- 1) Энэ шүлгийг Хулан, Номин хоёрын хэнд нь уншиж өгч болох вэ? Яагаад?
- 2) Шүлгийн тодруулсан хэсэг нь чамд тохиолдсон ямар явдлыг санагдуулж байна вэ?
- 3) Шүлгийг цээжлээд мэдрэмжээ илэрхийлж уншъя..

3 Хэний зөв бэ? Яагаад гэдгийг хэлэлцье.



Би Номингийн зөв гэж бодож байна. Яагаад гэвэл: .....

Би Хулангийн зөв гэж бодож байна. Яагаад гэвэл: .....



Х.3

АЛДААГҮЙ ЗӨВ БИЧИЖ СУРЪЯ

1 Тодруулсан үгсийг ялгаж бичээд ажиглая.

Би үүнийг мэднэ.

Жар-гал, тэн-гэр, ах-мад, ал-бад, тайл-бар гээд бүгд 2 үеэс бүтэж байна. Бас хоёрдугаар үе нь дандаа эгшигт гийгүүлэгчээр эхэлж байна.

“жаргалын” гэхэд “а” эгшиг нь ялгах бас эгшигжүүлэх хоёр үүрэгтэй байгаа учраас гэж болохгүй. Харин “тэнгэрийн, ахмадын, албадын, тайлбарыг” гэдгийг яагаад ингэж бичсэн юм бол?

Надад асуулт байна.

Би үүнийг мэдлээ.


“тэнгэрийн, ахмадын, албадын, тайлбарыг” гэж бичнэ шүү дээ. “э,а” эгшгүүд нь эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй байна шүү дээ.

2 Дараах үгсийг холбож, алдаагүй бичье. Хоёрдугаар үед байгаа эгшиг ямар үүрэгтэй байгааг бодоорой.

болжмор  
хөдөлмөр  
бүргэд  
чадвар  
бэлтгэл

+

- ын  
- ийн  
- ыг  
- ийг



.....  
.....  
.....  
.....  
.....

- 1) Бичсэнээ шалгая.
- 2) Найздаа тайлбарлан хэлж өгье.



## АНХААРУУЛАН ХЭЛЭХ УТГЫГ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ

1 Зурагт байгаа баатруудын зан чанарыг төсөөлөн хэлье.

- 1) Тэд юу хийж байгааг бодъё.
- 2) Тэд юу, юу гэж хэлж байгааг төсөөлөн ярилцъя.

Бидний хүсэл нэг шүү  
найзууд аа.



Хар нүдэн минь  
чи миний сайн  
найз шүү.



2 Нөхөрлөлийн тухай илүү ихийг мэдэхийн тулд дараах шүлгийг уншъя. Утгыг мэдэхгүй үг, хэллэг байвал асууж мэдээрэй.

### Найзын шүлэг

Найз минь! Би чиний баруун гар больё!  
Найз минь! Би чиний харах мэлмий байя!  
Бид хоёр нэг дэлхийн хүүхдүүд  
Бид хоёр нэг цээлийн загас  
Хэрүүл бидэнд хэрэггүй ээ!  
Алтан нарны туяанд эвтэйхэн зэрэгцэж явъя  
Атаархал бидэнд хэрэггүй ээ!  
Нутгийнхаа голын нэг доvon дээр хоёулаа багтъя!  
Өрөөл бусдаас хүндэтгэл нэхээд нэмэргүй ээ!



Нэг зүрхний хоёр судас шиг үнэнч  
 Нэг шувууны хоёр далавч шиг тэнхээлэг  
 Нэг загасны хоёр нүд шиг сэргэг  
 Нэг хүний хоёр гар шиг эвсэг  
 Тийм л сайхан дэлхийдээ найз нар явцгаая!  
 Тэнгэрээсээ уйддаггүй дэлхийдээ найз нар явцгаая!  
**Найз минь! Чи миний баруун гар яваарай!**  
**Найз минь! Чи миний харах нүд яваарай!**

С.Базарсад

3 Асуултын дагуу ярилцъя.

1. Найздаа юу, юу гэж анхааруулан хэлсэн байна вэ? Ярилцъя.
2. Шүлгийг цээжлэн уран тод уншъя.

1. Бидний нөхөрлөл арван жилийн дараа ямар байх бол? Төсөөлөн бичье.

4 Шүлгийн дараах хэсгийг дахин уншъя.

- 1) Юу гэж хэлж байгааг ойлгоё. Өгүүлбэрийн ард ямар тэмдэг байгааг мэдье.



Найз минь! Чи миний баруун гар яваарай!  
 Найз минь! Чи миний харах нүд яваарай!

Найз маань надаас хүсэж байгаа юм байна.

Найз минь! Би чиний баруун гар больё!  
 Найз минь! Би чиний харах мэлмий байя!

Найз минь зөвшөөрч байна.



5 Дараах бадгийг анхааруулах өгүүлбэр болгон бичье.

- 1) Үг нөхөж бичээд найздаа уншиж өгье.

Нэг зүрхний хоёр судас шиг үнэнч .....  
 Нэг шувууны хоёр далавч шиг тэнхээлэг .....  
 Нэг загасны хоёр нүд шиг сэргэг .....  
 Нэг хүний хоёр гар шиг эвсэг .....

- **Нөхөх үг:** байя, явъя, найзалъя, үерхье
- Энэ 4 мөрийг найзынхаа сэтгэлд хүргэхийн тулд яаж хэлэх вэ?

6 Анхааруулж хэлсэн утгыг сайн ойлгоё.

- 1) Шүлгээс анхааруулж хэлсэн өгүүлбэрийг түүж бичье.
- 2) Тэр өгүүлбэрийн утгыг тайлбарлан бичье.

7 Ирмүүн зам хөндлөн гарахаар ухас хийв. Тэр үед улаан гэрэл ассан байлаа. Энэ тохиолдолд чи юу гэж хэлэх вэ? Хэлж болох өгүүлбэрүүдийг жагсааж бич.


- Замаар гарч болох уу?
- Болохгүй шүү!
- Яагаад?
- Гэрэл дохиогоо хараарай!
- Тэгвэл яах ёстой вэ?
- Ногоон гэрэл асахаар гарна шүү!

Чанга тод дуугаар хэлээд үз.

Яаж хэлбэл сонсож байгаа хүнд аятайхан сонсогдох бол.

Гэхдээ би түүнд анхааруулах ёстой шүү дээ.

8 Цагдаа, охинд юу гэж хэлж байгааг бодоод, өгүүлбэрийг бичье.



..... ?

..... !

.....

.....

9 Бичсэн өгүүлбэрээ хэн нэгэнд хэлье.


1) Ямар дуу хоолойгоор хэлэх вэ?


2) Өгүүлбэрийг өөр, өөрөөр дуудан хэлж байгааг тэмдэглэе.


! , ? .

10 Зам хөндлөн гарах гэж байгаа найздаа зориулан санамж бичье.



 Найзууд аа!  
Улаан гэрэл  
асвал зам  
хөндлөн  
гарч болохгүй шүү!

 \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

 \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

1) Бичсэн санамжаа хэн нэгэнд хэлж өгье.

11 Чи замаар хөндлөн гарахдаа хэн нэгнээс тусламж хүсвэл яаж хэлэх вэ? Хэлж үзээд, зохих цэг тэмдгийг бичье.

Замаар хөндлөн  
гарахад надад  
туслаач



Та зам хөндлөн  
гарах гэж байна уу

Намайг хөтлөөд  
зам хөндлөн  
гараарай

Намайг  
дагуулаад яваач

## 12 Дараах өгүүлбэрүүдэд ! ? . тэмдгийн аль нь байхыг бичнэ үү.

Өглөө болчихлоо хурдан босооч дээ Өглөөний нар мандлаа өндийгөөрэй Хүүе, хүүе Түшээд аваарай Эрхэм найз минь ээ Үүнийг заавал уншсан байна шүү.



Баярлаж бахдах, айж эмээх, цочиж сандрах, дургүйцэх, уурлах зэрэгт сэтгэлээ илэрхийлэхдээ өгүүлбэрийн төгсгөлийг уртаар хүчтэй хэлж анхааруулдаг.



## БААТРЫН БОЛОН ЗОХИОГЧИЙН ҮГИЙГ ЯЛГАЯ

### 1 Зохиолын хэсгийг уншаад зурагтай холбон ярьъя.

#### Мөнхийн ус

(Зохиолын хэсгээс)

Өвгөн Амбаагийн үрчлээтэж атирсан дух, урт цагаан сахлыг ажиглаж суусан Лут:

- Амбаа гуай бид нар бас л тан шиг ийм үрчгэр духтай, цагаан сахалтай болох уу? гэж асуув. Амбаа гуай сахлаа имэрч:
- Та нар ч гэсэн хэзээ нэгэн цагт бас над шиг болно. Та нарын дух минийх шиг ийм атираатай болж, бас цагаан сахал ургана даа гэв.



### 2 Амбаа гуай ийм залуу болж өөрчлөгдөж болох болов уу?

Болно гэж бодвол яагаад гэдгээ баталж тайлбарлая.

Болохгүй гэж бодож байвал яагаад гэдгээ үгүйсгэж тайлбарлая.

### 3 Дараах зохиолыг “Сахалтай жаал” гэж нэрлэсний учрыг уншиж мэдье.

- Сахалтай жаал Амбаа гуай хоёр нэг хүн мөн үү, биш үү?




- Мөн бол түүнийг юу тэгж өөрчилсөн бол?
- Биш бол сахалтай жаал хэн болж таарах вэ?

### Сахалтай жаал

Сайн байна уу? Амбаа гуай гэж зэрэг зэрэг хашхиралдав. Гэтэл мөн хачин юм болжээ. Амбаа гуай алга байлаа. Харин энгэртээ хүрсэн урт сахалтай жаал хүү ширээний дэргэд зогсоод Амбаа гуайн цамцыг өмсөх гэж тэвдэж байснаа хүүхдүүд рүү харж,

- Сайн л байна. Та нар сайн байна уу? гэв. Гайхсан хүүхдүүд хариу хэлэхийн оронд Амбаа гуай хаачсан бэ? гэж бас л зэрэг, зэрэг асууцгаав. Өнөө жаал тэдний энэ асуултыг сонсоод нүдээ бүлтийлгэж,
- Би л байна шүү дээ, та нар чинь Амбаагаа танихаа байчхаа юу гэв. Хүүхдүүд түүний урт хар сахал руу гайхан ширтэцгээхдээ учрыг нь олж ядан, хиймэл сахалтай хүүхэд юм болов уу? гэж анхандаа бодсоноо “Та нар чинь Амбаагаа танихаа байгаа юу?” гэхийг нь сонсож мэл гайхаж хэлэх үгээ олж ядав. Тэр жаал хиймэл сахалтай биш, жинхэнэ хар сахалтайгаас гадна, Амбаа гуайн хувцсыг өмсөх гэж ядаж байх нь үнэхээр хачин. Амбаа гуайн том гутал, өргөн цоохор цамцыг өмссөн нь яг л дахан доор орсон хурга шиг санагдана.
- Яасан хачин аймаар жаал вэ? гэж Цэцэг охин сэм шивгэнэв.
- Чи, Амбаа гуай биш байна. Харин хаанаас ирсэн жаал вэ? гэж Бут зүрхлэн асуув.
- Чи яагаад хар сахалтай болчихсон жаал вэ? гэж Лут дараалан асуув.
- Юу гэнэ ээ? Та нар чинь. Би жаал биш, Амбаа гуай чинь байна. Би уулаасаа сахалтай байсан шүү дээ! гэж сахалт жаал хариулав.

- 4 **Уншсанаасаа зохиогчийн үгийг ялгая. Яагаад зохиогчийн үг гэж бодож байгаагаа багаар ярилцаарай.**
- 5 **Зохиолыг үргэлжлүүлэн уншихын өмнө дараах асуултын хариуг төсөөлөн бодож загварт буулгая.**



- 6 **Зохиолыг үргэлжлүүлэн уншъя.**

- ... Амралтын өдөр тул Богд ууланд гарч зугаалахаар хотын хүмүүс хөнгөн тэрэг, хоёр дугуйт бас зарим нь эгц дээш нисдэг онгоцоор нисэж, замын дагуу хөл ихтэйн гадна уулын оргилд гарах цахилгаан дүүжингээр эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу хүмүүс инээлдэн хөгжилдөн цувж байлаа. Амбаа тэр бүхнийг тоомсорлохгүй нүдээр ажин харж “Би чинь өнөөдөр ач хүүгийн дээ айлчлах ёстой сон бил үү. Муу тэргэндээ шалгалт хийлгэж, цэнэглүүлж аваад л гарч үзье” гэж амандаа шивнэж явлаа. Үүлэн бор нь цөмийн хүчээр хөдөлдөг машин байжээ. Амбаа гуайн ач нар мянган километрийн цаана “Хонин усны говь”-д байдаг юм. Амбаа гуай тэр хол газар цөмийн тэргээр өдөртөө очоод, өдөртөө эргэж ирдэг байсан юм...

*а. Энэ хэсгээс зохиогчийн үгийг ялгаж бичээрэй.  
б. Яагаад зохиогчийн үг гэж үзэж байна вэ?*

... Хурандаа Сонор гайхаж,

- Мөнх гуай юу болж байна аа. Надад ярьж өгөөч гэв.
- За хүү минь сонс. Өчигдөр Амбаа гуай манайд ирж тамирын эм авсан юм. Гэтэл би андуураад хүнийг залуужуулах “Шинэ тан” гэдэг эмийнхээ хамгийн сүүлийн найрлагыг өгч орхижээ. Амбаа гуай маань нэг шөнийн дотор залуужжээ. Уг нь би эмээ Амбаа гуайд сүүлийн 50 жил туршиж байгаа юм л даа гэж эрдэмтэн хэлээд сахалт жаал руу зааж,
- Энэ бол ямар нэг сахалт дээрэмчин биш, мөнхийн ус ууж залуужсан зуун наст Амбаа гуай байна. Харин нэг эм дутуу уусан учраас сахал нь хар болсон боловч гуужиж уналгүй үлджээ... гэв.

а. Энэ хэсэгт ямар ямар баатрууд байна вэ?

б. Баатруудын үгийг ялгаж бичээрэй.

в. Зохиогчийн үг биш гэдгийг батлаарай.

“Мөнхийн ус” зохиолоос хэсэглэн авав. Л.Түдэв

### 7 Амбаа гуай уг нь юуг хүссэн бол?

Амбаа гуайн хүссэн зүйл нь:

.....



Амбаа гуайн хүсээгүй зүйл нь:

.....

### 8 Одоо цаашид ямар үйл явдал өрнөх бол?

Амбаа гуай

- Энэ зохиолд юуг нэмж өгүүлээсэй гэж хүсэж байна?
- Энэ зохиолыг цааш нь зохиож бичвэл чи ямар баатар нэмж бичмээр байна вэ? Яагаад?
- Ямар баатрыг нь хасмаар байна? Яагаад?

сахалтай жаал


Л.Түдэв. “Мөнхийн ус” зөгнөлт туужийг уншвал Амбаа гуай, сахалтай жаал хоёрын тухай илүү ихийг мэдэж зохиолыг сайн ойлгоно.

### 1 “Эцгийн захиас” эхийг уншиж ойлгоё.

а. Зургаар дамжуулан үг бүрийн утгыг сайн ойлгоё.

	<b>тариачин</b>	тариалангийн ажил эрхлэх хүн;		<b>гэрээс</b>	Хүн нас барахынхаа өмнө захиж хэлсэн үг, захиа; гэрээс үг; гэрээс захиа; гэрээс хийх
	<b>шалгалт</b>	1. зөв буруу эсэхийг шалгах; 2. үзсэн сурсныг шалгах;		<b>бэх</b>	бичих зурахад хэрэглэгдэх будаг; бэх зуурах

Хурдан унших харааны дасгал хийе.



2) Даалгавар **а** -д тайлбарласан үг тааралдвал зурж тэмдэглэн уншъя.

### Эцгийн захиас

Ганц хүүтэй ядуу тариачин нас барахынхаа өмнө эхнэртээ “Хүүгээ л эрдэмтэй сайн хүн болгоорой. Тэгвэл хүн бүхэн хүндэтгэнэ” гэж захижээ.

Хүүг долоон нас хүрмэгц эх нь:

“Одоо чи эцгийнхээ гэрээсийг биелүүлэх цаг нь болжээ. Чамд эрдэм сурах арван жилийн хугацаа өгье. Тэгснийхээ дараа хотод очиж шалгалт өгөөд, эрдэмтэн болж чадна” гэж хэлэв. Хүү хот руу явсан боловч хугацаанаасаа өмнө эргэж ирэхэд, эх нь хүүгээ санасан хэдий ч сэтгэлээ барин:

- Чи яагаад хугацаанаас өмнө ирэв? Шалгалт өгч чадахаар ном эрдэм сурчхаа юу? гэж асуухад, хүү нь уйлж, “Идэх юм өгөөч.” гэв.
- Би тандаа ирэх гэж яараад арван жил сурах ном эрдмийг наана нь сурчихсан гэхэд эх нь:
- Тэгвэл чи эхний арван үсгийг харанхуйд бич гээд гэрлээ унтраахад, хүү ч үсгээ бичиж, эх нь ч боорцог хийжээ.

Хүүгийн бичсэн үсгүүд нь том жижиг, хэд хэдэн газар бэх дусаасан байхад ээжийнх нь хийсэн боорцог цэв цэвэрхэн, сайхан болсон байв. Ээж нь хүүгээ гэртээ байлгахыг хэчнээн их хүсэж байсан ч “Эрдмээ өөрийн болгон сураад ир” гэж тэр шөнөдөө явуулжээ.

3) Зохиолын баатрууд юу, юу гэж хэлснийг ялгаж бичье.

4) “Эцгийн захиас” эхийг дахин уншъя. Сонирхолтой хэсгийг бас тэмдэглэж уншаарай.

- 1) Хүүхдүүд янз бүрээр тэмдэглэжээ. Түүнийг мэдэцгээе. Чи яаж тэмдэглэсэн бэ?
- 2) Дараах үгийг хэн хэн хэлсэн бол?



“Хүү хот руу явсан боловч хугацаанаасаа өмнө эргэж ирсэн” гэсэн өгүүлбэр сонирхолтой байсан болохоор ингэж зурж тэмдэглэсэн юм.

ЭНЭ ҮГИЙГ  
ЗОХИОГЧ  
ХЭЛСЭН

ЭНЭ ҮГИЙГ

.....  
.....

“Чамд эрдэм сурах арван жилийн хугацаа өгье.” гэсэн өгүүлбэр сонирхолтой байсан болохоор ингэж зурж тэмдэглэсэн юм.



Уншихдаа зохиогч бас баатрын хэлсэн үгийг өөр өөрөөр ялган зурж тэмдэглэж болно.

ЭНЭ ҮГИЙГ

.....  
.....

Тэмдэглэх арга өөр өөр байж болно.



, —, ~, |

Сайн анхаарч уншина. Уншиж байхдаа сонирхолтой санагдсан үг, өгүүлбэрийг тэмдэглэнэ. Бас сайн мэдэхгүй үг байвал тэмдэглэнэ. Уншаад дууссаны дараа төвөггүй олоход зурж тэмдэглэх нь хэрэгтэй байдаг.

### 5 Зохиогчийн хэлсэн үгийг нөхөж бичье.

..... явсан боловч .....	..... ?
..... үсгээ бичиж .....	..... ?
..... том жи..... цэв цэвэрхэн.....	..... ?
..... гэртээ байлгахыг.....	..... ?

### 6 “Хүү хугацаанаасаа өмнө эргэж ирсэн” гэсэн үгийг зохиогч яах гэж бичсэн бол?

#### Зохиолуудыг уншихад:

Баатруудын хэлсэн үг байна.

Бас зарим үед зохиогчийн үг байх юм. Яагаад зохиогчийн үг байдаг юм бол?



Би ч бас өөрөөр тайлбарлаж бичье.



“Хүү хот руу явсан боловч хугацаанаасаа өмнө эргэж ирсэн” гэсэн өгүүлбэрийг зохиогч хэлсэн. Яах гэж?

.....

7 Ямар ялгаатай байгааг ярилцаарай. Тийм ялгаатай үг 5-ыг олж бичээрэй.

баг – бага  
уураг – уурга

араг – арга  
буг – буга

тараг – тарга  
алаг – алга

Утга нь ямар  
ялгаатайг  
ярилцъя.

Хүүхэн хэл идэвхтэй оролцож “га, го, гу, гы” гэж хэлэгдэх **г** үсгийг “хоолойн г” гэнэ. “Хоолойн г”-ийн ард а, о, у, ы дөрвөн эгшгийн аль нэгийг бичнэ.

*Жишээлбэл: арга, аргын, бага, ботго, гудамж гэх мэт.*

Хэлний угаар хэлэгдэх **г** үсгийг “хэлний г” гэнэ. “Хэлний г” ардаа эгшиггүй юм уу эсвэл а, о, у, ы дөрвөөс өөр эгшигтэй байна.

*Жишээлбэл: аймаг, нутаг, хөрөнгө, цэнгэл, цэцэг, гүйцэтгэх гэх мэт.*

“Хэлний г” үсгийн ард залгавар залгахад а, о, у эгшиг орох боловч “хэлний г” хэвээр байна. *Жишээлбэл: хамаг-хамгаас, тоорцог-тоорцгоор, туг-тугууд, омог-омгорхуу гэх мэт.*



**БОЛСОН ЯВДАЛ, СОНССОНОО ТОДОРХОЙ ЯРЬЖ БИЧЬЕ**

1 Өөрт тохиолдсон зүйлээ бичье.

1) Асуултын дагуу бодож бэлтгэе.

хэзээ

хэн

яагаад

яаж

хаана

юу

**Өөрт тохиолдсон зүйлээ бичихдээ:**

1) Юу тохиолдсоныг бодож төлөвлөнө.

✍ Хаана болсон, хэзээ болсныг

✍ Яг ямар зүйл тохиолдсоныг бодоод, **эхлээд, дараа нь, тэгээд, би, бид** зэрэг үгийг ашиглан бичнэ.

✍ Тохиолдсон зүйлээс ямар сэтгэгдэл төрснөө оруулан бичиж болно.

2 Хичээлийн завсарлагаанаар сургуулийн хонгилд юу болсныг ажиглаад бичээрэй. Асуултаар үгсийг бүлэглээрэй.

*Түяа ингэж бичжээ*

*Ахлах ангийн хүүхдүүд сургуулийн хонгилд ер харагдсангүй. 7б ангийнхан бэлтгэлийн хувцсаа өмсөөд биеийн тамирын заал руу явж байхдаа хөвцүүд нь дээр, цсэрч таазанд хурэхийг оролдож байлаа.*

*Бүгдийг анхааралтай харж, ажиглаж байлаа намайг хэн ч анзаараагүй. Бага*

анийн бололтой хоёр охин гартаа зайрмаг барьчихсан үйлдэж байгаа хүүхдүүдтэй мөргөлдөн зөрнө. Багш ч мөн дундуур нь мөрөө хажуулдасхийн зөрнө. Энэ бүхнийг би өмнө нь төдийлөн анзаарч байсангүй.

- 3 Туяагийн бичсэн зүйл юу бодоход хүргэв? Ярилцъя.
- 4 Сургуулийн цайны газарт юу болж байгааг ажиглаарай. Ажигласнаа сайн тогтоогоод бичээрэй.

*Туяа ингэж бичжээ*

Цайны газарт сурагчид орж ирлээ. Тэд ширээ ширээнд хэд хэдээрээ хуваагдан суугаад зөөлөн зөөлөн ярилцаж байв.

Цай авалицгүй суусаар байгааг нь кассын эмэгтэй ажиглаад л байх юм. Тэгтэл ахиад нэлээд хэдэн хүүхэд орж ирэн хоол цай аваад суух ширээ хайж байлаа. Эхний хэсэг хүүхэд от боссонгүй. Тэд их л чухал яриатай байгаа бололтой хуццугээ сунган ярилцаж байсан. Энэ бүхнийг би сайн ажиглаад ангидаа ирж бичсэн юм.

Сайн бичиж бэлдвэл бусдын өмнө тодорхой ярьж чадна шүү дээ.

- 5 Хаана юу, юу байгааг сайн ажиглавал ойлгож тогтооно. Бас юу, юу болж байгааг сайн ажиглах хэрэгтэй. Өдөр бүр “Болсон явдал” бичиж байгаарай.

**Болсон явдлыг сайн бичихийн тулд:**

- Хаана, хэзээ, хэн, юу, яав, яагаад, ямар учраас зэрэг асуултыг өөрөөсөө асуугаарай.
- Үйл явдал, сонссон зүйлийн талаар хэн нэгнээс тодруулан асуугаарай.

Тэгээд яг юу болсон юм бэ?

Та яаж мэдсэн бэ?

Яагаад тэгэв?

Яг хэзээ болсон юм бол?

Үйл явдал хаана болов?

Хэн хэн байсан бэ?

- 6 Телевизийн мэдээг гурван өдөр дараалан сонсоорой. Юу сонсож тогтоосноо бичиж аваарай. Ярилцаарай.

I баг



II баг



III баг



IV баг



7 Сонгосон сэдвээр ярилцахдаа дараах үг хэллэгийг ашиглаарай.

1 Би энэ тухай сайн мэдэхгүй ч бас ..... ингэж хэлж болмоор байна.

2 Миний ойлгож байгаагаар ..... тухай өгүүлж байна.

3 Би сайн ойлгохгүй бүүр төөрчихлөө.

4 Энэ нь надад, өмнө нь сонссон ..... тухай санагдуулж байна.

8 Зургийг сайн ажиглая.

Ажиглах зүйл:

- Байгаль
- Баатруудын байрлал
- Тэдний хөдөлгөөн



зураг 1



зураг 2

- ✓ Баатруудыг нэрлэе.
- ✓ Юу, юу хийж байгааг жагсааж бичье.
- ✓ Баатрууд юу гэж хэлж байгааг бичье.

- ✓ Баатруудыг нэрлэе.
- ✓ Юу, юу хийж байгааг жагсааж бичье.
- ✓ Баатрууд юу гэж хэлж байгааг бичье.

1) Дараах саналыг хэн, хэн хэлсэн бол?

Юу ч гэсэн оролдоод үз дээ.

Би туслах уу?

Ус тунгалаг байна уу?

Өөрсдөө хийж болно шүү дээ.

Би чадах болов уу?

Зүгээр л ажиглаж байя.

2) Юу болсныг зохиож бичээрэй.



1 Зохиогчийн ба баатрын үгийг ялгаж бичээрэй.

**Хүний сэтгэл санаа**  
(Домог үлгэр)

Эрт цагт хоёр бурхан, хүнийг бүтээжээ. Тэгээд түүний сэтгэл санааг нь ямар болгох тухай ярилцаж гэнэ. Нэг нь “Хун шиг цагаан” болгоё гэж. Нөгөө нь “Хэрээ шиг хар” болгоё гэжээ. Тэгээд нэг бурхан нь:


- Хэрэв хэрээ шиг хар болгочихвол, хүн чөтгөр шулам шиг муухай санаатай болно доо гэхэд, нөгөө бурхан нь:

- Хэрэв хун шиг цагаан болгочихвол, хүмүүс хэтэрхий сайхан санаатай болж, бүх идэх юмаа амьтанд хувааж өгөөд өөрөө өлсөж үхэх болно. Ингэхлээр хүний сэтгэлийг шаазгай шиг алаг хийе гэжээ.

Тийм учраас хүний сэтгэл санаа шаазгай шиг алаг эрээн, хар цагаан болсон гэнэ.

2 Нохойноос айж эмээх үед дүүдээ анхааруулж хэлсэн өгүүлбэр зохиож бичээрэй.

3 Зургийг ажиглаад “Болсон явдал” бичээрэй. Бичсэнээ бусдад тодорхой ярьж өгөөрэй.




4 Телевизээр сонссон ямар нэг зүйлээ гэр бүлийнхэндээ ярихад бэлтгэж бичээрэй.



Анхааралтай  
сонсох, тогтоох



Сайн сонсох,  
ажиглах, тогтоох



Сайн ажиглах,  
тогтоох



## ЧУХАЛ ХЭСГИЙГ ЯЛГАЖ ОЙЛГОЁ



Хамгийн чухал нь  
аль нь юм бол?

Яагаад чухал гэж?



Энэ хэсэг  
сонирхолтой байна.



**СОНИРХОЛТОЙ, ЧУХАЛ ХЭСГИЙГ ТЭМДЭГЛЭЖ ҮНШИЖ БОЛНО ШҮҮ ДЭЭ.**

Сонирхолтой, чухал зүйл юу болохыг ялгах  
Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэх  
Утга ялгасан үгийг алдаагүй зөв бичих



## ЧУХАЛ ХЭСГИЙГ ЯЛГАЖ СУРЪЯ

1 Дараах үгс ямар утгатай байж болохыг бодоод өөрийнхөө саналыг хэлье.

алс бөглүү - дорой - шогло -  
газрын мухар - ад шоо - гарын чилээ -

2 Дараах тайлбарууд аль үгэнд тохирохыг бодож бичье.

сэргэлэн биш дуу цөөн,  
чимээ багатай


хол газар, хүн амьтан  
төдийлөн очдоггүй газар

хол газар

шоолон дургүйцэх

бусдыг зүгээр байлгахгүй, шоолох, шоглох

Хурдан унших харааны дасгал хийе.



3 Утгыг нь мэдэхгүй үгээ сайн тэмдэглэж уншъя.

### Дашинчилэнд суугаа Андерсенд



**Би** багадаа Андерсенийг монгол хүн гэж боддог байлаа. **Би** тэгэхэд хүн бүү хэл шувуу ч цөөхөн үзэгддэг алс бөглүү Бүрэгхангай хэмээх сумын бага сургуульд суралцаж байв. Нэг удаа Дашинчилэн гэдэг газар багш маань явж, Андерсен гэдэг хүний зохиосон үлгэрийн ном авчраад **бид**энд уншиж өгч билээ. Жигтэйхэн сонин. **Тэр дундаа** “Нугасны муухай дэгдээхэй” юу? Яг л намайг дэгдээхэй дүрээр биччихсэн юм шиг санагдана. **Би** түүн шиг юм л бол ад шоо үзэгдэн зодуулж хүүхэд хүүхдийн гарын чилээг нь гаргаж явдаг дорой жаал байв. Андерсен гэдэг хүнийг **би** Дашинчилэнд суудаг юм байх гэж боддог байлаа. Бичсэн үлгэрээс нь үзэхэд их л сайхан сэтгэлтэй хүн

бололтой. Хүүхдэд шоглуулах үед тэр л миний талд орж, нулимсыг минь арчин аргадах болов уу гэсэн бодол төрдөг сөн.

Тэгээд **би** захидал бичиж “Дашинчилэнд суугаа Андерсенд. Булган аймаг Бүрэгхангай сумын бага сургууль Ж.Дашдондоогоос.” гэж хаяглалаа. Дахин гоё үлгэр бичиж өгөөч гэж. Хариу захидлыг хэчнээн их хүлээсэн гээч. Яаж ч ирэх вэ дээ. Хожим мэдэх нь ээ тээр газрын мухарт олон мянган километрийн цаана буй Копенхаген хэмээх хотод, тэгэх тэгэхдээ бүүр зуугаад жилийн өмнө үлгэрээ бичиж байсан хүнээс захидал хүлээж сууж шүү дээ. Харин Дашинчилэн нь манай сумаас ердөө жархан километр зайтай жижиг суурин байсан юм байж.



Ж.Дашдондоо

### Сэргээн санацгаая

- Захидлаа юу гэж хаягласан бэ?
- Үүнийг бичсэн зохиогч хаана амьдардаг байсан бэ?

### Учрыг ойлгож ярилцъя.

- Яагаад дэгдээхэйн дүрээр өөрийг нь биччихсэн юм шиг санагддаг байсан бэ?
- “Нулимсыг минь арчин аргадах болов уу” гэсэн бодол төрдөг байсны учрыг чи юу гэж бодож байна вэ?

- Сүүлийн хоёр өгүүлбэр хол-ойр гэсэн эсрэг утгатай гэвэл чи санал нийлэх үү? Яагаад?
- Зохиогч яагаад “Жигтэйхэн сонин.” гэсэн өгүүлбэрийг хэрэглэсэн юм бол?
- “Тэр дундаа нугасны муухай дэгдээхэй юу?” гэсэн өгүүлбэр чамд ямар бодол төрүүлж байна вэ?



“Нугасны муухай дэгдээхэй” илүү сонирхолтой санагдсан болохоор л “Тэр дундаа нугасны муухай дэгдээхэй юу?” гэж илүү тодруулж бичсэн гэж бодож байна.

### Дараах зохиол, бүтээлүүдээс олж уншаарай.

Ж.Дашдондог: “Хар цагаан шувууны түүх”, “Гурван марал”, “Аав Ээж Би”, “Аранзэл зээрд”, “Чулуун домог”, “Морьтой үлгэр”

Х.Андерсен: “Шүдэнз худалдагч охин”, “Лаа”, “Хааны шинэ хувцас”, “Лусын дагина”

- 4 “Хариу захидлыг хэчнээн их хүлээсэн гээч. Яаж ч ирэх вэ дээ” гэж зохиолч өгүүлжээ. Тэр яагаад ингэж бичсэн бол?

Туяа ингэж бичээд найзууддаа уншиж өгөв.

Андерсен гуайн зохиол маш их таалагдаж байсан болохоор өөр олон зохиолыг нь унших хүсэлтэй байсан. Тийм болохоор зохиолыг нь хүлээснээ “хэчнээн их хүлээсэн гээч” гэж бичсэн байх.

- 5 Дараах үгсийг томоор эхэлж бичсэнийг бодож учрыг хэлье.

Андерсен, Бүрэгхангай, Дашинчилэн, Булган, Дашдондог, Копенхаген, Нугасны муухай дэгдээхэй

Хүний нэр, амьтан, хот суурин, уул ус зэрэг ертөнц дээр ижилгүй юмны оноосон нэрийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Дамдины Сүхбаатар, Улаанбаатар хот, Энх тайвны гудамж, Богд уул, Орхон гол, Шувуун саарал (морь), Банхар (нохой) гэх мэт.

Би үүнийг мэдлээ.

Өөрт тохиолдсон зүйлээ тодорхой ярьж болох юм байна. Ярихдаа газар орны нэр, хүний нэрийг зөв хэлэх ёстой.

**6 Тохиолдсон үйл явдлаас чухлыг ялгаж бичье.**

Тохиолдсон явдал	Төрсөн сэтгэгдэл
Бүрэгхангай сумын бага сургуульд суралцаж байв. Нэг удаа Дашинчилэн гэдэг газар багш маань явж Андерсен гэдэг хүний зохиосон үлгэрийн ном авчраад бидэнд уншиж өгч билээ.	..... ..... .....

**7 “Дашинчилэнд суугаа Андерсенд” эхээс чухал хэсгийг ялгаж бичээрэй.**

**Эхлэл хэсгээс**

**Гол хэсгээс**

**Төгсгөл хэсгээс**

.....

.....

.....

**8 Яагаад чухал гэж байгаагаа тайлбарлана уу? Жишээ нь:**

Андерсен гэдэг хүний зохиосон үлгэрийн ном авчраад **бидэнд** уншиж өгч билээ. Жигтэйхэн сонин.

Яагаад гэвэл .....

**Чухлыг мэдэхийн тулд тэмдэглэн уншиж болно.**

**Яагаад тэмдэглэж унших хэрэгтэй вэ?**



Сонирхолтой санагдсан хэсгийг эргэж хайдаг.

Чухлыг нь мэдэх хэрэгтэй болдог.



Сайн ойлгоогүйг зурж болно. Дараа нь асууж мэднэ.

Чухал үг, өгүүлбэрийг дахин харах болдог.



1 Шүлгийг уншиж ойлгоё.

Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй

Талын шувуудын өндгөнд  
Сүүдрээ бүү хүргээрэй.  
Ташуурын сүүдэр шүргэх төдийд  
Үрээ тэд голдог гэнэ.

Хээрийн салхины хөл дор  
Хэдэн өндөг хоцордог гэнэ.  
Тэнгэрт нисэх тавилангүй  
Тэндээ яг төгсдөг гэнэ.

Хөдөөгийн сэлүүнд өнгө хорших  
Хөгжмийн утас тасардаг гэнэ.  
Баян талын минь ая эгшиг  
Бас түүгээр дутдаг гэнэ.

Сүр хүчит хүн танаа хүсэх минь  
Сүүдрээ хямгадаж яваарай  
Тайван нар тэнгэрт налайж  
Тал нутагт шувууд жиргэг. *Д.Нямаа*



Талын шувуудын өндгөнд  
Сүүдрээ бүү хүргээрэй.  
Ташуурын сүүдэр шүргэх төдийд  
Үрээ тэд голдог гэнэ

Сонирхолтой хэсгээ ✓ ингэж  
тэмдэглэж болно.

— Үгийн утгыг мэдэх хэрэгтэй  
учраас ингэж тэмдэглэж болно.

2 Бурмаагийн тэмдэглэж уншсан үгийн утгыг яаж мэдэж болох вэ?

1) Тэдгээр үгийн утгыг өөрийнхөө ойлгож байгаагаар хэлье.

Бурмаагийн санал:

салхины хөл доор\* гэсэн үгийн утгыг би ингэж ойлгож байна.  
Салхи хөлтэй биш шүү дээ. Харин салхилахад газар байгаа  
өндөгнүүдэд салхи хүрч байдаг гэдгийг ингэж хэлсэн байх.



Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
сэлүүн		чөлөө зайтай
хямгадах		юмыг хайрлаж хамгаалах, өөд татах, хэмнэх

Сэргээн саная

- Энэ шүлэгт юуны тухай бичсэн байна вэ?

Учрыг ойлгож ярилцъя.


- Шувууд яагаад үрээ голдог вэ?
- Баян тал эгшгээр дутдаг гэсний учир юу вэ?

3 Шүлгийг цээжилж хэн нэгэнд уншиж өгье. Тэгэхдээ сонссон хүний сэтгэл ямар болохыг төсөөлөн бодъё. Яаж уншиж өгөх вэ?

Талын шувуудын өндгөнд  
Сүүдрээ бүү хүргээрэй.  
Ташуурын сүүдэр шүргэх төдийд  
Үрээ тэд голдог гэнэ.


Хээрийн салхины хөл доор  
Хэдэн өндөг хоцордог гэнэ.  
Тэнгэрт нисэх тавилангүй  
Тэндээ яг төгсдөг гэнэ.

Хөдөөгийн сэлүүнд өнгө хорших  
Хөгжмийн утас тасардаг гэнэ.  
Баян талын минь ая эгшиг  
Бас түүгээр дутдаг гэнэ ✓



Өрөвдөх сэтгэл	Зөөлөн дуугаар, өрөвдсөн царайгаар хэлье.
Зовнисон сэтгэл	.....
.....	Харамссан байдлаар анхааруулж хэлье.

4 Шүлгээс мэдэж авсан чухал зүйлийг жагсаан бичье. Яагаад чухал болохыг тайлбарлая.



5 Дараах эхийг уншаад асуултад хариулж ярилцаарай.

- 1) Дамдин гуай яах гэж нар мандаж байхад явдаг вэ?
- 2) Дамдин гуай яах гэж өндөг авчирдаг вэ?
- 3) Дамдин гуай яагаад “Зэрлэг нугасны өндөг” гэж хэлдэг вэ?

Эх шувуу их зүдэрдэг юм гэнэ лээ...



... “Молоко” Дамдин гуай нар дөнгөж мандаж байхад урт түрийтэй усны гутал өмсөж, томоо гэгч аранз мөрөндөө углаад чийгийн улаан хорхой хийсэн сав, арвын ногоон хувин таглаж аваад Хараа юм уу, Ерөө эсвэл Сэлэнгэ рүү арилж өгнө.

... Ногоон хувингаар дүүрэн бор цоохор өндөг авчирна. Эмгэн нь ихэд дургүйцэн “Зэрлэг шувууны өндөг түүж, эх амьтны голыг харлуулаад яах гэсэн юм бэ? Эх шувуу их зүдэрдэг юм гэнэ лээ. Энийг чинь хэн идэх юм бэ?” гэхэд

Дамдин гуай “Маргааш Дархан орохдоо хүүхдүүддээ тарааж өгнө.” гэх. “Ямар шувууны өндөг болохоороо ийм элбэг, тэгээд том байдаг юм бэ?” гэж эмгэн нь шалгаахад, “Зэрлэг нугасны өндөг” гэж Дамдин гуай хэнэггүй хэлэв.

“Хэзээ зэрлэг нугас өндгөө сайр чулуун дээр унагаж байсан юм бэ? Наадах чинь явж явж тогорууны өндөг л болж таарлаа. Тогоруу чинь их цэвэрч шувуу гэсэн шүү дээ. Хүний сүүдэр туссан л бол өндгөө голдог юм гэсэн. Тогоруу нэг хараавал төмөр дөрөө сэтэртэл хараадаг юм гэсэн ардын үг бий. Дахиж өндөг битгий авчраарай гэхэд Дамдин гуай ихэд гэмшин толгой дохив.

<http://www.wikimon.mn>

6 Чухал хэсгийг ялгаж бичээрэй.

2 Тэр чухал зүйлийн талаар өөр мэдээлэл цуглуулна.

3 Шүлэгт байгаа чухал зүйлээ цуглуулсан мэдээлэлтэйгээ холбож ноороглон бичнэ. Мөр хооронд зайтай бичнэ.

4 Ноороглон бичсэнээ засаж сайжруулна. Мөр хоорондын зайнд нь нэмж бичиж болно.

Ноорог:

*Өндгөнд сүүдрээ хүргэж болохгүй.*

*Өндгөө голдог.*

*Ээжийнх нь гол харладаг.*

Сайжруулсан нь:

*Шувууны өндгөнд сүүдрээ тусгаж болохгүй.*

*Хэрэв сүүдэр туссан л бол эх нь өндгөө*

*голдог юм гэсэн. Тэгээд л Эх амьтны гол нь харлаж үрээ орхидог.*

5

Бичсэнээ найзууддаа уншуулна. Гэр бүлийнхэндээ уншиж өгнө. Цахимд нийтэлнэ.




## УНШСАН ЗОХИОЛЫН ТАЛААР СЭТГЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЖ БИЧЬЕ

1 Уншсан зохиолуудаа сэргээн саная. Зохиолоос чамд ямар сэтгэгдэл төрж байгаагаа хоёр өгүүлбэрээр бичье.



“Дашинчилэнд суугаа Андерсен”

.....  
.....



“Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй”

.....  
.....



“Эх шувуу зүдэрдэг юм гэнэ лээ...”

.....  
.....



“Эцгийн захиас”

.....  
.....

### Сэтгэгдэл бичих:

- Чухал гэж зурсныг сонгож болно.
- Зохиогчийн үгийг сонгож болно.
- Баатрын үгийг сонгож болно.
- Баатрын зан чанарыг сонгож болно.
- Үйл явдлыг сонгож болно.
- Зохиолыг бүтнээр нь авч болно.

- Сонгосон хэсгээ эхэнд нь бичнэ.
- Яагаад сонгосон шалтгаанаа бичнэ.
- Түүнээс төрсөн сэтгэгдлээ бичнэ.

бахархах, гайхах, эргэлзэх, баярлах, гуних, өхөөрдөх, өрөвдөх, хайрлах, уйтгарлах, харамсах, омогших илүү их хичээх, бусдад туслах, дахин судлах ... гэх зэргээр янз бүрийн сэтгэгдэл төрж болно.

2 Үлгэрийг уншиж ойлгоё.

### Хүн тариа тарих болсон нь

(Домог үлгэр)

Эрт цагт хүн тариа тарьдаггүй тул зөвхөн махан хоол иддэг байжээ. Усны шувууд намар болоход үр өндгөө усан дотор үлдээж, дулаан орондоо өвөлжөөд, хавар болохоор түүнээ үзэхээр баяр хөөртэй буцаж ирдэг юм гэнэ.

Шувууд ингэж орхихдоо гунигтай болдог тул намрын шувуу бэлгэгүй, хаврын шувуу бэлгэтэй гэж ярьдаг байв.



Дулаан орноос ирж байгаа сүрэг усны шувууг харсан бүсгүй өөдөөс нь сүүн цацал өргөсөнд шувууд баярлан ганганалдаж, гэрийнх нь дээгүүр удтал эргэлдэж байгаад явав.

Удалгүй намар болж шувууд буцахаар явж байхдаа мөн л таарч, баярлан түүний толгой дээгүүр эргэлдэн ниссэн боловч бүсгүй “Намрын шувуу бэлгэгүй” гэж бодоод цацал өргөсөнгүй. Шувууд хэсэг эргэлдэж байснаа нэг ууттай юм цацчихаад нисэн оджээ.

Дараа жилийн хавар болж сүрэг шувууд ирдгээрээ



ирж бүсгүй ч сүүгээ өргөж, намар болоход шувууд ч буцдагаараа буцаж гэнэ.

Намрын налгар сайхан өдөр нөгөө шувуудын цацсан юм нь халиурсан тариа болон ургасан байхтай таарчээ. Бүсгүй баярлан хөөрч, тариаг хурааж аваад гурил будаа гарган авчээ.

Үүнээс хойш хүн тариа тарьдаг болсон бөгөөд тарианы үрийг анх усны шувууд л хүнд өгсөн юм гэдэг.

### 3 Ойлгохын тулд зөв хариултыг олж тайлбарлаарай.

1) Усны шувууд яах гэж буцаж ирдэг вэ?

- ✓ Хавар болсон учраас
- ✓ Намар болсон учраас
- ✓ Үлдээсэн үр өндгөө үзэх гэж
- ✓ Тарианы үр өгөх гэж

2) Усны шувууд яагаад ганганалдан эргэлдсэн бэ?

- ✓ Гэрийг харсан болохоор
- ✓ Дулаан орноос ирсэн болохоор
- ✓ Сүүн цацал өргөсөн болохоор
- ✓ Бүсгүйг харсан болохоор


### 4 Төрсөн сэтгэгдлээ бичье. Сурагч дараах өгүүлбэрийг чухал гэж сонгожээ. Тэгвэл энэ өгүүлбэрээс үүдээд ямар сэтгэгдэл төрснөө бичнэ үү.

*Усны шувууг харсан бүсгүй өөдөөс нь сүүн цацал өргөсөн.*



*Шувууд хэсэг эргэлдэж байснаа нэг ууттай юм цацгихаад нисэн оджээ.*


### Зохиолын талаар сэтгэгдэл бичих арга:



5) Найзуудад өөр өөр өгүүлбэр чухал байгаа. Тиймээс тэдний бичсэнийг сонсьё.

1) Ийм сэтгэгдэл төрсөн бол ямар өгүүлбэр чухал санагдсан байж болох вэ?

.....  
Хүмүүст маш их тус хүргэсэн учраас тэр шувуудад бид баярлах ёстой гэж бодож байна.



2) Чухал санагдсан өгүүлбэрийг олоод төрсөн сэтгэгдлээ бичээрэй.

.....  
Яагаад гэвэл .....



6) Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ бичээрэй.



Уншсан номын тэмдэглэлээ ашиглаж бичих нь үр дүнтэй шүү.


Хэрэв уранзохиол бол:

- Чухал зүйл
- Таалагдсан баатар
- Гэнэтийн сонирхолтой үйл явдал
- Чухал үг хэллэг
- Зохиолын баатар

Энэ нь чамайг:

- Баярлуулсан уу?
- Гуниглуулсан уу?
- Гайхахад хүргэсэн үү?
- Уйтгартай болгосон уу?
- Илүү ихийг судлахад хүргэсэн үү?
- Яагаад чухал байна вэ?

Яагаад?



- 1 Өөр өөр утгатай баг – бага, араг – арга, тараг – тарга, уураг – уурга, буг – буга, алаг – алга зэрэг үгсэд оньсогоны хариу байгааг олъя.

Навтгар эмгэн  
Наян хумстай

Ижийн өгсөн тос  
Идэхэд хол

Гэрт багтдаггүй  
Гарт багтдаг

Малигар хүүгийн толгойд  
Маргад эрдэнэ хатгаатай

Тэр юу вэ?

- 2 Зургийн нэрийг яаж бичих нь зөв бэ? Үг бүрийн утгыг найздаа хэлж өгье. Хэлэхэд бас бичихэд ялгаатай байгааг ярилцъя.



баг – бага



тараг – тарга



уураг – уураг



алаг – алга

- 3 Үгийг чанга тод хэлье. Ардаа «а», «о» эгшигтэй «г» гийгүүлэгчийг яаж дуудах вэ?

даага  
чарга  
шанага  
хаалга  
аянга  
хурга  
унага  
тулга  
туурга  
шуурга  
хуулга

дуулга  
цорго  
ботго  
торго  
тотго  
босго  
хорго  
хонго  
тоосго  
солонго

Аль оньсогоны  
хариу вэ?

тулга, босго  
тотго, аянга  
цахих, шуурга

Харалдай ноёны  
Харвасан сум  
Манжийн газраас  
Төвдийн газарт хүрнэ.

Гунжин үхэр  
Гурван хөлтэй

Тал дээгүүр талийна  
Ташуургүй жилийнэ.

Манай бурхан ширээн дээр  
Танай бурхан шороон дээр



## ЮУ ОЙЛГОСНОО ШАЛГАЯ

### Харамсахгүй байхын тулд ...

Сурагч байхдаа унших ёстой олон зүйлийг уншихгүй өнгөрвөл хожим дэндүү харамсана.

Том амжилтад хүрсэн хүмүүсийн дийлэнх нь маш их үгийн баялгаар ярьдаг давуу талтай ажээ. Тэд яаж тийм их үгийн утга мэдэж сайн ярьж чаддаг болсон юм бол?

Тэд маш их ном уншдагт л байгаа юм. Илүү олон үгийн утгыг сайн мэдэж гайхалтай ярих бичих чадвартай болохын тулд ном унших нь ээ. Уншихдаа утгыг сайн мэдэхгүй үг таарвал зогсож, толь бичгээс харна. Толь бичигт нэг үг хэдэн утгатай байх нь бий. Түүнээс чухам ямар утга нь энэ өгүүлбэрт байгаа бол гэдгийг ойлгох хэрэгтэй.

Бас ном уншихдаа өөрөөсөө дараах гурван асуултыг асууж үзээрэй.

- ✍ Яагаад унших гэж байгаа билээ?
- ✍ Үүний гол санаа юу вэ?
- ✍ Хамгийн чухал зүйл нь юу вэ?

Өмнөө санамсаргүйгээр таван ном тавиад суу. Тэдгээрийг нэг нэгээр нь авч гүйлгэн хараад энэ гурван асуултын хариуг тэмдэглэж бичээрэй.

Энэ гурван асуултад хариулж чаддаг болохын тулд өдөр бүр хэдэн ном сонгож аваад, түүнийгээ эргүүлэн харж дасгал хийгээрэй.

### 1 Эхийг уншаад ойлгосон чухал зүйл юу вэ? Төрсөн сэтгэгдлээ бичье.

- Чухал нь  
- .....

✍ Яагаад чухал гэж?  
✍ .....

### 2 Дараах эхийг уншиж ойлгоё.

Би зурагт таавар эвлүүлэх дуртай. Гэхдээ нэг хоёр дүрсийн байрыг олж чадахгүй л бол залхуурч, орхидог. Маргааш нь дахиад л эвлүүлнэ, бас л орхино. Тэгээд ном уншина. Бас л залхуурч дутуу уншаад орхидог. Номоо дуустал уншихын тулд яах ёстойг ахаасаа асуулаа. Ах:

- Ном уншаад ойлгохгүй зүйл гарахаар л орхиж байгаа хэрэг. Чи ямар үед номоо дуусгахгүй орхидог вэ?
- Тийм шүү. Үнэхээр, үгийн утга ойлгохгүй болонгуут л залхуу хүрдэг. Тэгвэл тэр ойлгохгүй байгаа үгийг толь бичгээс харж мэдэж болно шүү дээ.
- Өө тэгээд хоёр ном зэрэг унших юм уу?
- Хэ хэ. Залхуурч байгаа хүнд дахиад үг хэлэхийн хэрэг байна уу? гэхэд нь би буруу зүйл хэлснээ мэдлээ. “Яагаад болохгүй гэж. Тайлбар толиос үгийн утга хайж үзье.” гэж хэллээ.

1. Чухал үг, өгүүлбэрийг сонгож аваарай.
2. Энийг яагаад чухал гэж авснаа тайлбарлан бичээрэй.
3. Эндээс ямар сэтгэгдэл төрснөө бичээрэй.

### 3 Үгийг нөхөж бичээрэй.



араг

..... ухаан



тараг

..... хүч



уураг

..... хийх

# ҮЙЛ ХӨДЛӨЛИЙН ҮЧИР ШАЛТГААНЫГ ТАЙЛБАРЛАЯ



Хэн, хэн  
юу хийсэн бол?



Баатруудын үйл  
хөдлөлийг мэдье.



Шалтгааныг  
тэмдэглэж мэдье.

## ҮЙЛ ЯВДАЛЫН ҮЧИР ШАЛТГААНЫГ ОЛЖ ЧАДВАЛ ЗОХИОЛЫГ ОЙЛГОНО.

- Зохиолд ямар, ямар үйл явдал болсныг мэдье.
- Яагаад ийм үйл явдал болсны шалтгааныг олъё.


Баатруудын үйл хөдлөл, хэлсэн үгийг ялгах  
Баатруудын үйл хөдлөлийн шалтгааныг тайлбарлах



## БААТРЫН ҮЙЛИЙГ ХӨӨН УНШИЖ, ШАЛТГААНЫГ ОЙЛГОЦГООЁ

### 1 “Богинохон нөхөрлөл” зохиолыг уншиж ойлгоё.

- 1) Зохиолд ямар, ямар баатрууд байгааг мэдье.
- 2) Баатруудын үйлийг ялгаж мэдье.



#### Үгийн утга:



**амьтан** - хээрийн муур, тэжээвэр муурнаас том, өнгө шаравтархан, бидэртэй.



**амьтан** - суусрын язгуурын хөхөөр өсөх араатан, ойд оршдог, өвөл ичнэ.



**амьтан** - .....

.....

.....



**амьтан** - нүд том, хошуу махир, шөнө дуугаран явдаг махчин шувуу

### Богинохон нөхөрлөл

#### Мануул, харх хоёрын үйл хөдлөлийг хөөж уншаарай.

<p>I</p> <p>Нэгэн модны ёроолд мануул, дорго, харх гурав амьдардаг. Модны дээр нэг ууль шувуу амьдардаг байж гэнэ. Ууль нь мануулаас, дорго нь мануул, ууль хоёроос, харх гурвуулангаас нь айдаг байжээ. Нэг өдөр мануул модны доор тавьсан анчны торонд орчихжээ. Мануулын торонд орсныг харсан харх ихэд баярлан дуулж бүжиглэж гарлаа.</p>	<p><b>Харх юуны учир баярласан бэ?</b></p>
---	--

- Энэ хүртэл уншсанаа сайн ойлгохын тулд асуулт зохиож үзье.
- Бусдын зохиосон асуултад хариулж ярилцъя.

#### Дорго, ууль хоёрын үйлийг хөөж уншъя.

<p>II</p> <p>Дараа нь дорго, ууль хоёр ирж, хөөрөн баясаж буй хархыг харжээ. Харх тэр хоёрыг хараад, намайг барьж идэх нь гэж үхтэл айв. Тэгээд яахаа бодож гэнэ. Энэ хоёр намайг отож байгаад барих тул нүхэндээ орж болохгүй гэж харх сэтгэв. Мануул миний дайсан боловч одоо ганцаараа, тэгээд ч торонд орчихсон, харин ууль, дорго хоёр хамтдаа байгаа, хоёулаа миний дайсан гэж харх сэтгээд, тэр даруй амиа аврах ажиллагаа хэрэгжүүлэв.</p>	<p><b>Харх яагаад амиа аврах ажиллагаа хийхээр болсон бэ?</b></p>
--	---

- Энэ хүртэл уншсанаа сайн ойлгохын тулд асуулт зохиож үзье.
- Бусдын зохиосон асуултад хариулж ярилцъя.

### Дорго, ууль, мануул гурвын үйл хөдлөлийг хөөж уншъя.

III	<p>Тэгээд азаа туршиж мануулын торонд орчихжээ. Мануул хархыг тэр дор нь идэхийг завдтал харх өгүүлэв.</p> <p>- Намайг идэхээ азна. Намайг амьд үлдээвэл би торыг хурц шүдээрээ тас хазаж чамайг аварна.</p> <p>Мануул торноос яаж гаръя даа хэмээн бодолд автаж байсан тул хархыг идэхээ азнав. Дорго, ууль хоёр нөгөө хоёрыгоо торонд орсныг хараад яваад өгчээ. Харх торыг мэрг таслан хоёул чөлөөтэй болов. Харх даруй нүхэндээ шургалаа.</p>	<p><b>Мануул хархыг идэхээ азнасан шалтгаан нь юу вэ?</b></p>
-----	---	---

- Энэ хүртэл уншсанаа сайн ойлгохын тулд асуулт зохиож үзье.
- Бусдын зохиосон асуултад хариулж ярилцъя.

### Мануул, харх хоёрын үйл хөдлөлийг хөөж уншъя.

IV	<p>Мануул маргааш нь хархтай уулзахаар иртэл, харх:</p> <p>- Чи миний дайсан болохоор би чамтай уулзахгүй гээд нүхнээсээ гарч ирсэнгүй.</p> <p>• Чи яагаад надтай уулзахгүй байгаа юм бэ? Бид хоёр өчигдөрхөн л найз байсан шүү дээ.</p> <p>- Бид хоёр түр зуур л найз болсон юм. Би чамайг торноос гаргасан, чи намайг үхэх аюулаас аварсан.</p> <p>• Тэгвэл бид найз юм байна шүү дээ.</p> <p>- Үгүй ээ, дайснууд хэзээ ч дайсан хэвээрээ байдаг, нөхөрлөл бол түр зуурынх. Тиймээс урьдын адил л амьдарцгаая.</p>	<p><b>М а н у у л хархтай уулзах гэж ирсэн шалтгаан нь юу вэ?</b></p> <p>• <b>“..урьдын адил амьдарцгаая” гэж хэлсэн нь ямар учиртай вэ?</b></p>
----	--	--

- Энэ хүртэл уншсанаа сайн ойлгохын тулд асуулт зохиож үзье.
- Бусдын зохиосон асуултад хариулж ярилцъя.



Аль нэг баатраар хөөж уншихад тэр ямар, ямар үйл хөдлөл хийсэн нь мэдэгдэнэ. Түүнээс шалтгааныг олж болно.



Уншсан даруйдаа тунгаан бодож бичвэл сайн хийж чадна.

### Яагаад?



Үйл хөдлөлийг мэдвэл шалтгааныг хайж олж болно.

2 Баатрууд ямар, ямар үйл хөдлөл хийснийг гүйцээж бичье.

харх	дорго	мануул	ууль
баярлах дуулах - бүжиглэх .....	ирэх харах .....	орох идэх .....	ирэх харах .....

3 Үйл хөдлөл ба шалтгааныг зохиолоос олж бичээрэй.

I Харх юуны учир баярласан бэ?

шалтгаан нь:

Мануул торонд орсон.

үйл хөдлөл нь:

Баярлан дуулж бүжиглэсэн.

II Харх яагаад амиа аврах ажиллагаа хийхээр болсон бэ?

шалтгаан нь:

.....

үйл хөдлөл нь:

.....

III Мануул хархыг идэхээ азнасан шалтгаан нь юу вэ?

шалтгаан нь:

.....

үйл хөдлөл нь:

.....

IV Мануул хархтай уулзах гэж ирсэн шалтгаан нь юу вэ?

шалтгаан нь:

.....

үйл хөдлөл нь:

.....

4 Зохиолын IV хэсэгт байгаа баатруудын харилцан яриаг уншаад тэр хоёрт хэлмээр байгаа үгээ бодож бичье.

Нөхөрт тус хийхэд  
Үеэ дуустал мартаггүй.

Үнэхээр тусалснаа муулбал  
Үйлс үл бүтнэ.

Нөхөр нөхөртөө тустай  
Нөхөөс дээлэндээ тустай.



Энэ үгийг хэнд нь хэлэх вэ?

..... гэсэн үгийг .....-д биш харин .....-д зориулан хэлмээр байна. Учир нь ..... сайхан сэтгэлийг ойлгохгүйгээр урьд өмнөх муу зангаа харуулж байна. Тэр ..... торондоо оруулсан, бас түүнийг идээгүй шүү дээ.

Аль нь амьтны нэр вэ? **ХАРХ - ХАРАХ**



### 1 “Битгий ай” зохиолыг уншиж ойлгоё.

#### Битгий ай

Намрын дунд сар гарлаа. Налгар шар нар ээж, хэдэн өдөр зун мэт байв. Хичээл сургуулиасаа ирсэн хүүхдүүд гэрт орохоо мэдэхгүй гадаа тоглоцгооно. Нар шингэж, эхний од тэнгэрт гялалзах үеэр Идэр гэртээ орж, гар нүүрээ угаав. Тэр оройн хоолоо хүртчихээд дахиад гадаа тоглохоор гарчээ. Эмээ нь түүнийг сүртэй гэгч нь дуудаад, дахин дахин гараад байхгүй шүү. Одоо болно оо. Би хаалга үүдээ түгжлээ шүү гэв.

- Эмээ минь! Намайг байхад битгий ай гэж баатар эрийн царай гаргав. Хуруун чинээ зээ хүүгийнхээ тэгж хэлэхийг сонсоод, тэсгэлгүй инээд алджээ.

- Юундаа инээгээд байна вэ? Би чинь гуравдугаар ангийн сурагч, эр хүн мөн үү? гэхэд нь бүр ч инээд нь хүрч:

- Эр хүн минь, ороо засаад унт гэвэл Идэр хүү:

- Үгүй би таны хажуугаар унтана. Өнөө шөнө тэнгэр дуугарч, бороо орох шинжтэй байна гэжээ.

### 2 Дараах үйл хөдлөлийн шалтгааныг зохиолоос олж бичээрэй.

#### Шалтгаан нь:

- .....
- .....
- .....
- .....
- .....

#### Үйл хөдлөл нь:

- Хүүхдүүд гадаа тоглоцгооно.
- Гэртээ орж ирсэн.
- Дахин гараад байхгүй шүү гэж эмээ хэлсэн.
- Эмээ инээд алдсан.
- Таны хажуугаар унтана.

### 3 “Битгий ай” зохиолд өгүүлсэн шиг өөрт тохиолдсон зүйлээ бодож бичье.

✍ Хэзээ, хаана болсныг

✍ Юу, юу болсныг

✍ Яагаад айснаа бодож бичнэ.

### 4 Хүүгийн дуу хоолойг дуурайн хэлээрэй.

✍ Намайг байхад битгий ай.

✍ Үгүй ээ, би таны хажуугаар унтана.

✍ Өнөө шөнө тэнгэр дуугарч, бороо орох нь.




Ямар дуу  
хоолойгоор  
хэлсэн бол?



## СОНСООД ШАЛТГААНЫГ ОЙЛГОЖ, ЯРЬЖ СУРЦГААЯ

1 Зургийг сайн ажиглаад юуны тухай байж болохыг таамаглаж ярилцаарай.



2 “Жинхэнэ найзууд” үлгэрийг сайн сонсоод, утгыг ойлгоё. .

3 Утгыг мэдэхгүй үгийг бичиж авъя.

4 Бичсэн үгийнхээ утгыг мэдэхийн тулд:

- 1) Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай сонсьё.
- 2) Үгийн утгыг өөрийнхөө ойлгосноор бичээд үзье.
- 3) Энэ үгийнхээ утгыг толь бичгээс олж, өөрийнхөө бичсэнтэй харьцуулъя.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
өчүүхэн	маш жижигхэн	.....
базаахгүй юм	.....	.....
.....	.....	.....

4) Утгыг мэдсэн бол үгээ оролцуулаад өгүүлбэр зохиож бичье.

*Би найзыгаа удаан хүлээлгэсэн нь тун базаахгүй юм болсон доо.*

*Хүлээлгэсэн нь сайнгүй тул гэмисэн сэтгэлээр хэлж байна.*

5 Үлгэрийг сонсоод, асуултад хариулж ярилцъя.

- Гурван найз нь яагаад бугын төлөө санаа зовсон бэ?
- Бугыг яаж аварсан бэ?
- Хүний хөлийн чимээ гарчээ. .... гээд дараа нь юу болсон бэ?
- Бугыг тэгж хэлснээс хойш анчин ямар, ямар үйл хийсэн бэ?

6 Баатруудын чухал үйл хөдлөлийг уншаад, нийлүүлж бичье.

баатрууд	хэрээ	хулгана	буга	яст мэлхий	анчин
чухал үйл хөдлөл нь:	Торонд орсон бугыг харсан. .....	Торыг мэргэ тасалсан. .....	Буга анчны торонд орсон. .....	Толгой хөлөө нуух гэсэн. .....	Амьтанд тор тавьсан. .....

7 Бичихийн өмнө үйл хөдлөлийн дарааллыг гүйцээ.

хэрээ	хулгана	буга	яст мэлхий	анчин
3. Торонд орсон бугыг харсан. 4. Хулгана яст мэлхий хоёрт хэлсэн.	..... ..... ..... .....	2. Анчны торонд орсон. ..... ..... .....	..... ..... ..... 16. Алга болсон.	1. Амьтанд тор тавьсан. ..... ..... .....

8 Үйл хөдлөлийн шалтгааныг зөв тохируулъя.

Үйл хөдлөл

- Хулгана торыг мэрэв.
- Буга анчныг гүйцэж очив.
- Анчин хойноос нь хөөлөө.
- Яст мэлхий алга байв.

Шалтгаан

- 4 найз нэгийгээ аюулд орвол аварч чаддаг учраас мэлхийг аварсан.
- Бугыг барих гэж.
- Бугыг суллах гэж.
- Анчны анхаарлыг өөр тийш болгох гэж.

9 Үлгэрээр бидэнд юу сургамжилсныг яаж мэдэх вэ?

- Баатруудын хийсэн үйлийг бичье. Тэр үйлийн сургамжтай зүйл нь юу вэ?

Яст мэлхий ямар, ямар үйл хөдлөл хийсэн бэ?



Хэрээний нуруун дээр суусан. ⇒ Хамаг хурдаараа мөлхсөн. ⇒ Толгой, хөлөө хуяган доогуураа нуусан. ⇒ Алга болсон.



..... сайн үйл. Яагаад гэвэл тэр бусдын төлөө зөв сэтгэлтэй байсан учраас. Сургамжтай зүйл нь ...

- Хэрээний үйл хөдлөлийг бусад хүүхэд яаж ялган бичсэнийг ярилцъя.
- Өчүүхэн хулганы үйл хөдлөлийг бусад хүүхэд яаж ялгаж бичсэнийг ярилцъя.
- Бугын үйл хөдлөлийг бусад найзууд яаж ялгаж бичсэнийг ярилцъя.

10 Анчин дараах үйл хөдлөлийг яах гэж хийсэн бэ? Шалтгааныг олж бичье.

- Амьтанд тор тавьсан.
- Яст мэлхийг цүнхэндээ хийчихсэн.
- Бугыг хараад цүнхээ газарт тавьчихсан.
- Бугыг хойноос нь хөөсөн.
- Бугыг гүйцээгүй.
- Буцаж ирсэн.
- Яст мэлхий байхгүй байсан.



Тэнгис ингэж ярьсан.



Бугыг дахин барихыг бодсон учраас

түүнийг хараад цүнхээ газарт тавьчихсан.

Найзынхаа ярьсныг сонсоод Эрхэс бас ингэж ярив.



Тэгээд агнахыг бодсон учраас

бугыг хойноос нь хөөсөн.

11 Эдгээр үгийг аль баатарт хэлэх вэ? Яагаад?

• Шунал ихэдвэл  
Шулам болно.

• Уулын буга хараад  
Унасан бухаа орхих”

12 Хулганы үйл хөдлөлийн чухал нь аль вэ? Эргэцүүлэн бодоод бичье.

1. Бугын төлөө санаа зовсон.



3. Бугыг аврахын тулд торыг тас мэрсэн.

2. Яст мэлхийг аврахын тулд очсон.

Эдгээр үйлээс аль нь чухал болохыг бодож үзэхэд 2 ба 3 нь илүү чухал байна. Яагаад гэвэл санаа зовоод зүгээр орхиогүй, жинхэнэ тус хийсэн.

13 Бусад баатрын үйлээс чухлыг ялгаж тайлбарлая.

14 Анчин яагаад ганцаараа эсрэг талд зогсож байгаа шалтгааныг тайлбарлаж бичье.




.....



.....



.....



**Бодох зүйл:**

Эхлээд гарчгийг сайтар бодож уншаад утгыг нь сайн ойлгоё. Баатруудын үйл хөдлөлөөс чухлыг нь бичнэ. Тэдгээрээс хамгийн чухлыг нь бичиж болно.

15 “Жинхэнэ найзууд” үлгэрийг дахин саная. Утгыг бодож нөхөж бичье.

*Хэн? амьтанд тор тавьсан. Юу? анчны торонд орсон. .... торонд орсон бугыг харсан. Хулгана яст мэлхий хоёрт хэлсэн. .... тасалсан. Буга суллагдсан .... Зугтаарай ..... Толгой, хөлөө нуух гэж байгаад ..... Хэрээ ..... харж байсан. Нөгөө хоёртоо хэлсэн. Анчныг гэртээ харихаас өмнө ..... Яст мэлхийг анчин аваад явахад ..... Бугыг хараад ..... тавьчихсан. .... хойноос нь хөөсөн. .... алга болсон байлаа.*

Үйл хөдлөлийн шалтгааныг бичихдээ: Яагаад гэвэл, учраас, тэгсэн болохоор, тиймээс, учир нь гэх мэт үгийг хэрэглэж болно.

16 “Богинохон нөхөрлөл”, “Жинхэнэ найзууд” зохиолыг номын тэмдэглэлдээ бичье. Бичсэн тэмдэглэлээ яах билээ?

Би дугуйлангийн найздаа уншиж өгнө.




Би бичсэн зүйлүүдээ цэгцэлж хадгална.

Би аав ээждээ уншиж өгнө.

- 1 “Нүдүүрийн дуу” зохиолыг уншиж ойлгоё.
- 2 Уншихдаа утгыг мэдэхгүй үг байвал ✓, —, | тэмдэглэж уншъя.

### Нүдүүрийн дуу



Монгол ахуйгаас хэчнээн **төсөөрснөө** ижийтэйгээ золгохоор ирэхдээ л мэдэв. Намайг өндийх зуур “Ээж нь хүүгээ сэрээхгүй гэж их л аяархан нүдсэн юм сан” гэж гэмшингүй өгүүлээд, “Энэ муу **уур нүдүүр** хоёр уу, чанга дуутай гэдэг нь” гэж амандаа үглэв.

- Ээжээ, манай энд уур нүдүүртэй айл олон уу?
- За даа, бид мэтийн **хөгшчүүлд** л байхаас залуу айлд бол ч ховор доо.
- Дэлгүүрт төмөр уур нүдүүр зөндөө л байдаг шүү дээ.
- Хэ цэс, ямар юмных нь уур гэдэг юм. Хүнд, зай муутай, дуу нь хүртэл чол чол гээд нэг л...

- Дуу ямар хамаатай байна аа?
- Ишш хүү минь. Биднийг бага залуу байхад “Тэдний уур сайхан дуутай, эдний уур сайхан **хэвтэй**” гээд л ярилцах. Айлын **эзэгтэй** нар бусдаас эрт цайгаа нүдэх гэж битүүхэндээ өрсөлддөг байлаа шүү дээ. Тэр чинээгээрээ ч эрт босдог, ажлаа ч амжуулдаг байлаа.
- Цайг заавал нүдэж яадаг юм. **Холтлоод** л хийчихвэл...
- Яалаа гэж! Нүдсэн цай **ааг сайтай**. Тэгээд ч арвин байдаг юм.
- ...Бид ч бас уур нүдүүрээ **орхих нь дээ**. Ай хөөрхий нүдүүрийн дуу гэж...

Б.Галаарид

- 3 Зохиолыг сайн ойлгохын тулд тэмдэглэсэн үгийнхээ утгыг тайлбарлая.
  - 1) Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай уншъя.
  - 2) Үгийн утгыг өөрийнхөө ойлгосноор бичээд үзье.
  - 3) Энэ үгийнхээ утгыг толь бичгээс олж үзээд өөрийнхөө бичсэнтэй харьцуулъя.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
төсөөрөх	.....	.....
уур нүдүүр	.....	.....

- 4) Утгыг мэдсэн бол үгээ оролцуулаад өгүүлбэр зохиогоод үзье.
- 4 Зохиолын утга санааг сайн мэдэхийн тулд баатруудын үйл хөдлөлийг бичээд ярилцъя.
- 5 Учир шалтгааныг олъё.
  - 1) “За даа, бид мэтийн **хөгшчүүлд** л байхаас залуу айлд бол ч ховор доо.” гэж ээж нь хэлсний учир юу вэ?
  - 2) Яагаад “Дуу ямар хамаатай байна аа?” гэж хэлэв?
  - 3) Зохиогч яагаад “Ай хөөрхий нүдүүрийн дуу гэж...” гэж төгсгөсөн бэ?



## БИ ЮУ ЧАДДАГ БОЛОВ?

- 1 Доорх эхийг анхааралтай уншиж ойлгоорой.
- 2 Гарчгийн хариултыг эхээс олж бичээрэй.


### Яагаад ихэнх хүмүүс баруун гараа ашигладаг вэ?


Хүний их тархи бол мэдрэлийн тогтолцооны хамгийн дээд зэрэглэлийн эрхтэн бөгөөд баруун, зүүн хоёр хэсэгт хуваагддаг ба хэмжээ нь адилхан. Гэвч баруун зүүн хоёр тархины үүрэг, чадвар нь хоорондоо адилгүй. Хүний зүүн тархи биеийн баруун хэсгийн үйл ажиллагааг, баруун тархи биеийн зүүн хэсгийн үйл ажиллагааг захирдаг.

Их тархины хоёр талын ажиллах чадвар нь тэнцвэргүй байдаг. Хүн баруун тархиа хангалттай ажиллуулдаггүй, харин зүүн тархиа илүү их ашигладаг ажээ. Тиймээс ихэнх хүмүүс баруун гараа ашиглан зурж, бичдэг төдийгүй аливаа үйлдлийг ихэвчлэн баруун гараараа гүйцэтгэдэг байна.

Цаг үе, нийгэм хэрхэн өөрчлөгдсөн ч ялгаагүй хүний тархины ийм ген удамшсан хэвээр зүүн тархи илүү их ажилласан хэвээр, ихэнх хүмүүс баруун гараа ашигладаг хэвээр байгаа. Мэдээж зарим тохиолдолд баруун тархи нь илүү хөгжсөн хүний зүүн гар илүү чадвартай болж бидний ярьдаг “солгой гартан” болдог.

- 3 Ихэнх хүн солгой биш байдгийн шалтгааныг олж бичээрэй.
- 4 Чухал санагдсан өгүүлбэрүүдээ бичнэ үү.
- 5 Зураг сайн зурдаг хүний аль тархи сайн ажилладаг вэ? Шалтгааныг доорх зургаас олж бич.





Ямар үйл явдал болов?  
Цааш юу болох бол?

**ЗУРАГ ЮУНЫ ТҮХАЙ БОЛОХЫГ, БАС ЗОХИОЛ ЯАЖ ҮРГЭЛЖЛЭХИЙГ ТААМАГЛАЖ БОЛОХ ҮҮ?**

Зохиолын үйл явдлыг ойлгох  
Үйл явдал яаж өрнөхийг таамаглах





## ҮЙЛ ЯВДЛЫГ ОЙЛГОЖ, ЮУ БОЛОХЫГ ТААМАГЛАЯ

### 1 Зургийг ажиглаад, юуны тухай өгүүлж байгаа болохыг ярилцъя.

- 1) Ямар, ямар үйл явдал болж байгааг ажиглая.
- 2) Зургийг зөв дараалалд оруулан тэмдэглэе.
- 3) Юуны тухай өгүүлж болохыг ярилцъя.



- 4) Зураг бүр хоорондоо яаж холбогдохыг тайлбарлая.



- 2 “Эрт урьд цагт ах дүү хоёр холын уулнаас мод түүж ирэхээр явах болжээ.” энэ үйл явдал цааш юу болохыг таамаглаж хэлье.
- 3 Зохиолыг уншиж ойлгоё. Утгыг нь сайн мэдэхгүй үгээ бичиж авъя.

### Алт Мөнгө хоёр

#### (1)

Эрт урьд цагт ах дүү хоёр холын уулнаас мод түүхээр явах болжээ. Явахад нь ээж нь хоёр хүүхдэдээ замдаа идэж яв гэж нэг, нэг боодолтой ааруул эззгий өгөөд “Хоорондоо эвтэй, ах нь дүүгээ асарч яв” гэж захижээ. Ингээд хоёр хүү алсын аянд гарчээ. Энэ хоёр хүүгийн ахыг нь Алт, дүүг нь Мөнгө гэдэг. Алт, Мөнгө хоёр замдаа их хүйтэн шуургатай шөнө хээр унтах болжээ. Мөнгө нь хэлж гэнэ:

- Ах аа! Энэ хүйтэн шуургатай шөнө их даарна шүү. Хоёулаа хадны агуй олж унтахыг бодъё гэж хэлэв. Алт нь миний дүүгийн үг зөв. Хоёулаа хоёр тийшээ явж агуй эрье. Чи энэ уулын өвөр рүү яв. Би уул өөд явъя, хэн эхэлж агуй олсон нь бие биеэ дуудъя гэв. Дүү нь за тэгье гэж зөвшөөрч, хоёр тийш салаад, хоргодож унтах хадны агуй эрэхээр явцгаажээ.

**Зохиол цааш яаж үргэлжлэхийг таамаглан бодож ярилцъя.**

- 1) Ах дүү хоёрт хүйтэн цасан шуургатай шөнийг өнгөрөөх агуй олдвол зохиол яаж үргэлжлэх бол? Чи юу гэж бодож байна.
- 2) Хэрвээ энэ шөнийг өнгөрөөх агуй олдохгүй бол яах вэ? Зохиол цааш яаж үргэлжлэх бол?

**4 Зохиолыг сайн сонсоорой. Чиний таамаглан бодсонтой адил байна уу, өөр байна уу, харьцуулъя.**

<p>Агуулгыг ойлгохын тулд асуултаар ярилцъя.</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Мөнгө хүү ахыгаа яагаад дуудсаар байсан бэ?</li> <li>2) Харин Алт яагаад дүүгээ дуудсангүй вэ?</li> </ol>	<p>Мөнгө хүүд юу тохиолдох бол эргэцүүлэн бодоод, төсөөлөн ярилцъя.</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Мөнгө хүү цасан шуургатай хүйтэн шөнийг яаж өнгөрөөх бол?</li> <li>2) Харанхуй шөнө айж, даарсан Мөнгө хүү ямархуу байдалтай байсан бол? Төсөөлөн бодож ярья.</li> </ol>
--	--

- 1) Сонссон зохиолтой таамаглан бодсоноо харьцуулан бичье.

Асуулт	Миний бодсон	Зохиолд өгүүлсэн
1) Ах дүү хоёрт агуй олдвол зохиол яаж үргэлжлэх бол?	..... .....	..... .....

**5 Зохиол цааш яаж үргэлжлэхийг уншиж мэдье.**

- 1) *Цэгийн оронд ямар үг байж болохыг төсөөлөн бодъё.*
- 2) *Төсөөлөн бодсон үгээ хэлж уншъя.*

**(2)**

Өвлийн хүйтэн шуурган дунд нимгэн хөдсөн дээлтэй Мөнгө тачигнатал чичирч, айх даарахын эрхэнд ахыгаа олон удаа дуудсан боловч огт чимээ гарсангүй.

Мөнгө хүүгийн гар хуруу чимчигнэн хөлдөж үхэх шахаад байтал, адуу эрж явсан өвгөн дайралдаж арваад настай бяцхан Мөнгө хүүг дулаан дээлэндээ ....., ..... үхэх аюулаас аварчээ. Тэр ууланд чоно элбэгтэй юм байжээ. Хоёр чоно үдэш агуйгаас .... шөнө айлуудын хот руу ан хийж ..... юу ч олсонгүй өлссөндөө гутсаар үүрлэдэг агуйдаа ..... агуйд унтаж байгаа бяцхан хүүг ..... тоймгүй их баярлаж, хэл амаа долоож ..... завдаж, хэн нь эхэлж барих вэ? гэж ярилцаж байлаа.

Мөнгө хүү өвгөн адуучны хүчээр дааралгүй хоносон боловч ахыгаа харанхуйд төөрөөд, хөлдөж үхсэн болов уу гэж бодсоор байгаад, үүрийн цагаан гэгээгээр босжээ.

- 3) *Цэгийн оронд хэлж үзсэн үгээ бичье.*
- 4) *Ойлгохын тулд асуулт зохиож бичээд, найзуудаасаа асууя.*

**6 Эхийг сайн ойлгохын тулд мэдэхгүй үгийнхээ утгыг тайлбарлая.**

- 1) *Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай уншъя.*

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
үүрийн цагаан гэгээ	.....	.....

**7 Зохиол яаж төгсөхийг асуултын дагуу таамаглан ярилцъя.**

- 1) Өлсгөлөн хоёр чоно Алтыг яах бол?
- 2) Хэн нэгэн Алтад туслах болов уу?
- 3) Ах дүү хоёр уулзах болов уу?
- 4) Миний бодсоноос ялгаатай байна уу, адил байна уу? Үргэлжлүүлэн уншиж мэдье.

(3)

... Мөнгө хүү ахыгаа эрэн хадны агуйн дэргэд иртэл, агуй руу мөлхөж яваа хоёр чоныг хараад чанга дуугаар хашхирсанд, цогтой хүүгийн цовоо дуунаар чоно зугтаад явчав. Алт арай гэж сэрээд, чонын барааг харж айсандаа уушги зүрх нь дэлбэрэх шахжээ. Ингэж ах дүү Алт, Мөнгө хоёр үүрээр уулзжээ... П.Хорлоо

- 5) Уншсан, таамаглан бодсоноо харьцуулан бичье.

асуулт	миний бодсон	зохиолд өгүүлсэн
Өлсгөлөн хоёр чоно Алтыг яах бол?	.....	.....
Хэн нэгэн хүн Алтад туслах болов уу?	.....	.....
Ах дүү хоёр уулзах болов уу?	.....	.....

**8 Зохиолын төгсгөлд зохиолчийн тавьсан асуултад хариулж ярилцъя.**



Хэрэв Мөнгө нь эрж олоогүй бол Алтыг чоно яах байсан бэ? Та нар сайн бод.



Энэ юунаас болов?


Мөнгө хүү яах байсан бол?		
Таамаглал 1	Таамаглал 2	Таамаглал 3
.....	Мөнгө хүү хүйтэнд хөлдөж магадгүй байх	.....
.....		.....
.....		.....

Таамаглан бодохдоо

1. Мэдсэн зүйлээ бодно.
2. Таамаглал дэвшүүлнэ.
3. Таамаглалаа зохиолтой харьцуулж бодно.


**9 Үйл явдлыг таамаглан бичье.**

- 1) Хэрэв адуучин өвгөн ирээгүй бол дүү Мөнгө нь яах байсан бол?
- 2) Зохиолын баатрууд ийм холбоотой бол чоно ямар холбоотой бол?



# 1 Зургийг ойлгож ярилцъя.

- 1) 3 минутын турш зургийг сайн ажиглая.
- 2) Асуултын дагуу ярилцъя.



# 2 Өвөө, хүү хоёрт юу тохиолдсоныг бодоод уншъя. Уншихдаа утгыг сайн мэдэхгүй үгийг тэмдэглэж уншъя. (✓, —, |)

## Өвөө хүү хоёр

1 Өвөө жаал хүү хоёр илжигтэйгээ аян замд гарчээ. Хотод ойртох үедээ илжгээ хөтөлж гэнэ. Гэтэл хэсэг хүүхэд хажуугаар нь өнгөрөхдөө:

-Энэ тэнэгүүдийг хараач. Эрүүл чийрэг илжигтэй мөртлөө явган **сажилж** байна. **Ядахнаа** өвөө нь илжгээ унамаар юм даа гэж шоолцгоов.

Ямар, ямар үйл явдал болов?

- Хүүхдүүд шоолцгооход өвөө, хүү хоёрт юу бодогдсон бол?
- Өвөө, хүү хоёр цааш яасныг таамаглан хэлье. Үргэлжлүүлэн уншъя.

2 Ингэхэд өвөө, хүү хоёр:

- Хүмүүс бид хоёрыг шоолж байна. Тэдний хэлсний дагуу хийхгүй бол **горьгүй нь**, гээд өвөө илжгээ унан, хүү дагаж алхлаа. Удалгүй хэсэг хүн зөрөх зуур:

-Үгүй ер, өөрөө илжгээ уначхаад **хээвнэг** явах шив. Жаахан хүүхэд ядарч байгаа гэж боддоггүй л юм байх даа гэгцгээв. Тэгэхээр нь **мань хоёр** байраа сольж, хүү илжгээ унаж өвөө алхав.

Ямар, ямар үйл явдал болов?

- Дахиад хэсэг хүмүүс энэ хоёртой тааралджээ.
- Тэд яасан бол? Үйл явдлыг таамаглан хэлье.

3 Зам зуур ахиад л хэсэг хүн таарав.  
 - Тэрийг хар даа. Яасан ичдэггүй жаал вэ? Дэргэд нь настай хүн алхаж байх юм. **Ах захаа хүндлэх ёс** алга болжээ гэж шүүмжилцгээв. Одоо яах вэ? **Гайхширч эргэлзсэн** хоёрт ганц л **зам үлдлээ**. Хоёул илжгэндээ сундлав.

Ямар, ямар үйл явдал болов?

- Ингээд цааш явтал хэдэн хүн зөрөв. Тэд юу гэж хэлсэн бол?
- Өвөө, хүү хоёр цааш яасан бол? Таамаглан хэлье.
- Үргэлжлүүлэн уншъя.

4 Гэтэл бас нэг хэдэн хүн **зөрөхдөө**:  
 - Арай ч дээ хоёрын хоёр хүн нэг илжиг дээр мордчихжээ. Хөөрхий илжиг ядарч үхлээ. Өөрсдөө илжгээ үүрээд явбал таарна гэж муулцгаав. Өвөө, хүү хоёр **дөрөө мулталж** хэлэлцлээ. Энэ янзаар бол хэн хүний **хэл амны бай** болох нь. Ингээд эцсийн **аргаа сийлж**, илжгээ үүрч явахаар шийдэв.

Ямар, ямар үйл явдал болов?

- Аргаа барсан өвөө, хүү хоёр илжгээ үүрээд яасан бол? Таамаглан хэлье.
- Үргэлжлүүлэн уншъя.

5 Тэр хоёр, илжгээ дамнуурганд хүлж **дамнуургаа мөрлөн** гүүрээр гартал бөөн хүн таарч:  
 - Хүн илжгийг унадаг байтал илжиг хүнийг унаж явна. Ямар гээчийн алиа **солио явдал** вэ? гэж **ам булаалдан** шагшрав. Олон хүний шуугианаас цочсон илжиг **олсоо тийрэн огло** харайгаад гүүрнээс уналаа. Өвөө хүү хоёр илжгээ авах гэж гүүрнээс буутал аль хэдийн өнгөрсөн байлаа.  
*“Чанадын чанадад” номоос*


Ямар, ямар үйл явдал болов?

3 Эхийг сайн ойлгохын тулд тэмдэглэсэн үгийнхээ утгыг тайлбарлая.

- 1) Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай уншъя.
- 2) Үгийн утгыг өөрийнхөө ойлгосноор бичээд үзье.
- 3) Энэ үгийнхээ утгыг толь бичгээс олж үзээд, өөрийнхөө бичсэнтэй харьцуулъя.

Бичсэн үг	Миний ойлгосон утга	Толь бичигт байгаа утга
илжиг	.....	.....
сажлах	.....	.....
хээвнэг	.....	.....

4 Уншсанаа сайн бодъё. Хүмүүс юу, юу гэж хэлснийг жагсаан бичье.

хэлсэн үг нь:					
	хэсэг хүүхэд	зөрсөн хүмүүс	хэсэг хүн	хэдэн хүн	бөөн хүн
	.....	.....	.....	.....	.....

5 Жагсаан бичсэнээс баатруудын зан чанарыг ярилцъя.

- 1) Эдгээр баатруудын хэлснийг бодоод, таалагдаж байгаа бас таалагдахгүй байгаа нэг, нэг жишээг сонгоё.
- 2) Таалагдаж байгаа учрыг тайлбарлаж хэлье.
- 3) Таалагдахгүй байгаа учрыг ч бас тайлбарлаж хэлье.

6 Хэрэв чи баатруудын оронд байсан бол яах байсан бол? Таамаглаарай.

Өвөө, хүү хоёр илжгээ хөтлөөд, явж байхад нь таарвал: .....

Өвөө илжгээ унаж, хүү даган алхаж байхад нь таарвал: .....



Хүү унаж, өвөө алхаж байхад таарвал: .....

Хоёул сундлаад явж байхад таарвал: .....

7 Дараах асуултад хариулж бичээрэй.

- ✍ Юунаас болж өвөө нь илжгээ унасан бэ?
- ✍ Жаахан хүүхэд ядарч байгаа гэж боддоггүй юм байх даа гэж хэсэг хүн хэлснээс болж өвөө, хүү хоёр яасан бэ?

8 Өвөө, хүү хоёр дараах үйл явдлыг хийх болсон шалтгааныг олж бичье.

Шалтгаан нь:	Үйл явдал нь:
.....	Өвөө илжгээ унан, хүү дагаж алхлаа.
.....	Хүү илжгээ унаж, өвөө алхав.
.....	Хоёул илжгэндээ сундлав.
.....	Тэр хоёр, илжгээ дамнуурганд хүлж, дамнуургаа мөрлөн гүүрээр гарав.
.....	Илжиг олсоо тийрэн огло харайгаад, гүүрнээс уналаа.

1) Өвөө, хүү хоёр илжээ авах гэж гүүрнээс буутал илжиг нь аль хэдийн өнгөрсөн байлаа.



Илжиг яагаад үхэв?  
Юунаас болж илжиг үхэв?  
Илжиг үхсэн шалтгаан юу вэ?

Эдгээр асуултад ямар хариулт өгч болох вэ?

9 Өвөө, хүү хоёрын зан чанарыг тодорхойлоорой.



Бат-Эрдэнэ ингэж бичжээ.

.....  
.....

Өвөө, хүү хоёр өөрсдөө шийдвэр гаргаж чадаагүй.  
Бусдын хэлсэн үгээр л байсан.

Бодох зүйл

Хүн бүр өөр өөрийн бодлоо тулгаж хэлбэл юу болохыг бодоорой. Тэр бүхнийг дагаад байвал юу болох бол?

10 Тэр хоёрт үг хэлсэн хүмүүсийн зан чанарыг тодорхойлоорой.

Зөв байж болох үг нь:					
	хэсэг хүүхэд	зөрсөн хүмүүс	хэсэг хүн	хэдэн хүн	бөөн хүн
	.....	.....	.....	.....	.....

11 Хүмүүс, өвөө хүү хоёрыг хараад, юу гэж хэлбэл зөв байж болохыг хэлэлцээрэй.

Зөв байж болох үг нь:					
	хэсэг хүүхэд	зөрсөн хүмүүс	хэсэг хүн	хэдэн хүн	бөөн хүн
	.....	.....	.....	.....	.....

12 “Өвөө хүү хоёр” зохиолын сургамжтай зүйл нь юу байгааг ярилцаарай.

## БААТРУУДЫН ЗАН ЧАНАРЫГ ЖИШЭЭГЭЭР ТАЙЛБАРЛАА



Баатруудын хэлсэн үг, хийсэн үйлдлийг ялгаж ойлгох  
Баатруудын зан чанарыг зохиолын жишээгээр тайлбарлах  
Оноосон нэрийг зөв бичих





## ЗӨВ ДАРААЛЛЫГ ОЛЖ УНШИЦГААЯ

### 1 Дараах зургийг сайн ажиглаад, дарааллыг олж ярилцъя.

1. Зураг бүрийг сайтар ажиглая.
2. Яаж дараалуулах учир шалтгааныг сайн бодъё.
3. Эхлээд, дараа нь, эцэст нь юу болохыг төсөөлөн бодъё.

**Жамуха, Тэмүжин хоёр анд нөхөр бололцсон нь**



### 2 Зургийн дарааллыг бодоод, зохиолыг уншъя.

Жамуха Ван хааны хуурай хүү. Сүрхий сэргэлэн, овсгоотой, их зоригтой, залирхаг гялтганасан хар нүдтэй, монтгор хамартай, өргөн магнайтай, хөрслөг бор хүү байжээ. Нэг өдөр Жамуха, Есүхэйн хүү Тэмүжинтэй жирх агнахаар хөөцөлдөж яваад тааралдав.

Ингээд тэр хоёр Онон мөрний мөсөн дээр гулгаж тоглохоор тохиролцжээ. Маргааш өглөө нь хоёул эртлэн ирж, ширэн гутлынхаа улыг мөлийтөл гулгав. Энэ тоглоом их сонирхолтой байлаа.

- “Маргааш яаж тоглох вэ? Мөн л гулгах хэрэг үү?” хэмээн Жамухыг асуухад, Тэмүжин “Үгүй шагалцъя!” гэв.

Маргааш нь тэр ёсоор нэхий дээлийнхээ хормойг тунтран сууж, мөсөн дээр шагалцав. Орой нар жаргахын хэрд сайн найзууд болсноо батлан суран бүсээ сольж бүсэлцгээв. Энэ үеэс хойш Жамуха Тэмүжинд тусалж, заримдаа алдаа дутагдлыг нь ч хэлж зөвлөж, шоглож шоолон засдаг байлаа.

*Т.Мандир*

### 3 Уншсан хэсгийнхээ гол үйл явдлыг нэг өгүүлбэрт багтаан бичье.

Жамуха, Тэмүжин хоёр ан хийж яваад уулзав.

Маргааш нь мөсөн дээр гулгаж тоглов.

Бүсээ солилцож, анд бололцов.

- 1) Гол үйл явдлыг нэг өгүүлбэрт багтаан бичсэнийг зөвшөөрч байвал, яагаад зөвшөөрч байгаагаа тайлбарлаарай.

2) Үгүйсгэж байгаа бол, яагаад гэдгээ жишээгээр батлаарай.

4) Дараах загварыг гүйцээж бичээрэй.

<div style="border: 1px solid black; border-radius: 15px; padding: 5px; width: fit-content; margin: 0 auto;">Жамуха ямар хүн бэ?</div>	-->	<div style="border: 1px solid black; border-radius: 15px; padding: 5px; width: fit-content; margin: 0 auto;">Жамухыг яагаад ингэж тодорхойлсон бол?</div>	-->	<div style="border: 1px solid black; border-radius: 15px; padding: 5px; width: fit-content; margin: 0 auto;">Юу хийж байхдаа Тэмүүжинтэй тааралдсан бэ?</div>
<div style="border: 1px solid black; border-radius: 50%; padding: 10px; width: fit-content; margin: 0 auto;">залирхаг, ....., ....., ....., ....., .....</div>		<div style="border: 1px solid black; border-radius: 50%; padding: 10px; width: fit-content; margin: 0 auto;">..... .....</div>		<div style="border: 1px solid black; border-radius: 50%; padding: 10px; width: fit-content; margin: 0 auto;">..... .....</div>

5) Жамуха, Тэмүүжин нар юу, юу хийсэн бэ?




---

---

---

---

---

---

---




---

---

---

---


---

---

---

**“Үнсгэлжин” зохиолтой танилцъя**

1) Зургийг ажиглая. Юу болж байгааг таамаглаж ярилцъя.



**2 Асуултын дагуу ярилцъя. Зургийг зөв дарааллаар дугаарлая.**

1. Үлгэрийн гол баатар хэн бэ?
2. Үнсгэлжинг хааны ордонд ороход нь хэн тусалсан бэ?
3. Шидэт дохиурт эмгэн юу хийв? Тэр Үнсгэлжинд юуг анхааруулсан бэ?
4. Үнсгэлжин хааны ордонд очоод юу хийв?
5. Яагаад яаран гарч гүйсэн бэ?
6. Гүйхдээ юугаа гээсэн бэ?
7. Хан хүү түүнийг хэрхэн хайсан бэ?
8. Хааны элч яаж Үнсгэлжинг таньсан бэ?
9. Үлгэр хэрхэн төгсдөг вэ? Энэ үлгэрээс ямар сайн, муу зүйлийг мэдэж авсан бэ?

**3 Үнсгэлжин зохиолыг уншиж ойлгоё.**

**Үнсгэлжин**

(Үлгэр)

Эрт цагт үзэсгэлэнт хөөрхөн Үнсгэлжин охин, аавтайгаа хамт амьдран суудаг байжээ. Удалгүй охин хойд ээжтэй болж, хамт амьдардаг болов. Хойд ээж нь хоёр охинтой бөгөөд тэд түүний эгч болжээ. Ээж нь өөрийн охиддоо тун ч хайртай бөгөөд тэднийг эрхлүүлж, харин хөөрхий Үнсгэлжинд хатуу ширүүн хандан, гэрийн хамаг ажлыг хийлгэдэг боллоо.

Нэгэн өдөр охин гэрийн ажлаа хийж байгаад, хавханд орсон хулганыг суллаад хооллож явуулав. Тэр цагаас хойш хулганууд түүний найз болжээ. Түүний зэрэгцээ Үнсгэлжин их ажлынхаа хажуугаар шувуудыг хооллож, өөрийн найз хулгана, шувуу зэрэг амьтадтай тоглодог байв. Сайхан сэтгэлт охин ойн амьтдыг хайрлан хамгаалж, тоглосоор сайн найзууд болжээ. Найзууд нь болон Үнсгэлжин ч гэсэн бие биедээ дандаа тусалдаг байв.

Гэтэл тэр улсын Хаан өөрийн хүүдээ гэргий болгон авч өгөх охин олохоор шийдэж гэнэ. Тэгээд гэргий болох насны бүх охидыг урьж, маш том үдэшлэг зохиохоор шийджээ. Ингээд, охидтой бүх гэр бүлд урилга явуулж гэнэ. Үнсгэлжин охиныд ч бас урилга иржээ. Үдэшлэгийн урилга авсан эгч нар нь ихэд баярлаж, шууд л үдэшлэгт бэлтгэж эхэлжээ. Харин тэд, ээжтэйгээ нийлж Үнсгэлжинг загнан, “Чи яаж Хааны ордонд очих билээ. Ийм муухай байж.” хэмээн хашхирахад, хойд эх нь “Чи бүх ажлыг хийж дуусгавал л явна шүү.” гэж загнажээ.

Удалгүй үдэшлэгт очих өдөр боллоо. Хоёр эгч нь өглөөнөөс хойш бэлтгэн, даашинзаа гоёж их л завгүй байв. Харин тэд Үнсгэлжинд өглөөнөөс үдэш болтол завсар зайгүй их ажлыг ар араас нь даалгаж, охин борви бохисхийлгүй ажилласаар, даашинзаа гоёж, үдэшлэгт бэлтгэх ч зав гарсангүй. Үнсгэлжингийн найз болох ойн амьтад, хулгана, шувууд “Хөөрхий манай Үнсгэлжинд үдэшлэгт бэлтгэх зав гарахгүй нь ээ. Бүгдээрээ Үнсгэлжинд гэнэтийн бэлэг барья. Даашинзыг нь гоёж өгье.” хэмээн ярилцаж, үдэшлэгт өмсөх даашинзыг нь гялалзсан сайхан сувд, өнгө өнгийн гоёмсог туузаар чимэглэн, бэлтгэж өгчээ.

**4 Үнсгэлжингийн хийсэн үйлүүдийг ялгаж бичээрэй. Хойд эхийн хэлсэн үгийг бас бичээрэй.**

Орой болж, охид Хааны ордон руу явахаар хувцсаа өмсөв. Үнсгэлжин ч бас найз нарынхаа бэлтгэж өгсөн гоёмсог даашинзыг өмсөн, явахаар гарч ирэв. Гэтэл түүнийг харсан эгч нарын нэг нь “Хүүе! Энэ надад л баймаар сувд байна. Би авлаа.” хэмээн хашхирч, сувдыг нь булаан авлаа. Харин нөгөө эгч нь “Энэ туузаа надад өг!” хэмээн

хашхирч, даашинзыг чимэглэсэн гоёмсог туузыг нь татаж, хөврүүлээд хаячхав. Ингээд Үнсгэлжинд дахин ажил өгч, “Үүнийг хийж дууссаны дараа л Хааны ордон руу яваарай!” гээд, өөрсдөө үдэшлэгт явжээ.

### **5 Шидэт эмгэний хийсэн үйлийг ялгаж бичээрэй.**

Охин тэдэнд гомдон уйлж суутал, гэнэт түүний өмнө нэгэн жижигхэн дохиур барьсан эмгэн хүрч ирээд: “Охин минь! Чи яагаад уйлав?” гэж асуухад, охин бүгдийг ярьж өгчээ. Харин эмгэн: “Намайг Шидэт эмгэн гэдэг. Би чамайг сайхан сэтгэлтэй, ажилсаг болохыг мэднэ. Тэгэхээр чамд туслахыг хичээе. Чи надад нэг хулуу олоод ирээч.” гэжээ.

Үнсгэлжин охин нэгэн хулуу авчирч өгтөл, эмгэн шидэт дохиураараа дохиж, маш гоё сүйх тэрэг болгочихлоо. Дараа нь Үнсгэлжингийн найз хулгануудыг дохиураараа сайхан цагаан морьд болгон хувиргав. Харин охиныг маш гоёмсог даашинзтай, хөөрхөн болор шаахай өмссөн үзэсгэлэнт бүсгүй болгон хувиргажээ. Тэгээд охинд хэлжээ. “За охин минь! Хүссэн үдэшлэгтээ очиж, бүжиглэ дээ. Тэгэхдээ шөнө дунд болсныг зарласан цагийн хонх “Дүн дан” дуугармагц чиний энэ ид шид байхгүй болж, чи хуучин хэвэндээ буцаж орно гэдгийг мартуузай.” гэж захижээ.

Охин гоёмсог сүйх тэргээрээ яаран давхиж, Хааны ордонд ирэв. Үдэшлэгт орж ирэхэд, хүн бүхэн үзэсгэлэнт охиныг бахдан харж, охид атаархан ширтэж байлаа. Хан хүү түүнийг хараад, бүжгэнд урьж, тэд бүх л оройжин бүжиглэжээ. Бүжиглэж байсан охин, гэнэт шөнө дунд болж байгааг зарласан цагийн хонх “Дүн дан, дүн дан” гэж дуугарахыг сонслоо. Тэгээд, ордноос хар хурдаараа гарч гүйхдээ өрөөсөн болор шаахайгаа ордны шатан дээр унагачихжээ. Араас нь яаран гарч ирсэн Хан хүү охиныг хайсан боловч байсангүй. Харин гоёмсог болор шаахайны өрөөснийг л олжээ. Тэрээр охины шаахай болохыг танив. Үнсгэлжин гэртээ яаран ирэхэд, бүх ид шид үгүй болж, хуучин хэвэндээ орсон байлаа. Түүний араас хойд эх, хоёр эгч нь орж ирээд, үдэшлэгт ирж, Хан хүүгийн сэтгэлийг булаасан үзэсгэлэнт охин хаанаас ирсэн хэн болохыг гайхан ярилцсаар унтжээ.

Удалгүй Хааны элч нар, орон даяар Үнсгэлжингийн үеийн охинтой бүхий л айлуудаар явж, Хан хүүтэй гэрлэх охиныг хайхдаа нэгэн өрөөсөн болор шаахайг авч явжээ. Тэд айл бүрд орж, болор шаахайг охидод нь өмсүүлэн үзэж байв. Гэвч хэнд ч таарахгүй байлаа.

### **6 Хойд эх, хоёр эгчийн хэлсэн үг, хийсэн үйлийг бичээрэй.**

Тэгж явсаар, элч нар Үнсгэлжин охиныд ирэв. Хоёр эгч нь яаран, болор шаахайг булаалдан өмсөж үзсэн боловч хөлд нь багтсангүй. Энэ үед Үнсгэлжин хойд эхийн даалгасан ажлыг хийгээд завгүй байлаа. Ээж нь зориуд түүнд ажил өгч, ихэд уурлан, болор шаахайг өмсөж үзэхийг ч зөвшөөрсөнгүй. Ингээд элч нар гэрээс гарахаар үүд рүү явах замд Үнсгэлжингийн найз шувуухай түүнийг Үнсгэлжин рүү очуулахаар, урдуур нь нисчээ. Түр зогсож, гайхсан элч гэнэт Үнсгэлжин охиныг харж: “Охинд шаахайг өмсүүлж үзүүлье.” гэхэд, хойд эх яаран: “Үгүй, үгүй. Тэр манай зарц байгаа юм.” гэв. Харин сайхан сэтгэлт элч: “За яахав, өмсүүлээд үзье дээ.” гээд, өрөөсөн шаахайг охинд өгчээ. Үнсгэлжин охин шаахайг өмсөж үзэхэд, хөөрхөн хөлд нь яг таарчээ. Хааны элч баярлан хашхирч, харин хойд эх болон хоёр эгч нь атаархсандаа чанга хашхирав.

Харин охин хувцасны шүүгээн дотроосоо болор шаахайны өрөөснийг нь авч, нөгөө хөлдөө өмсөж гэнэ. Ингэж хойд эх үдэшлэг дээр Хан хүүгийн сэтгэлийг татсан үзэсгэлэнт охин бол Үнсгэлжин байсныг мэдэж, ихэд уурсаж, харин хоёр эгч нь атаархсандаа хашхиран уйлж гэнэ.

Хааны элч түүнийг ордонд аваачхад, Хан хүү охиныг хараад шууд л танив. Ингээд сайхан сэтгэлтэй, ажилсаг Үнсгэлжин охин Хан хүүтэй гэрлэж, Хааны ордонд очин, аз жаргалтай сайхан амьдрах болжээ. Түүний үнэнч найзууд ч бас охинтой хамт амар сайхандаа жаргажээ.

7 Баатруудын хэлсэн үг, хийсэн үйлдлийг зөв холбож бичье.

Үнсгэлжин	ажил	тоглодог.
Эгч нар	Үнсгэлжинд	загнасан.
Найз нар	амьтадтай	бэлтгэсэн.
Хойд ээж	Үнсгэлжинг	өгсөн.
Шидэт эмгэн	даашинз	тусалсан.

Үнсгэлжин	хонх	ирсэн.
Охин	хуучин хэвэндээ	сонссон.
Үнсгэлжин	үдэшлэгт	орсон.

Элч нар	хэний ч хөлд	хайсан.
Болор шаахай	таарсан охин Ханхүүтэй	таараагүй.
Болор шаахай	гэрлэх охиныг	гэрлэнэ.

8 Та нарт үлгэрийн ямар баатар таалагдав. Бас ямар баатар таалагдсангүй вэ? Яагаад гэдгийг хэлээрэй.

- 1) Хүүхэд бүр хариултаа бичиж бэлдээд самбарт наагаарай.
- 2) Тэдгээр хариултыг “Тойрон аялал”-аар явж уншаарай.

Баатрууд чамд таалагдах эсэх нь тэдний хийсэн үйл, хэлсэн үг, зан чанараас шалтгаална. Иймд түүнийг илүү сайн судалъя.

9 Асуултад бүтээлчээр хариулт хайя. Хариултаа дараах загварт оруулж бичье.

Асуулт	Хариулт	Түүний зан чанар	Бодох зүйл
Хэрвээ шөнө дундын 12 цагаас хойш Синдрелла тэргэндээ үсрэн сууж амжаагүй байсан бол юу болох байсан бэ?	Ноорхой хэвээр байх байсан.	Цаг барьдаг.	Зарим үед бусдын өмнө нооройчихсон зогсож байвал юу болох билээ!
Асуулт	Хариулт	Түүний зан чанар	Бодох зүйл
Гэтэл Синдрелла үдэшлэгт яаж явж чадав аа?	..... .....	..... .....	..... .....


Асуулт	Хариулт	Түүний зан чанар	Бодох зүйл
Түүнийг үдэшлэгт явахыг хориглоход нь яваагүй бол юу болох байсан бэ? Гэтэл тэр явсан. Явахыг хэн шийдсэн бэ?	..... .....	Өөрийгөө хайрладаг, шийдвэр гаргадаг..	..... .....

Асуулт	Хариулт	Түүний зан чанар	Бодох зүйл
Хэрэв чи Синдреллагийн хойд ээж байсан бол түүнийг Хан хүүгийн үдэшлэгт явуулах байсан уу? Үгүй юу? Яагаад?	Тийм? Үгүй?	..... .....	Өөрийнхөө хүүхдийг хайрладаг шигээ бусдын хүүхдэд хайртай байж чаддаггүй юм байна. Үүнийг бодъё

10 Үнсгэлжин ямар зан чанартай вэ? Зохиолоос жишээ олж хэлнэ үү.

11 Дараах жишээнээс хоёр эгчийн зан чанарыг тодорхойлж бичээрэй.

Чи яаж хааны ордонд очих билээ гэв.  
Тэд их ажлыг Үнсгэлжинд даалгав.  
Нэг нь сувдыг булааж, нөгөө нь туузыг татав.  
Тэд дахин ажил өгөв.




Зан чанар

.....

.....

.....

Хоёр эгч шаахайг булаалдан өмсөв.  
Хоёр эгч атаархсандаа чанга хашхирав.  
Хоёр эгч атаархсандаа уйлав.



Зан чанар


.....

.....

.....

1 “Дашинчилэнд суугаа Андерсенд” гэсэн зохиогчийн тэмдэглэлийг дахин уншъя. Тэнд өгүүлсэн “Нугасны муухай дэгдээхэй” зохиолыг уншиж найддаа ярьж өгье.

Хурдан унших харааны дасгал хийе.



## Нугасны муухай дэгдээхэй

(Үлгэр)

1.

Жаргалтай дэлгэр зун цаг аа гэж. Хуучин гацааны хашаанаас татаал ус хүртэл хүүхэд нуугдаж тогломоор далбагар том навчис дүүрэн бөгөөд тэнд нэгэн эх нугас өндгөө даран хэвтэх ажээ. Тэгж байтал дарсан өндөг нь дараалан пис пас хагарч, өрөвгөр өрөвгөр жаахан толгой шовс шовсхийн гарч ирэв. Тэгээд, нялх үрсээ бүртгэн тоолж байгаад “Ээ яадаг билээ, нэг өндөг үлдчихэж” гээд, даруй түүнийг дарж хэвтэв.

Тэгтэл нэг хөгшин нугас ирж өндгийг нь үзээд, “Наадах чинь яасан том юм бэ? Тахианых бололтой. Үүнийг дарахын оронд үр хүүхдээ усанд самруулж сургахыг бод” гэлээ. Эх нугас “За яахав нэгэнт дарсных, хэсэг хэвтээд үзье” гэв. Тэгж тэгж нөгөө том өндөг хагарч, дотроос нь бие маш том бөгөөд үзэшгүй муухай юм гарч ирэх нь тэр. Эх нь мэл гайхаж “Юу вэ, энэ чинь! Нугас юм уу, тахиа юм уу? Юутай ч нуурын ус ялгаад өгөх байлгүй. Усанд түлхэж байгаад оруулж үзье” гэв.



Хойд өдөр нь гэгээн дулаан өдөр болж, нар их л ээнэ. Нугас дэгдээхэйгээ дагуулж татаалын зүг очоод, усанд пал хийтэл харайж орон, “рапа рапа” гэж дуудав. Дэгдээхэйнүүд хойно хойноос цувалдан харайж, усанд шумбаад ил гарч ирмэгц хөл нь өөрөө хөдөлж, догь байдал гарган самрахад өнөөх муухай бор дэгдээхэй бас самралцана. Эх нугас түүнийг хараад “Энэ яав ч тахиа биш. Яахын аргагүй төрсөн үр минь. Харахгүй юу, тэр сэлж байгааг нь!” гээд хэдэн муу дэгдээхэйгээ дагуулан цааш одов.

Нугас бүхэн түүнийг ад шоо үзэн давшилсаар. Буруу нь гэвэл ердөө л нугас нугаснаас нуруу өндөр төрснийх! Сүүлдээ бүүр олны элэг доог болон гишгэх газар олдохоо болив. Бүгд л сүргээсээ хөөж тууна. Хамт төрсөн ах эгч нар нь хүртэл муухай аашлан, “Муурын идэш болвол таарах золиг!” гэнэ. Яваандаа эх нь ч хамгаалж чадахаа больжээ.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
татаал ус	.....	.....

### 2 Дараах хоёр үйл явдал холбоотой юу?

«Наадах чинь яасан том юм бэ? Тахианых бололтой. Үүнийг дарахын оронд үр хүүхдээ усанд самруулж сургахыг бод» гэлээ.

«Юу вэ, энэ чинь! Нугас юм уу, тахиа юм уу? Юутай ч нуурын ус ялгаад өгөх байлгүй. Усанд түлхэж байгаад оруулж үзье» гэв.

### 3 Холбоотой эсэхийг асуултаар мэдье.

- ✓ Нугасны дэгдээхэй усанд сайн сэлдэг үү?
- ✓ Усанд оруулбал тэр сэлж чадах болов уу?
- ✓ Хөгшин нугасны үг эх нугасанд юу бодогдуулав?

### 4 Яагаад “Нугасны муухай дэгдээхэй” гэж нэрлэснийг тайлбарлан бичээрэй.



2.

Хаврын сайхан цаг ирж, нарны илч халуун болсон цагт нугасны дэгдээхэй намаг дахь хулс зэгсний дунд хэвтэж байсан бөлгөө. Гэнэт түүний жигүүр дэлгэгдэн нээгдэж, урьдаас улам чадалтай шаламгайгаар хөдлөн нисэж нэг мэдэхэд нисэн буужээ.

Гурван сайхан цагаан хун шувуу шугуй дотроос самран гарч, дэгдээхэйн зүг маш үзэсгэлэнтэйгээр усан дээгүүр гулган самарч очив. Дэгдээхэйн сэтгэл сонин болоод: «Би энэ шувууны өмнөөс нисэн очъё. Намайг энэ муухай ойртон ирэв хэмээн тоншин цохиж хөнөөвөл хөнөөтүгэй. Нугасанд чимхэгдэж, тахианд чичигдэж, шивэгчинд өшиглүүлж, элдэв зовлон зүдгүүрийг үзэж явснаас эдэнд хөнөөгдвөл дээр буй за» хэмээн усан дээр нисэн бууж, тэр сайхан хун шувууны өмнө самран очив.

Гэтэл хун шувуу өдөө дэрвийлгэн сөхөж, угтан ирсэнд хөөрхий дэгдээхэй “Намайг хөнөөгтүн” хэмээн тэргүүнийг дарав. Гэвч тунгалаг усан дотор үзвэл, амьтан бүхнийг жигшүүлэх муухай дэгдээхэй биш, харин нэгэн сайхан хун байна.

- Нугасны муухай дэгдээхэйд бусад нь яаж ханддаг байсныг ярья.



3.

Дэгдээхэй өч төчнөөн зовлон зүдгүүрийг хүлцэн тэсвэрлэж өнгөрүүлсний эцэст ийм сайхан дүрийг олоод, сая түүний ид шидийг бүрнээ мэдэв. Том хун шувуу түүнийг тойрон ирж хошуугаар илэн эрхлүүллээ.

Гэнэт хэдэн бяцхан хүүхэд цэцэрлэгт орж ирээд, усанд талх тариа цацтал, хамгийн бага нь хашхиран өгүүлрүүн: «Тэр нэгэн шинэ хун байна.» гэсэнд бусад нь баярлан хашхирав.

- «Шинэ хун ирэв. Шинэ хун ирэв.» хэмээн алгаа дэлдэж, аав ээжээ дуудан ирүүлэв.

Тэгээд усанд талх боов хаяж, бүгдээр өгүүлрүүн: «Шинэ хун хамгийн сайхан, хамгийн залуу болой. Хуучин хун түүний өмнө толгойгоо бөхийжээ.» гэсэнд залуу хун шувуу ихэд ичингүйрэв.

Ихэрхэг, омгорхог болох ёсгүй тул хун шувуу тэсгэлгүй бахдан баярлавч өчүүхэн төдий ч омгорхог ихэрхэг болсонгүй. Урьд хамаг бүхэнд ад шоо болж, жигшигдэн хөөгдөж явжээ. Одоо сонсвол, амьтан бүхэн түүнийг “Сайхан шувуудын дотроос хамгийн сайхан нь буюу” хэмээн шагшин магтаж хэлэлцэхийг дотроо бодож, “Би нугасны муухай дэгдээхэй байх цагт ийм сайхан жаргалыг зүүдэндээ ч зүүдэлсэнгүй.” гэжээ.

*Х.К.Андерсен*



- Энэ зохиол үнэн байж болох уу? Үүнийг яаж мэдэж болох вэ?
- Бяцхан хүүхэд “Шинэ хун, шинэ хун” гэж хэлсний учир юу вэ?
- Нугасны муухай дэгдээхэйн зан чанарыг хүний зан чанартай харьцуулан тайлбарлая.

### Нугасны муухай дэгдээхэйд

#### Тохиолдсон хэцүү зүйлс

- Нугас бүхэн ад шоо үзнэ.
- Олны элэг доог болов.
- Гишгэх газар олдохоо больсон.
- Бүгд сүргээсээ хөөж тууна.
- Ах эгч нар нь ч хөөнө.
- Эх нь ч хамгаалж чадахаа больсон.

#### Тохиолдсон үйл явдал

- Хулс зэгсний дунд хэвтэж байв.
- “Зовлон зүдгүүр үзэж явснаас алагдвал дээр.” гэж бодов.
- Толгойгоо бөхийлгөө.
- Тунгалаг усанд үзэсгэлэнт хун харагдав.
- Залуу хун ихэд ичингүйрэв.
- Бахдан баярлав.
- “Би нугасны муухай дэгдээхэй байх цагт ийм сайхан жаргалыг зүүдэндээ ч зүүдэлсэнгүй.” гэж бодов.

- ихэрхэг, омгорхог бус
- ичимхий

Аль нь түүний зан чанар вэ?

- сайхан, үзэсгэлэнтэй
- аз жаргалтай

5 Зохиолын баатрууд юу гэж хэлсэн, юу хийснийг бичээрэй. Эндээс зан чанарыг нь тодорхойлоорой.

	Хэлсэн үг	Хийсэн үйлдэл	Зан чанар
Эх нугас	_____	Түүнийг дарж хэвтсэн.	_____
Хөгшин нугас	Үүнийг дарахын оронд үр хүүхдээ усанд самруулж сургахыг бод.	_____	_____
Бусад нугас	_____	_____	_____
Ах эгч	_____	_____	Дүүгээ хайрладаггүй.
Хун	_____	_____	_____

### 1 Шүлгийг ойлгохын тулд дутуу үгийг нөхөж бичье.

#### Миний ээж

(Шүлэг)

Монголын үзэсгэлэнт сарангуа, намайг .....	ээж	
Яруу сайхан эгшгээрээ бөн бөн .....	ээж	
Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн .....	ээж	
Зүйтэй уран үгсээрээ сурган .....	ээж	Д.Нацагдорж

**Нөхөх үг** хүмүүжүүлсэн, төрүүлсэн, өсгөсөн, бүүвэйлсэн

- 1) Ямар дарааллаар нөхөж бичсэнээ найздаа тайлбарлая. Цээжилж уншъя.
- 2) Шүлгийг сонсож байгаа хүндээ ойлгуулахын тулд яаж унших вэ?

Монголын үзэсгэлэнт сарангуа, намайг төрүүлсэн ээж  
Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ээж  
Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ээж  
Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ээж



Ээжийгээ хайрласан сэтгэлээ илэрхийлж, шүлгийн агуулгад тохируулан:

- Дууны өнгөө өөрчилнө.
- Үйл хөдлөл хийнэ.
- Нүд, нүүрний хувирлыг гаргана.

### 2 Эхийг уншиж, ойлгоё. Уншихдаа дараах тэмдэглэгээг хийж уншъя.

- Улсын нэрийг ✓ , аймаг, сумын нэрийг — , газар орны нэрийг | тэмдгээр зурж тэмдэглэе.

#### Үзэсгэлэнт байгалийг хэрхэн хамгаалдаг вэ?



Дэлхийн улс орон бүрт байгалийн үзэсгэлэнт газрууд бий. Тэдгээрийг хамгаалахын тулд Дэлхийн байгаль хамгаалах сангаас дэлхийн өвд бүртгэж авдаг. Жишээ нь: Америкийн Нэгдсэн Улсын Их хавцал, Австралийн ойролцоох усан доорх том хад, Викториа, Анхель хоёр хүрхрээ, Байгаль нуур зэрэг нь дэлхийн байгалийн өвийг хамгаалах санд бүртгэгджээ.

Монгол Улс байгалийн үзэсгэлэнт газруудаа “Дархан цаазат газар” болгон хамгаалдаг. Манай оронд ийм газар олон бий. Жишээ нь: Богд хан уул нь Монгол Улсын төдийгүй дэлхийд хамгийн анхны дархан цаазат уул юм.

Мөн Говийн их дархан газар нь Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгийн нутагт оршино. Баянхонгор аймгийн нутагт говийн хамгийн том нуурууд болох Бөөнцагаан болон Орог нуур оршдог.

Харин Хан Хэнтийн дархан цаазат газар нь Хэнтий аймгийн Батширээт, Өмнөдэлгэр, Төв аймгийн Мөнгөнморьт, Эрдэнэ, Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө зэрэг сумдын нутгийг хамран оршдог.

Туул, Хараа, Ерөө, Минж, Захар, Шороот, Онон, Эг, Хэрлэн зэрэг томоохон голууд, тэдгээрийн цутгал олон жижиг гол эх аван урсдаг байна.

3 Эхийг сайн ойлгохын тулд мэдэхгүй үгийнхээ утгыг тайлбарлая.

- 1) Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай уншъя.
- 2) Үгийн утгыг өөрийнхөө ойлгосноор бичээд үзье.
- 3) Энэ үгийнхээ утгыг толь бичгээс олж үзээд, өөрийнхөө бичсэнтэй харьцуулан үзье.

Бичсэн үг	Миний ойлгосон утга	Толь бичигт байгаа утга
ӨВ	.....	.....
эх авах	.....	.....

4) Утгыг мэдсэн бол үгээ оролцуулаад, өгүүлбэр зохиож бичье.

4 Эхийг ойлгохын тулд асуултад хариулж ярилцъя.

- 1) “Дархан цаазат газар” гэж нэрлэсэн нь ямар учиртай вэ?
- 2) Чи ямар, ямар дархан цаазат газрыг мэдсэн бэ?
- 3) Тэдгээр нь аль аймгийн нутагт байдаг вэ? Яагаад хамгаалах болов?
- 4) Мэдэж авсан гол мөрний нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар бичье.

5 Тэмдэглэсэн үгийг яаж бичсэнийг ажиглая.

Монгол Улс  
Баянхонгор аймаг  
Туул гол

Хүний нэрийг том үсгээр бичдэг шүү дээ.  
Бас улс, аймаг, уул ус, гол мөрний нэрийг том үсгээр бичдэгийг мэдэж авлаа.

6 Уншиж ойлгосон эхээс нэрсийг жагсаан бичье.

Улс орон	Аймаг, сум	Газар, нутаг	Гол, мөрөн
<u>А</u> мерикийн <u>Н</u> эгдсэн <u>У</u> лс	<u>Г</u> овь- <u>А</u> лтай	<u>Б</u> огд хан уул	<u>Т</u> уул гол
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....

7 Гадаад үгийг дэвтэртээ бичиж нүдэлье.

Австрали Улс, Викториа хүрхрээ, Анхель хүрхрээ

8 Эхийг уншиж үзье. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичье. Бас ямар дүрмээр бичихээ бодож бичье.

Хоргын тогоо

Нөхөх үг

1. Архангай 2. Тариат 3. Цэцэрлэг 4. Тэрхийн цагаан



Хорго нь (1.) ..... аймгийн (2.) ..... сумын нутагт (3.) ..... хотоос 180 км зайд байдаг, (4.) ..... нуурын хөвөөнд орших унтарсан галт уул бөгөөд найман мянган жилийн өмнө оргилж байгаад унтарчээ. Сонин тогтоц бүхий хад асга, ангал,

хавцалтай, агуй, хонхор гүдгэр ихтэй. Араар нь хуш, шинэсэн ой ургадаг. Хоргын тогооны дэргэд нутгийнхны нэрлэж заншсан чулуун гэр бий.

- Хорго нь хаана байдаг вэ?
- Яагаад “Хоргын тогоо” гэж нэрлэсэн бэ?
- “Хоргын тогоо” юунаас үүссэн бэ?

**Хэрэглэх үг** 1. Өлийн тогоо 2. Суман 3. Чулуут

Хоргын тогооноос гадна Гичгэний баруун зүүн тогоо, (1.)..... Цагаан уул, Залаа толгой, Мандлын тогоо, Шаврын царам зэрэг 33 галт уул бий. Тэдгээрийн дундуур (2.)....., Гичгэнэ, (3.)..... голууд хөөсрөн урсаж энэ нутгийн бас нэгэн гайхамшигт чимэг болдог. Хоргын үзэсгэлэнт газрыг 1965 онд дархан цаазтай болгожээ.

**9 “Тэрхийн цагаан нуур” хэрхэн үүссэн тухай домгийг уншъя.**

- 1) *Үйл явдал тус бүрийн утгыг ойлгоё.*
- 2) *“Тэрхийн цагаан нуур” үүссэн үйл явдлыг холбон зуръя.*

Харин хоргоогдож тогтсон ус нь “Тэрхийн цагаан” нуур болсон гэнэ.

**Тэрхийн цагаан нуур**



Хүмүүс “Хоргоогоорой, хоргоогоорой” хэмээн хашхирч байжээ.

Гэтэл их хэмжээний ус олгойдон гарч, хөндийг дүүргэн аюул болов.



Эрт дээр үед ус авсан хүмүүс худгаа таглахаа мартчихжээ.

3) *Домгийн үйл явдал аль цаг үед болсон бэ?*

**Зөв дарааллыг олж бичихийн тулд яах вэ?**

Зохиолын утгыг ойлгохын тулд асуултын дагуу ярилцъя. Асуултыг ойлгож уялдаа холбоотойгоор хариулбал, зохиолыг зөв дарааллаар бичиж чадна.

**Би өөрийгөө дүгнэе.**

Асуулт	Чадна	Бага зэрэг дэмжлэг хэрэгтэй	Илүү их хичээнэ
Баатруудын зан чанарыг тодорхойлж чадах уу?			
Зан чанарыг хэлэхдээ зохиолоос ашиглаж чадах уу?			
Оноосон нэрийг зөв бичиж чадах уу?			

1 Зохиолч ба зохиолын баатрын яриаг ялгаж мэдэх нь чухал шүү.

1

2 Зохиолын баатрын яриаг төлөөлөн уншъя.

2

3 Үлгэр зохиож бичье.

3


3 Хэлж байгаа санаагаа дууны өнгө, биеийн хөдөлгөөнөөр зөв илэрхийлье.

3

Зохиолын баатруудын үг яриаг ойлгож ялгах  
Дуу хоолой, биеийн хөдөлгөөнөөр дүрийг төлөөлөн хэлэх  
Ойролцоо эсрэг утгыг бататгах  
Үлгэр зохиож бичих



Хурдан унших харааны дасгал хийе.



1 Эхийг уншиж ойлгоё.

Наран хааны Туяа гүнж

(өгүүллэг)

Ертөнцийн гэрлийн их хаантан Наран хязгааргүй удам хөх тэнгэртээ заларч, Туяа хэмээх танхил гүнжээ энхрийлэн өсгөж байлаа.

Уул нэвт үзэсгэлэнтэй, гэр нэвт гэгээтэй Туяа гүнж газар тэнгэрийг холбон солонгорно. Тэнгэрт дуулж, газарт бүжиглээд жаргалтай сайхан байтал нэг өдөр Наран эцэг дуудаж, “Охин минь одоо чи том боллоо. Ажил хийх цаг чинь боллоо.” гэтэл, Туяа гайхаж “Ажил ий? Тэнгэрийн уудмаар тэнэж, тэнд эндгүй л явлаа. Одон ертөнц, огторгуйн хөлөг зөндөө харлаа. Гэвч би тэнд ямар ч хийх ажлыг харсангүй.” гэв.



“Сэтгэл гаргаж хайвал, хийх ажил олдоно. Алив ажлыг сайн хийвэл, аз жаргал аяндаа ирнэ.” гэж хаан эцэг нь айлдлаа. Чингээд Туяа ажил хайж, тэнгэрийн замаар довтолгон одов. Дээшээ доошоо, зүүн тийш баруун тийш, яваагүй газаргүй. Үүлний наана, үүлний цаана хэчнээн хайгаад ч ажил олдсонгүй.

- Энэ хүртэл ойлгосноо асуулт зохион ярилцъя.
- Хаан эцэг, Туяа гүнжид юу гэж хэлсэн бэ?



Тэгтэл Жил гэдэг өвгөн Сар гэдэг хүүхдэдээ гутал оёж суулаа. “Туяа гүнж юу хайгаа вэ?” гэж Жил өвгөн асуув. “Ажил хайж явна” гэтэл, Жил өвгөн жигтэйхэн их баярлаж, “Юун сайн юм бэ? Надад яг одоо туслагч хэрэгтэй байна. Нааш ир, би чамд сайхан ажил өгье.” гэв. Угаас сониуч Туяа өвөөгийн урланд хүрэлцэн очлоо. “Ямар ажил юм бол?” хэмээн догдолж гарлаа. “Амтат чихэр хийх юм болов уу? Гоё тоглоомоор наадах юм болов уу? Тэгтэл

Жил өвгөн, Туяа охинд хоёр цүнх өгөөд, “За үүнийг барьж бай” гэв.

Хоосон хоёр цүнхнээс өөр юу ч байхгүйд Туяа гайхлаа. Тэгтэл Жил өвгөн “Энэ хоёр цүнхийг ав. Цагаанд нь өвлийг, ягаанд нь хаврыг хийгээрэй. Хооронд нь хольж хутгаж болохгүй шүү ” гэлээ. Туяа “За” гээд цүнхийг авсан ч эргэлзэх сэтгэл төрж байлаа. Цүнх нь хүнд, зам нь хол. Тийм ч сайхан ажил мөн гэж үү? Хамгийн гол нь өнгийг хооронд нь хольж болохгүй. Цагаан цүнхийг өвөлд, ягааныг хаварт өгөх ёстой. Өвөл ойртлоо. Туяа гэнэт цүнхээ санав.

• Зохиолд ямар, ямар баатрууд гарч байна вэ?

Одон ертөнц, огторгуйн хөлгийг ялгаж чаддаг боловч өнгөний тухай ойлголт түүнд маруухан байв. Хоёр цүнхний аль нь цагаан билээ? Авч яваа хоёр цүнхээ эргүүлж тойруулж зөндөө үзсэн ч алийг нь өвөлд өгөх билээ хэмээн эргэлзэж гарав. Тэгэхээр нь нүдээ аньж байгаад аль таарснаа өвөлд өгчээ. Үлдсэнийг нь хаварт өгөх нь мэдээж.



Хавар гэртээ байгаагүй тул гуравдугаар сар гэдэг хүүд нь өгчээ. Түүнээс болж, ёстой нөгөө холион бантан гэгч эхэлж. Цэцэглэн буй буйлсын модтой цүнх авсандаа өвөл маш их баярлажээ. Алаг цэцэг дэлгэрээд л, анхилуун үнэр ханхлаад л сайхан байсан гэнэ. Өвөл баярлахдаа нулимс унагаажээ.

Гуравдугаар сар түүнээс дутахгүй баяртай байлаа. Түүний авсан цүнхнээс цагаан цас, хүйтэн жавар гарч, өдөржингөө хүүхдүүдтэй гулгаж, хөгжилдөн наадав. Тэдгээрийг Туяа гүнж хараад, бүхнийг баясгасан буянтай ажил хийлээ хэмээн инээмсэглэж байлаа. Харин Жил өвгөн өвөл буйлс цэцэглэж, хавар жавар тачигнаж бүгд буруугаар эргэсэнд хилэгнэн байв.

Туяа охин хийсэн ажлаа бүтэлгүйтсэнд санаа зовж, ертөнцийн өнгийг ялгаж сурах хэрэгтэй юм байна даа хэмээн бодлоо.

*Зои Валаси (Грекийн зохиолч)*

2) Баатруудын хэлсэн үгээс сонгож, утгыг тайлбарлая.

Наран хаан	Туяа гүнж	Жил өвгөн
Сэтгэл гаргаж хайвал, хийх ажил олдоно. Аливаа ажлыг хийвэл, аз жаргал аяндаа ирнэ.	..... .....	..... .....

- 1) Баатрууд юу гэж хэлснийг бодъё. Тэдний ярианаас юу ойлгосноо ярилцъя.
- 2) Өөрт таалагдсан баатрыг сонгон авч, хэлсэн үгийг төлөөлөн уншъя.
- 3) Баатрууд хоорондоо адил, эсвэл ялгаатай эсэхийг тайлбарлая.

3) Зохиолыг дахин уншихдаа, баатрын дуу хоолойг гаргаж уншъя.

Төлөөлөн уншихад юу чухал вэ?

Зохиолд байгаа баатрууд нь өөр, өөр байдаг. Үүний яриа, үйл хөдлөл өөр байгаагаас мэдэж болно. Ялгаатай байдлыг өөр, өөрөөр илэрхийлж болно.

4) Туяагийн гайхаж байгааг, эргэлзэх сэтгэл төрж байгааг, санаа зовж байгааг яаж илэрхийлэх вэ?



- 1 Дараах зургийг сайн ажиглаад, юуны тухай байж болохыг таамаглан бодъё.



- 2 “Муурын байшин” үлгэрийг сонсоод, мэдэхгүй үг тааралдвал бичиж авъя.  
 3 Үлгэрийн утгыг ойлгож мэдье.  
 4 Баатруудын үг, яриаг ялгая.

### Муурын байшин

1.

**Зохиогч:** Энхрий хүүхэд та нарт энэ үлгэрийг ярья. Алс газраас гарсан Ангар нутгаас ирсэн айхтар нэг муур алтан дэлхийд байжээ. Муур муурнаас өөр гэнэ. Мухлагт хоргодож унтахгүй, байшин бариад суудаг гэнэ. Бамбагар зөөлөн ортой гэнэ. Өнгөтэй торгон хөнжилтэй гэнэ. Өдтэй зөөлөн дэртэй гэнэ.

Өргөн хашааных нь үүдийг өвгөн манаач манадаг юм. Өвгөн муур тэдний өнө цагийн зарц юм. Хашаа байшинг цэвэрлэж, хамаг ажлыг нь хийдэг юм. Цэвэрхэн хашаан дотор нь **чацаргана**, **гүзээлзгэнэ** ургадаг гэнэ. Өвгөн зарц Василий амьтан хүнийг халгаахгүй, айхтар чанд манадаг гэнэ.

Нэг өдөр муурын хоёр ач нь ирж гэнэ. Өнчин хоёр ач нь өнөөх баян муурын хаалга үүдийг нь тогшиж, хайр өршөөлийг гуйжээ.

Энэ хүртэл уншсанаа ярилцъя.

- Энд хэдэн баатар гарч байна вэ? Нэрлэе.
- Зохиогч нь баатруудаас ямар ялгаатай вэ?



Зохиолд байгаа жимсний нэрийг олж зөв бичиж суръя.

Тэгвэл үг бүрийг бичиж үзье.



гүзээлзгэнэ

чацаргана

бөөрөлзгөнө

улаалзгана

боролзгоно



Би үүнийг  
мэдлээ.

Эдгээр үгэнд бүгдэд нь гурван гийгүүлэгч орсон байна. Харин бүх үгийн сүүлийн **н**, **г** гийгүүлэгчийн өмнө эгшиг бичсэн байна шүү дээ.

Тийм байна. Тэгвэл гурван гийгүүлэгч дараалан орвол, сүүлийн гийгүүлэгчийн өмнө заавал эгшиг бичдэг юм байна.

Миний  
мэдсэн зүйл

5 Дараалсан гурван гийгүүлэгчтэй нэр үгийг нүдлэн тогтоож, хуулан бичье.

харцага	чандага	янзага	халбага	батгана
турсага	зулзага	тарвага	хоромсого	хэдгэнэ
хундага	замбага	бортого	зэндмэнэ	бударгана
аньсага	ганзага	чагтага	эрдэнэ	алтаргана
оньсого	хавтага	чогчиго	зээргэнэ	

6 Үг бүрийн утгыг мэдэж өгүүлбэр зохиоё.

- Бударгана, зээргэнэ ихтэй хоолойгоор хөндлөн гарч батгана, хэдгэнэд барцуулах шахав.
- Замбага ургамал мөнх ногоон бутлаг мод, мөн түүнээс ургадаг хуйт цэцэг гэж тольд тайлбарласан байна.



7 Зохиолыг үргэлжлүүлэн уншъя. Хэн хэн юу юу хэлэв.

2.

**Зулзага:**

Өвгөн буурал ах минь  
Өөрийн эзэнд хэлээч  
Өнчин муусайн ач нар чинь  
Өлсөж ядраад ирлээ  
Суудаг муу байшингийн

Суурийг нь хулгана мэрчихлээ  
Хана нь салхи хаахгүй  
Хамхарч унахад хүрлээ  
Дээвэр нь бороо хаахгүй  
Дэрвэсэн хэдэн банз байна  
Гурил будаа ч байхгүй  
Гуринхалж явна бид нар



**Зарц Василий:**

Өрөм идэх гээ юу?  
Өөдгүй амьтад тонил!  
Шилэн дээрээс чинь атгаад  
Шидэж орхино шүү та нарыг

**Муур:**  
Ямар юмнууд ирээд  
Ярвиг өдөв цаана чинь?

Энэ үгийг ямар дуу  
хоолойгоор хэлэх вэ?



**Зарц Василий:**

Өнөөх муусайн зулзаганууд  
Өлслөө гээд явж байна.

**Муур:**

Өөдгүй муусайн амьтдыг

Өөгшүүлж ердөө болохгүй

Бага байж ч үзсэн дээ

Балгаа тарьж яваагүй дээ

Айлын үүд эргүүлдэж

Ад болж яваагүй дээ

Ажил анхиагүй болоод

Аль байдгаа барччаад

Яршиг төвөг удаад

Яах санаатай юм бэ?

**8** Муурын үгийг дөрвөн хүүхэд өөр  
өөр дуу хоолойгоор хэлээрэй.

Өнчин өрөөсөн амьтдыг

Өршөөж тэжээх газар байна

Олиггүй муусайн зулзаганууд

Очоод хэвтвэл боллоо

Уур их хүргэчихвэл

Усанд хийж орхино шүү

(Энэ үед баян муур авгайнд баахан зочид ирэв.)

**Муур:**

Морилж орцгоо нөхөд минь, баярлаж байна авгай нь. (Үүнийг огт өөр дуу хоолойгоор хэлээрэй)

**Зохиогч:**

Урт сахалт ухна, эхнэртэйгээ улсын түрүүнд ирээд суудлын эхэнд суулаа. Уран хоолойт тахиа гуай улаан залаат эхнэртэйгээ эдний дараа ирээд суулаа. Айлын бүдүүн гахай аахилж уухилсаар ирлээ.

Баян муур ирсэн зочдод орон гэрээ танилцуулж, дуртай бүжгээ хийцгээж, дуулж хуурдан наргиж, дулаан зуухаа тойрон сууж үлгэр домог ч хэлэлцэж гэнээ.

Баатруудын  
дуу  
хоолойноос  
өөрөөр  
хэлээрэй.

Яагаад өөр өөр дуу хоолойгоор хэлэв?



..... ?



..... ?




..... ?



..... ?

9 Төлөөлөн хэлэхдээ нүүр царай, биеийн хөдөлгөөнөөр яаж илэрхийлэх вэ?



Даанч сайхан наргилаа  
Дараа баяртай, учиръя  
Ням гараг болохоор  
Нярайлсны баярт очоорой.



**Ямаа:**

Ангараг гарагт манайхаар  
Айлчилж очихыг гуйя

Буд гарагт манайхаар  
Бууж морилохыг гуйя  
Хамт будаа идээд  
Ханзанд сууж наргия

Гажуу зантай боловч  
Урилганд чинь очно би  
Уулзаж ярих юм бий  
Намайг бүү мартаарай  
Найзындаа ирж байгаарай ...



**Зохиогч:**

Баян муур авгай, зарц Василий хоёр зочин олон нөхдөө зохистой ёсоор үдэв. Учиртай олон үгээ ярьж байтал зуухны өмнө дэвссэн зузаан хивс шатлаа. Хоромхон зуурын дотор хуурай түлээ нь ноцлоо. Байшингийн хана түлэгдэж, бараан утаа ихсэв. Гал утаа багсарч, гайт түймэр гарлаа. Василий өвгөн түрүүлээд, баян муур дараалан, гэртээ орж ирээд, гэнэт түймрийг үзлээ. “Гал түймэр гарлаа. Гай түй боллоо” гээд хашхирах чимээ ч дуулдлаа. Гадагш дотогш гүйлээ. Тар няр хийгээд, тааз дээвэр нь шатлаа. Өндөр сайхан байшинг өрвөлзсөн гал ороолоо. Хэрээ түүнийг хараад, хэдэн талаас нь гуаглав. Муурын байшин шатлаа. Муухай явдал боллоо....



Энэ хүртэл уншсанаа ярилцъя.

- Зохиогч ба баатруудын яриаг дууны өнгөөр ялган уншъя.
- Зочид муур авгайд юу гэж хэлж байсан бэ?
- Муурын байшингийн эздэд юу тохиолдов?

10 Дуу хоолой биеийн хөдөлгөөнөө хослуулан илэрхийлье.



Хүүе та минь, хүрз зээтүүгээ барьцгаа  
Түймрийн багаж гаргаад, түргэн хурдан ажиллаарай  
Гахай чи хөдлөөч, гантай ус аваад ир  
Ухна чи гүйгээч, устай хувин аваад ир...



Шигшүүрт ус хийсэн чинь ширгэж гоожоод байх юм  
Утгаад, утгаад байхад утгагдаж өгөхгүй байна...



Шатаж байгаа байшинг минь шаламгай аварч үзээрэй  
Ширээ сандлыг гаргаарай, шил толийг зөөгөөрэй  
Одоо шатаад дуусах нь олигтой хурдан ажиллаарай  
Василий эднийг гуйгаарай, бараа туруу гаргаарай

**Гахай:**

Юу, гэнээ та минь, юу ч дуулахаа байчихлаа

**Минж:**

Хуйхлагдах гээгүй юм бол хурдан зайлцгаа та минь



Голомт нь ингээд баларлаа го-го-го  
Голомт нь ингээд сөнөлөө го-го-го

**Муур:**

Суух оронгүй боллоо



Манах хашаагүй боллоо.

## 11 Үргэлжлүүлэн уншъя. Зохиогчийн дуу хоолойг гаргаж хэлнэ үү.

**Зохиогч:**

Бараан утаа манарч байна. Баян муур уйлж байна. Байшин хашаа ч байхгүй тул өвгөн манаач Василийтайгаа, уриад байсан найзуудындаа ээлж дараагаар очтол өөрсдөө гэртээ тоглож, өөдөөс нь тэднийг хөөв. Хэн нь ч тэр хоёрыг оруулсангүй..

Харин хөөж тууж явуулсан, хөөрхий хоёр ач нь “Зай муутай ч гэсэн шахалдаад багтаж болно. Задгай цоорхой ч гэсэн бөөгнөөд унтаж болно. Дээвэр шалгүй гэртэй, дэвсгэр хөнжилгүй бид, харин шахалдаж хэвтвэл халуун дулаан хононо” хэмээн оруулжээ. Муур авгай “Баян байхдаа би бага сага юмыг базааж өгсөн болоосой, бас тоогүй боллоо. Харам сэтгэлд баригдаад, харлаж байгаа минь энэ дээ” гэж гэмшээд, хоёр хөөрхөн ачдаа өрлөг эх нь болж, өвгөн залуу бүгдээрээ өв хүчээ нийлүүлж байгаад, шинэ байшин барьжээ. Байшин шинээр барьсны баярын хурим хийж гэнээ.

*С.Маршак*

Санал бодлоо сайн ойлгуулахын тулд дуу хоолой, нүүр царайгаараа илэрхийлж болно. Бас бусдын ярьж байгааг ойлгохын тулд дуу хоолой, нүүр царайны байдлыг ажиглавал илүү сайн ойлгоно.

Хүмүүс баярласан, итгэсэн, эргэлзсэн, гайхсан, гомдсон, уйтгарласан үедээ дуу хоолой, нүүр царай нь өөр, өөр болдог.

Би өөрөө яаж хийснээ бодоод, тэмдэглэе.

Асуулт	Тийм	Үгүй
Зохиолыг уншаад ойлгосон уу?		
Баатрын үг яриаг тохирсон өнгө аясаар төлөөлөн уншиж чадсан уу?		
Баатрын үг ярианд тохирсон биеийн хөдөлгөөнийг хийж чадсан уу?		

Х.3

### ОЙРОЛЦОО БА ЭСРЭГ УТГЫГ БАТАТГАЖ ОЙЛГОЁ


Хэрвээ чи хурга “НААШ” дэгдэх утгыг зөвшөөрөхгүй байвал, эсрэг утгыг зөвшөөрч байна гэсэн үг. Тийм үү, хүүхдүүд ээ! Тэгвэл та нар юу гэж хэлэх вэ?

**НААШ** биш **ЦААШ** гэж хэлж болно.

1 Дараах зургийг ажиглан, эсрэг утгатай үгийг олж, бичье.



туранхай биш тарган



.....



.....



.....



.....



.....

.....

2 Зүйр цэцэн үгийг уншиж, утгыг ойлгоё.

- 1) Зүйр цэцэн үгийн утгыг тайлбарлаж бичье.
- 2) Хэрэв эсрэг утгатай болговол, цэгийн оронд ямар үг байж болохыг бодъё.
- 3) Эсрэг утгатай үгийг нөхөж бичье.

**Эрт** босвол нэгийг үзнэ  
..... унтвал нэгийг сонсоно

**Бурууг** хэлж  
..... сонс

**Сайныг** дагавал сарны гэрэл  
..... дагавал могойн хорлол

Нүдээр үзсэн бүхэн **үнэн**  
Чихээр сонссон бүхэн .....

- 3 Дараах үгсийн утгыг толь бичгээс хараарай. Тайлбарыг бичиж аваарай. Эсрэг утгатай үгийг нь олж бичээрэй.

битүү - задгай	дуусах - эхлэх
хялбар - .....	сулрах - .....
гэрэл - .....	тарах - .....
ийм - .....	нийлэх - .....
орлого - .....	дэлгэх - .....
олонх - .....	үрчийх - .....

- 4 Эдгээр үгээр өгүүлбэр зохиож бичээрэй.

- 5 “Хоёр нь” шүлгийн мөр бүрд байгаа эсрэг утгатай үгийг ялган бичье. Ямар утгатай байгааг найздаа хэлж өгье.

### Хоёр нь

Саруул мунхаг хоёр нь  
 Онох эндүүрэх хоёр  
 Цагаан хар хоёр нь  
 Авах гээх хоёр  
 Өвөл зун хоёр нь  
 Хүйтэн халуун хоёр  
 Төрөх үхэх хоёр нь  
 Бүтэх эвдрэх хоёр

Д.Равжаа



- 6 Дараах үгс ойролцоо утгатай байгааг өгүүлбэрт оруулж илэрхийлнэ үү.

хэлэх - бурах - хадуурах - ярих - нурших - өгүүлэх - чалчих

- 7 Дараах өгүүлбэрийн цэгийн оронд ойролцоо утгатай үгийг нөхөж бич.

Алсыг зорин хөдөлцгөөв.

Алсыг зорин .....

Алсыг зорин .....

- 8 “Явах” гэсэн үгтэй ойролцоо утгатай үг гурав байгааг олж бичнэ үү.

Би найзуудтайгаа жимс түүхээр шийдэв. Биднийг хөдлөхөд орж байсан бороо арилж тэнгэр цэлмэсэн байлаа. Замд гарахад ээж минь бүүр алс холд удаан хугацаагаар одох гэж байгаа юм шиг л өдий төдий юм бэлдэж билээ.




Ойролцоо утгатай үгийн бичлэг нь өөр, өөр байна. Харин утга нь ойролцоо байх юм. Ойролцоо утга нь өгүүлбэр, эхэд илүү ялгарч мэдэгдэнэ.

9 Дараах ойролцоо утгатай үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич.


унтах - нойрсох, найз- нөхөр, уурлах - хилэгнэх, хуурах - молигодох,  
хүйтэн - сэрүүн, тоглох - наадах, настай хүн - хөгшин хүн

1 “Муурын байшин” зохиолын баатруудын хэлсэн үгийн гол санаа нь юу вэ? Нухацтай бодоод бичиж үзье.

**Муурын байшин**  
(Үлгэрээс)

	Даанч сайхан наргилаа Дараа баяртай, учиръя Ням гараг болохоор Нярайлсны баярт очоорой	<b>Гол санаа нь:</b> Муурыг өөрийн гэрт урьж байна.
	Ангараг гарагт манайхаар Айлчилж очихыг гуйя Таанатай хоол зооглохоор Та манайд очоорой.	<b>Гол санаа нь:</b>
	Буд гарагт манайхаар Бууж морилохыг гуйя Хамт будаа идээд Ханзанд сууж наргия	<b>Гол санаа нь:</b>

2 Дээрх баатрууд яагаад ийм утгатай үг хэлсэн бэ? Ойролцоо утгатай байна уу, эсрэг утгатай байна уу? Чи юу гэж бодож байна? Шалтгааныг тайлбарлаарай.



.....  
.....  
.....



.....  
.....  
.....



.....  
.....  
.....

3 Ойролцоо утгатай үгийг олж бичвэл, ямар үг бичих вэ?

наргих - цэнгэх  
тоглох - .....

уулзах - .....  
..... - .....

айлчлах - .....  
идэх - .....

4 Ойролцоо утгыг олж, холбон бичье.

эрээн <input type="radio"/>	овжин <input type="radio"/>
сураг <input type="radio"/>	харах <input type="radio"/>
үзэх <input type="radio"/>	цоохор <input type="radio"/>
сагсуу <input type="radio"/>	бөглүү <input type="radio"/>
зальжин <input type="radio"/>	чимээ <input type="radio"/>
алс <input type="radio"/>	онгироо <input type="radio"/>

5 Эхийг уншиж ойлгоё.

**Хүний сэтгэл санаа**  
(Домог үлгэр)

Эрт цагт хоёр бурхан, хүнийг бүтээжээ. Тэгээд түүний сэтгэл санааг нь ямар болгох тухай ярилцаж гэнэ. Нэг нь “Хун шиг цагаан” болгоё гэж. Нөгөө нь “Хэрээ шиг хар” болгоё гэжээ. Тэгээд нэг бурхан нь:

- Хэрэв хэрээ шиг хар болгочихвол, хүн чөтгөр шулам шиг муухай санаатай болно доо гэхэд, нөгөө бурхан нь:

- Хэрэв хун шиг цагаан болгочихвол, хүмүүс хэтэрхий сайхан санаатай болж, бүх идэх юмаа амьтанд хувааж өгөөд өөрөө өлсөж үхэх болно. Ингэхлээр хүний сэтгэлийг шаазгай шиг алаг хийе гэжээ.

Тийм учраас хүний сэтгэл санаа шаазгай шиг алаг эрээн, хар цагаан болсон гэнэ.

6 Баатруудын хэлсэн үг эсрэг утгатай байна. Үүнийг батлах жишээг зохиолоос олж бичье.

	Ямар болгох вэ?	Ямар болох вэ?
Нэг бурхан нь:		
Нөгөө бурхан нь:		
Зохиогчийн хэлсэн үг:		

7 Зүйр цэцэн үгийг уншиж, утгыг ойлгоё.

1) Эсрэг утгатай үгийг олъя

2) Өгүүлбэрийг гүйцээн бичье.

Өдрийн бодол  зүүд.

Хал нь гаднаа хайр нь .

санаатын чих дүлий

Хүнд тус хийвэл  тус ирнэ.


Сайн санаатын нүд хурц.





## ТӨЛӨӨЛӨН УНШЪЯ

Хурдан унших харааны дасгал хийе.



### 1 Зохиолын эхлэлийг уншиж ойлгоё.

#### Ах уурлавал ч уурлаг

Миний ах шиг тайван, сайхан сэтгэлтэй хүн ер нь ховорхон байх аа. Орчлонгийн бүх хүн тийм уур уцааргүй байдаг бол мөн ч сайхан биз дээ гэж бодож явдаг байлаа. Ахыг алс холын аян замын тээвэрт яваад ирэхэд машиных нь тоос шороог сайтар арчиж, цэвэрлэсээр байгаад сүүлдээ бүр хэвшил болчхоод ахаар хэлүүлэлгүй өөрөө л санаачлаад хэзээний л цэвэрлэчихсэн байдаг болов. Ах минь ч миний энэ туслалцаанд их л тааламжтай байдаг.



Ахдаа итгэсэн баяртай царайгаар өөртөө итгэлтэйгээр төлөөлөн уншъя.

#### 1) Эхийн агуулгыг ойлгохын тулд асуулт зохион ярилцъя.

Нэг өдөр хичээлээсээ иртэл ах минь учир зүггүй уурлаж намайг балбахаар нь би ухаан жолоогүй зугтав. Огт уурладаггүй хүн чинь уурлахаараа мөн ч мундаг юм байна билээ. Ахын минь хэзээний эмх замбараа муутай байдаг буржгар хүрэн халимаг нь тал тал тийшээ мушгиран сагсайж, онигордуухан нүд нь санаснаас хэтэртэл томорч, бахим бүдүүн гар нь муна адил харагдаж билээ. Би айсандаа болоод гэртээ ирэлгүй, өвөөгийн дөө хонолоо.



Айсан царайгаар, толгойгоо бага зэрэг хөдөлгөн, зөөлөн дуугаар төлөөлөн уншъя.

#### Эхийн агуулгыг сайн ойлгохын тулд асуултаар ярилцъя.

- 1) Дүү нь яагаад ухаан жолоогүй зугтсан бэ?
- 2) Ах нь уурлахаараа ямархуу байдалтай болдог вэ?
- 3) Ах нь дүүдээ уурлах болсон шалтгаан нь юу вэ? Төсөөлөн бодоорой.

### 2 Эхийг сайн ойлгохын тулд мэдэхгүй үгийнхээ утгыг тайлбарлая.

1) Тэр үгийнхээ ойр орчмын үг өгүүлбэрийг дахин анхааралтай уншъя.

Бичсэн үг	Миний бодлоор	Толь бичигт байгаа утга
Муна адил	.....	.....

### 3 Эхийг үргэлжлүүлэн уншъя.

1) *Уншихдаа тодруулсан асуултын оронд зохих үгийг нөхөж уншъя.*

Нөхөх үгс	Нөхөх үгс
торгуулаад, арчсанаас, зугтаагаад, будаад, явахдаа, арчиж	би, машиныг, хүнээс, дугаарыг, шавраар, чи, зээр, хууль, ахын,

2) *Баатруудын хэлсэн үгээс сонгон, төлөөлөн хэлье.*

3) *Найзуудынхаа яаж хэлж байгааг ажиглая.*

... Маргааш нь айж хургасаар иртэл ах алга, эгч л хоёр хүүтэйгээ байв.

- Эгч ээ, ах яагаад надад тэгж их уурлав аа?

- Ах чинь (яагаад?) иржээ.

- Юунаас болов? Машиныг би муу цэвэрлэснээс тэр үү?

- Үгүй, үгүй. Харин чи ахынхаа (юуг?) сайн (яаснаас?) болсон юм байх.

- Яагаад тэр вэ? Машиныг нь сайн арчиж болохгүй болоо юу. Хачин юм аа.

- Ах чинь (яагаад?) гүйцэгдээгүй юм гэнээ.

- Юунаас?

- Уурын тэрэгний (хэнээс?)

- Тэгээд яачихсан юм бэ?

- Машины нь (юуг?) үзчихээд л дараа нь дуудаж аваачаад торгочхож

- Хэдэн төгрөгөөр?

- Нэлээд их юм байх аа.

- Миний буруу нь юу билээ. Ах яагаад торгуулав аа?

- Ах чинь машиныхаа (юуг?) Цагаан голын салдаггүй (юугаар?) (яагаад?), мэдэгдэхгүй болгочихсон байсныг чи цэвэрлэчихсэн байжээ. Уржигдар үүрээр (яахдаа?) чиний арчиж цэвэрлэснийг мэдэлгүй яваад тийм хэрэг болж гэнэ.

- Ах юунд явсан юм бэ?

- Ах чинь хоёр танилтайгаа (юуг?) хөөж яваад мэдэгдчихэж.

- Өө хөөрхий, ах минь (юуг?) зөрчиж явсан юм уу. Тэгвэл миний буруу биш, (хэний?) буруу байна. Үүнээс хойш ахын машины дугаарыг хамгаас түрүүнд улам сайн (яаж?) байх юм шүү. Ах уурлавал ч уурлаг.

*Ц.Дашдондог*

4) *Асуултын дагуу ярилцъя.*

1. Ах яагаад уурласан талаарх чиний төсөөлөл зөв байв уу?	1. Дүүгийн хийсэн үйл сайн үйлс болж чадах уу? Үгүй юу? Яагаад?
2. Ахыг торгуулсанд дүү гэмших болов уу?	2. Ахын хийсэн үйлийг чи юу гэж бодож байна?

### 4 Хэлсэн үг, хийсэн үйлээр нь баатруудын зан чанарыг тодорхойлж бичье.

Эгч	.....	.....
Ах	.....	.....
Дүү	.....	.....

5 Дүүгийн зан чанарыг бодвол ямар дуу хоолойгоор хэлэх вэ?



“Үүнээс хойш ахын машины дугаарыг хамгаас түрүүнд улам сайн угааж байх юм шүү. Ах уурлавал ч уурлаг.” гэж хэлсэн. Учир нь .....

6 Ах дүү хоёр уулзвал бие биедээ юу гэж хэлэх бол? Яаж хэлэх бол.

Зохиол яаж үргэлжлэх байсан бол?		
Хэлэх үг	Таамаглал 1	Таамаглал 2
Ахын хэлэх үг	.....	.....
Дүүгийн хэлэх үг	.....	.....

7 Зүйр цэцэн үгсийг зохиолын баатруудад зориулан хэлье.

- 1) Зүйр цэцэн үгсийн утгыг ярилцъя.
- 2) Хэнд ямар үгийг яаж хэлэх вэ?




Үнэн хүчтэй

Буруу юмыг бүү өмөөр  
Бусдын юманд бүү шуна

Унах бүр ухаан орох  
Ойчих бүр санаа авах

Итгэлийг олоход үнэн хэрэгтэй



8 Би яаж хийснээ бодоод, харандааг будъя.

Асуулт	Хариулт
Баатруудын хэлсэн үгийг сайн ойлгосон уу?	
Тэдний дуу хоолой өөр, өөр байгаагийн учрыг хэлж чадах уу?	
Төлөөлөн хэлснээр хүмүүс өөр өөр байдгийг ойлгож чадсан уу?	
Ойролцоо ба эсрэг үгээр өгүүлбэр зохиож чадах уу?	



- 1 Үлгэрийг уншиж ойлгоорой. Заан хулгана хоёрт юу тохиолдсоныг багаараа ярилцаарай.

### Илэрхий өчүүхэн хулгана их биет зааныг босгосон үлгэр

Эрт цагт нэгэн хулгана гүн нүхэнд ороод эргэн гарч чадалгүй удсан тул өлсөж цангахын эрхээр гаслан гийнаж, уйлан дуугарахыг нүхний дэргэд байсан заан сонслоо. Заан түүнийг өрөвдөөд арга сэдэж нүхнээс гаргав. Тэгтэл өчүүхэн хулгана тоймгүй баярлаж:

- Чи миний амийг аварсан тул ачийг чинь би хэзээ ч мартахгүй. Хэзээ нэгэн цагт би чиний ачийг хариулж чамд туслах болно хэмээн өгүүлсэнд заан:

- Чиний цөхөрсөн дорой дууг сонсоод би тэсэлгүй өрөвдөж гаргасан билээ. Чамаас би хариу хүсэхийн тул гаргасан бус. Тиймээс чи сэтгэл амар явагтун гэж хэлээд яван оджээ.

Түүнээс урт хугацаа өнгөрсөн хойно заан өтөлж доройтсон бөгөөд нэгэн давчуу газарт хөрвөж унаад босож чадалгүй уйлан дуугарахыг өнөөх хулгана сонсож гэнэ.



- 2 Зургийг ажиглаад дээрх үлгэрийн төгсгөлийг зохиож бич.

- 3 “Цэцэн түшмэл” үлгэрийн хэсгийг уншаад, эхлэл, төгсгөл хэсгийг зохиож бичье.

#### Эхлэл хэсэг:

Хаана болсон, хэзээ болсон, яах гэж уулзсан тухай бичнэ.  
Ноён юу гэж асуусныг бичнэ.

#### Гол хэсэг:

Ноёнтны асуултад түшмэл ийнхүү хариулжээ. Хун шувуу хүзүү урттай, гэдэс томтойн учир дуу нь цээл сайхан болжээ. Нарс мод үндэс холтой, иш бүдүүн учир мөнх ногоон ургажээ. Та язгуур өндөртэй, заяа ихтэй учир их сахалтай төржээ хэмээн хариулжээ.

**Төгсгөл хэсэг:**


Үүнийг сонссон ноён .....  
.....  
Ингэж цэцэн түшмэл цолтой болж гэнэ ээ.

**4 Баатар, Банхар гэдэг хоёр нохойны тухай үлгэр зохиож бичээрэй.**

Баатар нь манай нохой  
Банхар нь айлын нохой.

.....  
.....  
Банхар гэрийн хаяанд  
зүүдлэн унтаж.

.....  
.....  
Харин аргамжаатай морьд,  
айл хотлоо Баатар л эргэж тойрно. ....



**5 Дараах сэдвүүдээр үлгэр зохиож бичье.**



Шидэт нөмрөг



Үнэг муур хоёр

Сайхан сэтгэлтний тухай



## 6 Дараах домог үлгэрийг уншаад яаж бичсэнийг ярилцаарай.

### Туулай яагаад сэтэрхий уруултай болсон бэ?

(Домог үлгэр)

Эрт урьдын цагт туулайнуудын хамгийн ахмад нь бусдыгаа цуглуулж:

- Энэ дэлхийн амьтан болгон аливаа амьтдыг айлгадаг эрдэмтэй, амиа хамгаалдаг арга ухаантай байх юм. Бидэн шиг өрөвдөлтэй амьтад энэ ертөнцөд алга. Модны навчис сэржигнэхэд хүртэл уушги зүрх амаар гарчих шиг болж ухаанаа алдтал айх юм. Бид амьтан болгоноос дорой төрөх гэж дээ. Хорхой шавж хүртэл биднээс айдаггүй гэж үү? Ах дүүс минь, ингэж айж зовж амьд явснаас худагт унаж үхэцгээсэн нь дээр гэж бусдыгаа дагуулан гунигтай гэгч нь явжээ.

Эхлэл хэсэг

Тэгтэл нэгэн шаазгай тааралдаж. Шаг шаг туулайнууд минь юу болов гэж асуув. Тэд юу ч дуугарсангүй.



Шаазгай дахиад л шаг шаг, та нар яагаад ийм гунигтай явна вэ? Надад яриач гэж шалгаажээ. Нөгөө ахмад туулай энэ дэлхийд бид л бүх амьтнаас айж явна уу гэхээс биш, биднээс айдаг амьтан гэж нэг ч алга. Ингэж амьд явснаас худагт унаж үхье гэж ярилцаад

Гол хэсэг

явж байна.

- Яасан тэнэг юм бодоцгооно вэ?

- Тэнэг юу байх вэ? Үнэн маань ийм л байна.


- Тэгвэл одоо та нар дор дороо хяраад хэвтэцгээ. Хоньчин хонио услах гээд худаг руу туугаад ирж байна. Хонин сүргийг дэргэдүүрээ ирэхэд нь тал тал тийшээ босон харайгаарай. Тэгэхэд л та нар үнэн худлыг мэдэх болно. Туулайнууд шаазгайн хэлснээр бут бутны ёроолд хярж байгаад хонин сүрэг ирмэгц, босон харайж дээр дээр дэгдэн үсэрч харсанд, хоньд хуйлран үргэж хоньчин нь хонио тогтоох гээд шилбүүрээ далайн хашхиран гүйж явна гэнэ. **Туулайнууд тэр дороо гайхан зогсож:**

- Энэ олон хонийг эзэнтэй нь айлгалаа. Ийм сонин юм гэж байдаг аа гээд хойд хоёр хөл дээрээ оцойн сууж тачигнатал хөхрөлджээ.

Хөхрөлдөөд л байж хөхрөлдөөд л байж, дээд уруулаа сэтэртэл хөхрөлдөж гэнэ. Ингээд туулай сэтэрхий уруултай болсон юмсанж.

Төгсгөл хэсэг

## 7 Заан яагаад урт хошуутай болсон тухай үлгэр зохиож бичээрэй.



1) Дараах үгсийг ажиглая. Яаж бичсэнийг тайлбарлая.

гэмт цант сүүдэрт уст мөст	+	НА НЭ НО НӨ	→	гэмт <b>э</b> нэ цант <b>а</b> на сүүдэрт <b>э</b> нэ уст <b>а</b> на мөст <b>ө</b> нө	1) Эхэд ингэж бичигдсэн үг байна уу? Түүж бичье.
--	---	----------------------	---	--	--

2) 1 - д байгаа загварыг хараад зөв бичье.

Хэвт малт тогт бууралт шаргалт	+	НА НЭ НО НӨ	→	..... ..... ..... ..... .....	1) Бичсэнээ шалгая. 2) Найздаа тайлбарлаж өгье.
--	---	----------------------	---	---	--

3) Дараах үгсийг ажиглая. Яаж бичсэнийг ярилцъя.

бодог <b>д</b> санаг <b>д</b> хараг <b>д</b> үзэг <b>д</b> мэдэг <b>д</b>	+	НА НЭ НО НӨ	→	бодог <b>до</b> но санаг <b>да</b> на хараг <b>да</b> на үзэг <b>дэ</b> нэ мэдэг <b>дэ</b> нэ	туслал <b>ц</b> бодол <b>ц</b> харил <b>ц</b> бичил <b>ц</b> зуурал <b>ц</b>	+	НА НЭ НО НӨ	→	туслал <b>ца</b> на бодол <b>цо</b> но харил <b>ца</b> на бичил <b>цэ</b> нэ зуурал <b>ца</b> на
---	---	----------------------	---	---	--	---	----------------------	---	--

4) 3 - д байгаа загварыг ажиглаад зөв бичье.

хэл хар хий хуур яв	+	- лц - гд	+	НА НЭ НО НӨ	→	..... ..... ..... ..... .....
---------------------------------	---	--------------	---	----------------------	---	---




Бусдын ярьсныг тодруулж, лавшруулж асууж суръя  
Хамтдаа хэлэлцэн ярьж суръя





## БУСДЫН ХЭЛСНИЙГ ТОДРУУЛАН АСУУЖ ОЙЛГОЁ

Хурдан унших харааны дасгал хийе.




### 1 Зохиолыг уншиж, утгыг ойлгоё.

1) Монголчуудын үндсэн сууц болох гэр яаж үүссэнийг ойлгоё.

#### Гэр

(Өгүүллэг)

1.



Монголын дээд өвөг хээрээр гэр, хэцээр дэр хийж явсан өнө эртний үед юм гэнэ ээ. Хөх цэнхэр дээвэртэй, хөрст ногоон дэвсгэртэй орчлон дэлхий хэмээх оосор бүчгүй нэгэн их гэрт хүн амьтан цөмөөрөө л эвтэй сайхан амьдардаг байжээ. Тэгтэл юунаас болсныг бүү мэд, нэг л мэдэхэд хоорондоо муудалцан уралцаж, хүчтэй нь хүчгүйгээ барьж идэхэд хүрэв гэнэ. Амьтад мөр мөрөө хөөн салж, зарим нь газар нүхлэн шургаж, нэг хэсэг нь усны гүнд нөгөө хэсэг нь модны оройд гэртэй болжээ.

Газар малтах хумс, усанд залах сэлүүр, тэнгэрт нисэх жигүүр хүнд байсангүй. Харин хүссэн бүхнээ хийж чадах ухаан гэгчийг түүнд заяажээ. Тэр цагт насан өндөр болтлоо ухаанаас ондоо өв хөрөнгө хураагаагүй нэг өвгөн байж гэнэ. Нэгэн өдөр долоон хүүдээ: “Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно.” гэхэд хөвгүүд нь бодоод бодоод учрыг үл ойлгов гэнэ.

Өвгөн ханаран хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг, өмнийн хадан хавцлаас санаа авч хаалга урлав. Чанх дээр голлосон үдийн нарнаас тооно, тал тийш урссан алтан цацрагнаас нь унь, уулын араас ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ.

Түшилдэн ханхайсан уул нуруудын араар сансрын хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа гэж бодуутаа хялгас томж бүслүүр хийв ээ. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, уриа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нарны гэрлийг наашлуулж татдаг, салхины хүчийг цаашлуулж хорьдог, нүүе гэвэл эвхээд ачдаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр хийсэн өвгөн буурал эцгийнхээ ухаанд хөвгүүд нь биширч аятай тавтай аж төрөх болжээ. Гэвч үлгэр үүгээр дууссангүй.

### 2 Энэ хүртэл уншсан, сонссоноо бодоод, ойлгоогүй зүйлээ тодруулан асууя.

1) Юуг дуурайлган гэрийг бүтээснийг яаж асуух вэ?

о Ухаант өвгөн гэр барих санааг юунаас авсан бэ? гэж асууж болно.



*Би дэмжиж байна.*

“Энэ асуулт зөв байна.

Би ч ингэж асуух байсан.”

- Дуурайлгахын тулд санаа авсан биш үү? гэж тодруулан асууж болно.

*Би дэмжихгүй байна.*

“Гэрийг бүтээхдээ юу юуг дуурайлгасан бэ?” гэж асууна.



2) Дуурайлган хийсэн зүйлсийг олж бичье.

Уулсыг	Хана
Хадан хавцлыг	.....
Нарыг	.....
Нарны цацрагийг	.....

Уулын арын манан буданг	.....
Үүлсийг	.....
Салхийг	.....
	.....

3) Юуг, юугаар дуурайлган хийснийг загварчлан холбоё.



2.

Урт насалж удаан жаргасан өвгөн аав нь нэг өдөр хэвтэрт орж, хөвгүүдээ тойруулан суулгаж:

- Төрөх нэг өдөр байхад төгсөх нэг өдөр бий. Ханан гэрээсээ аав нь хадан гэртээ буцах боллоо. Яаж аж төрөхийг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү бүслүүрээ л чангалж яваарай! гээд насан өөд болжээ.

Хөвгүүд нь урьдын адил мөн л учрыг ололгүй гайхаж хоцров. Тэгтэл нэгэн өдөр гэрийнх нь бүслүүр суларчээ. Бие биедээ найдсаар хэн нь ч чангалж таталгүй суутал гэр нь яажийж унав гэнэ. Ах дүү долоо чамаас боллоо, танаас боллоо гэлцэн хэрэлдэж сүүлдээ бүр таарч тохирохоо больж, тарж салахдаа хүрчээ. Эцгээс үлдсэн хөрөнгийг эн тэнцүү хувааж авахаар шийдээд, хана, унь, хаалга, тооно, дээвэр, туургаа салган үүрч харсан зүгтээ одоход, отгон дүүд нь бүслүүрээс өөр юм үлдсэнгүй.

Ууган хүү нэгэн газар хүрч хаалгаа босгон хэрүүл уруулгүй амар жимэр сууж байтал өдөржин хурц нар төөнөөд арай л шатаачихсангүй. Удаах хүү сараалжин ханаа дэлгээд унтаж хэвттэл гэнэт ширүүн бороо асгаж, аянга тасхийж эгээтэй л ниргэчихсэнгүй.

Дараах хүү туургандаа хоргодон суутал уулын үер урсгаад явчхаж. Бас нэг нь дээвэр дороо амарч хэвттэл, хуй салхи босож, хуу татаад хаячхав гэнэ.

Нөгөө нь толгой дээрээ тооноо өргөөд сууж байтал шөнө болж, араатан чоно тал талд нь архиралдаж золтой л хүү татчихсангүй.

Униа боож овоохойчлоод хоргодож суусан нэгийг нь хүйтэн жавар хайрч хөлдүүс болгох дөхөж гэнэ. Бүслүүрээс ондоо юм үлдээгүй болохоор отгон дүү нь бүүр ч хэцүү байсан нь мэдээж.

Тэгтэл нэг өдөр түүн дээр хана үүрсэн ах нь буцаад иржээ. Удаах ах нар нь удалгүй хаалга, тооно, унь дээвэр, туурга үүрсээр ар араасаа цувран айсуй. Тэгээд тэд гэрээ эв хаваар нь золгуулан барьж бүслүүрээ чангалан татлаа.

Тийнхүү долоон хүү өвгөн буурал эцгийнхээ гэрээс үгний учрыг сая л ухаарч түүнээс хойш үеийн үед сургаалтай өргөө цагаан гэрээ эвийн сүлд болгон дээдэлсээр амар сайхандаа жаргажээ. Ж.Дашдондог



## УНШСАНАА ХЭЛЭЛЦЭЖ СУРЦГААЯ

1) Зохиолоор юу сургамжилсан гэж бодож байна вэ? Хэлэлцэж ярилцъя.

Сургамж 1 .....	}	<input type="radio"/> Зөв	ЯАГААД ГЭВЭЛ .....
Сургамж 2 .....			
Сургамж 3 .....			

2) Зүйр цэцэн үгсийг уншиж, утгыг ойлгоё.

- 1) Цээжлээд ярихдаа хэрэглэе.
- 2) Дээрх зохиолын баатруудад хэлэх зүйр үгийг олж бичье.

Сайн хүн ажлаараа	Эв түмэн лан	Намаржин наргиад
Сагсуу хүн амаараа	Эрдэм мянган лан	Өвөлжин үрчийх
Ном утгатай	Эвдэхэд хялбар	Эвт шаазгай
Нас тоотой	Эвлүүлэхэд бэрх	Буга барина
Юманд учир	Аавын ачийг өнгөрсний хойно	
Суманд гичир	Айлын ачийг нүүсний хойно	

3) Асуултын дагуу ярилцъя.

*Гэрийг аль нэг модгүйгээр барьж болох уу?*

- Тийм бол үүнийг яагаад дэмжиж байгаагаа уншсанаасаа санаа авч, батлаарай.
- Зөвшөөрөхгүй бол бас түүнийгээ батлаарай.








4) “Гэр нь үндэсний баялаг юм.” гэдгийг хэлэлцье.

- 1) “Дэмжиж байна”, эсвэл “Дэмжихгүй байна” гэсэн асуултаар баг дотроо хэлэлцээрэй. Хэлэлцэхдээ уншсан зохиолоос жишээ авч болно.

	Дэмжиж байна, яагаад гэвэл:	Дэмжихгүй байна, яагаад гэвэл:
Монгол гэр нь байгаль дэлхийгээс санаа авч хийсэн монголчуудын үндэсний баялаг юм.		

5) Гэрийн тухай оньсогыг хэлэлцэн тааж, дэвтэртээ тайлж бичье.

1) Зөв хариутай холбон тэмдэглэе. Жишээ нь: Ханыг “Сээр шиг нугалж сэмж шиг дэлгэнэ” гэж оньсоголсон нь буруу. Яагаад гэвэл сээр шиг нугалбал хана хэдэн хэсэг болж сална шүү дээ гэх мэт.

<input type="radio"/> Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй.	<input type="radio"/> 
<input type="radio"/> Сээр шиг нугалж Сэмж шиг дэлгэдэг.	<input type="radio"/> 
<input type="radio"/> Эгч дүү хоёр Эн чацуухан.	<input type="radio"/> 
<input type="radio"/> Сар шиг дугуй, Сэмж шиг садархай	<input type="radio"/> 
<input type="radio"/> Урт хүн уландаа үстэй.	<input type="radio"/> 
<input type="radio"/> Ишигний эвэр ийшээ тийшээ.	<input type="radio"/> 
<input type="radio"/> Гүн худгийн гүйдэг могой хүчтэнээс хамгаална.	<input type="radio"/> 

6) 5-д байгаа оньсого, зурагтайгаа тохирч байна уу? Мэдэхийн тулд зохиолыг уншъя. Уншсанаа бичье.


**Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй**

(Оньсогон өгүүллэг)


Манайхан “Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй”-г барих боллоо. Хамгийн түрүүнд “Сээр шиг нугалж, сэмж шиг дэлгэдэг”-ээ тойруулаад, “Эгч дүү хоёр эн чацуухан”-ыг голлуулав. Тэгээд дараа нь “Чи түүгээр яв, би үүгээр явъя, билүүтийн голд уулзъя”-гаа чангалж бэхэллээ. Аав “Сээр шиг нугалж, сэмж шиг дэлгэдэг”-ийн яг голд зогсоод, “Сар шиг дугуй, сэмж шиг садархай”-г өргөн, дүү бид хоёр “Урт хүн уландаа үстэй”-г ойртуулж туслахад ах эгч нар “Ишигний эвэр ийшээ тийшээ”-г тойруулан, “Сар шиг дугуй, сэмж шиг садархай”-д өлгөв. Аав “Гүн худгийн гүйдэг могой хүчтэнээс хамгаална”-д хүнд юм уялаа.

Ах, эгч нарт дүү бид хоёр “Урт хүн уландаа үстэй”-г ойртуулж өгөхдөө “Гэрээр дүүрэн гэлэнгийн олбог”-ийг дөрөөлж болохгүйг сануулж байлаа.

Ш.Энхбаяр



Үнэндээ энэ чинь илжигний  
тухай юм уу, эсвэл хүмүүсийн  
тухай юм уу?



Өвөө хүү хоёрын  
зөв үү?

## ЮУ СҮРСНАА БАТАТГАН ДАВТЯ.

Зургаас үйл явдал зохиож ярих  
Үйл явдлыг ойлгох, таамаглах  
Баатруудын зан чанарыг тодорхойлох  
Хэлсэн үгийг төсөөлөх  
Учир шалтгааныг тайлбарлах, асуулт зохиох

1 Дараах зургийг ажиглая. Ямаа үүрч яваа хүүд 3 хүн юу, юу гэж хэлснийг уншъя.




Та яагаад мөрөн дээрээ нохой үүрч яваа юм бэ?  
- Чи сохор юм уу? Нохой биш ямаа байгаа биз дээ?  
- Уучлаарай, би танд юу үзсэнээ л хэлж байна.



- Та яагаад үхсэн тугал үүрч яваа юм бэ?  
- Үгүй ээ, энэ чинь амьд ямаа.  
- Таныг, ямар амьтан үүрч явааг би мэдэхгүй, гэхдээ харснаа л хэллээ.



Та яагаад илжиг үүрч яваа юм бэ?  
Хүмүүс шоолно шүү дээ гэжээ.



Хүүд үг хэлсэн энэ гурван хүн хэн юм бол?  
Яагаад ингэж хэлсэн юм бол?

2 Илүү сайн мэдэхийн тулд “Ямаа, чөтгөр хоёр” зохиолыг уншъя.

**Ямаа, чөтгөр хоёр**

Аавын хэлснээр хүү нь зах дээрээс нэг ямаа худалдан авав. Тэгээд ямаагаа мөрөн дээрээ үүрээд, сэтгэл хангалуун гэгч нь харихаар алхлаа. Түүний хойноос гурван хулгайч дагав. Эхний хулгайч нөгөө хүү дээр очиж:

- Та яагаад мөрөн дээрээ нохой үүрч яваа юм бэ? гэлээ.
- Чи сохор юм уу? Нохой биш ямаа байгаа биз дээ?
- Уучлаарай, би танд юу үзсэнээ л хэлж байна.

Дараа нь хоёр дахь хулгайч нөгөө хүү рүү очоод:

- Та яагаад үхсэн тугал үүрч яваа юм бэ? гэв.
- Үгүй ээ, энэ чинь амьд ямаа.

- Таныг, ямар амьтан үүрч явааг би мэдэхгүй, гэхдээ надад юу **харагдана** түүнийг л хэлж байна.

Хэсэг азнаад гурав дахь хулгайч очиж:

- Та яагаад илжиг үүрч яваа юм бэ? Хүмүүс шоолно шүү дээ гэжээ.

Нөгөө хүү гэнэт сэтгэл түгшин бодож гэнэ. “Ингэхэд би ер нь юу үүрч яваа юм бол? Нэг хүн нохой гэлээ, нөгөө нь үхсэн тугал гэлээ, өөр нэг нь илжиг гэлээ. Энэ ер нь ямаа биш, чөтгөр болж таарлаа. Үүнээс одоохон салъя.”

Нөгөө хүү ямаагаа буулгаж орхиод, араас чөтгөр хөөх байх гэж айсандаа хөлийн хурдаар зугтав. Гурван хулгайч ямааг аваад буцаж гэнэ. “*Панчатантра*”-аас аваа.

### 3 Юунаас болсныг ярилцъя.

- ✓ Гурван хулгайч юу бодож нохой, тугал, илжиг гэж хэлсэн бэ?
- ✓ Хүү юунаас болж ямаагаа орхив.
- ✓ Хүү яагаад “Чөтгөр болж таарлаа.” гэж бодсон бэ?

### 4 Юу болсныг бичье.

#### Шалтгаан нь

Аав хэлсэн.

Ямааг хулгайлахыг бодсон.

Гурван хулгайч, “Нохой, тугал, илжиг” гэж хэлсэн.

“Энэ ер нь ямаа биш чөтгөр болж таарлаа.” гэж бодсон.

“Чөтгөр хөөх байх” гэж бодсон.

#### Юу болсон бэ?

.....

.....

.....

.....

.....

### 5 Би нөхдөөсөө юуны тухай асууж болох билээ?

- ✓ Хүү ямаа үүрч яваа гэдэгтээ үнэхээр итгэлтэй байгаа эсэх талаар тодруулж асууж болно.
- ✓ Хулгайч нарт үнэхээр юу харагдсан тухай асууж болно.
- ✓ Хүү “Чи сохор юм уу?” гэж асуултад асуултаар хариулсныг асууж болно.
- ✓ Үйл явдал хэзээ, хаана болсныг асууж болно.
- ✓ Учир шалтгааныг янз бүрээр асууж болно.



Зохиолд байгаа зарим нэг үгийг ажиглаад, зөв бичиж сурах хэрэгтэй юм байна.

Утгыг сайн мэдэж байвал зөв бичиж чадна шүү дээ!



6 Үг бүрээр өгүүлбэр зохиогоод үзье.

түгж

түгжинэ

нэгж

нэгжинэ

эмж

эмжинэ

- Хүүе! Хаалгаа түгж.

- Тэгнэ ээ. Түгжинэ, түгжинэ.

Санаа зоволтгүй.

шинж

шинжинэ

хөгж

хөгжинэ

өнж

өнжинэ

унж

унжина

угж

угжина

дэмж

дэмжинэ

Би үүнийг мэдлээ.

Эдгээр үг –“ж”- ээр төгссөн, бас бүгд “-на, -нэ, -нө” гэж залгаж бичсэн байна. Харин бүх үгэнд “и” бичжээ.

Тийм байна. Гэхдээ нэг чухал зүйл байна. Бүх үг нэг үетэй мөртлөө хоёр гийгүүлэгчээр төгссөн. Тийм байхад “-на, -нэ, -нө” гэж залгаж бичвэл гурван гийгүүлэгч нэг дор орох болох нь ээ. Тийм байдлаар хэлэхэд сонсголонтой биш юм аа. Тэгээд л “и” эгшиг бичсэн байна.

Миний мэдсэн зүйл

Надад асуулт байна.

“на, нэ, нө” гэж залгаж бичсэн байх юм. Энд “-но” гэж харагдахгүй байна даа. Тийм болохоор “-но” залгаж бичсэн үг олцгооё.

7 Үгийг сайн ажиглая.

1) Дээр байгаа үгстэй харьцуулъя.

2) Яаж бичсэнийг дүгнэж хэлье.

ээнэгшинэ, омогшино, эрэмшинэ, үүлшинэ, хоногшино, гаршина, хуршина, давшина, урамшина

8 Дараах зохиолыг уншъя. Нар, сар, үүлний санал бодол өөр өөр байгаа учрыг мэдье.

1) Уншихын өмнө нар, сар, үүл гурвын бодлыг чи юу гэж тайлбарлах вэ?

Нарны бодол:	Хүмүүс завгүй ажиллаж байдаг.
Сарны бодол:	Үгүй, хүмүүс дандаа унтаж байдаг.
Үүлний бодол:	Та хоёрынх хоёулаа зөв.



## Нар ба сарны харсан дэлхий

### 1.

Нар, дэлхий дээр хүмүүс амьдардаг тухай саранд ярьж өглөө. Тэр “Хүмүүсийн амьдардаг газар гайхалтай. Тэд үргэлж хичээнгүй ажиллаж байдаг. Газар дэлхийн навч модод нов ногоон өнгөөр гэрэлтэж, тэнд байгаа хүмүүс мод, цэцэг навчис, уул, усыг тордон хайрлаж байдаг” гэв. Нарны ингэж ярихыг сонссон сар хэлсэн нь:

- “Үгүй, навч модод мөнгөлөг өнгөөр гэрэлтдэг. Бас хүмүүс үргэлж унтдаг. Тийм болохоор ажиллахгүй, бас уул усыг хайрлахгүй байгаа” гэв.

Сар юу яриад байгааг нь нар ойлгосонгүй.

- Хүмүүс байнга унтдаг гэж үү? Үгүй ээ, тэд байнга завгүй хөдөлмөрлөж байдаг юм.

Сар ч мөн нар юуны тухай яриад байгааг ойлгосонгүй. Тийм болохоор тэд үүлнээс асуулаа. Үүл:

- Ха ха ха. Та хоёр өөр өөрийн харснаа л ярьж байна шүү дээ. Тийм болохоор л бие биенийхээ яриаг буруу гээд байгаа юм. Гэхдээ хүн бүрд мэддэггүй зүйл гэж байдаг юм.

- “Тэр нь юу гэсэн үг вэ?” гэж нар асуулаа.

### 9 Зохиолыг ойлгохын тулд асууж ярилцъя.

1. Нар “Газар дэлхий ногоон, хүмүүс үргэлж ажиллаж байдаг” гэж хэлсний учир юу бол?	Сар “Навч, модод мөнгөн өнгөөр гэрэлтдэг. Бас хүмүүс үргэлж унтдаг.” гэж хэлсний учир юу бол?
2. Нар яагаад сарны хэлснийг ойлгоогүй вэ?	Сар яагаад нарны хэлснийг ойлгоогүй вэ?
3. Үүл “Бие биенийхээ яриаг буруу гээд байгаа юм.” гэж хэлсний учир юу вэ?	

Нар, сар нь яагаад тэгж хэлж байгааг ухаарвал тэдний санал бодлыг зөв ойлгоно.



Би харснаа л хэлсэн. Би ч бас адилхан.

гэж хэлээд байгаа учрыг тайлбарлая.



### Хэлэлцэж ярих

Хэрэв нарны бодол зөв гэвэл чи түүнийг юугаар тайлбарлаж хэлэх вэ?  
Хэрэв сарны бодол зөв гэвэл чи түүнийг юугаар тайлбарлаж хэлэх вэ?

**10 Нар, сар хоёрын санаа бодлыг юу гэж ойлгосноо найруулан бичье.**

1) *Бичихийн тулд сар ингэж боддог шалтгааныг олъё.*

Мөнгөлөг  
өнгөтэй,  
хүмүүс  
нь үргэлж  
унтаж  
байдаг.




Сар тэгж боддог.

Үнэхээр тийм байдаг.

Сарны гэрэл тусахад ингэж харагддаг.

Сар хэзээ ч дэлхийг өдрийн цагаар хараагүй.



2) *Шалтгаан, бодол хоёрыг найруулан бичье.*

*"Дэлхийн хүмүүс үргэлж унтаж байдаг. Бас дэлхий мөнгөлөг саарал байдаг." гэж сар боддог. Энэ бодол нь нарныхаас өөр байгаа нь ямар нэг шалтгаантай. Тэр шалтгаан нь сар хэзээ ч өдрийн цагаар дэлхийг хараагүй, зөвхөн шөнө өөрийнхөө гэрэлд л хардагт байгаа юм.*

**Зохиолын төгсгөлийг уншъя.**

**Нар ба сарны харсан дэлхий**

2.


Нар өдөр харснаа, сар шөнө харснаа л ярьсан. Хэн ч гэсэн өөрийн бодлоо зөв гэж зөрүүдлэх үе байдаг даа. Миний бодол зөв байхад бусад хүний бодол ч бас зөв байж болно шүү дээ.

Нар, сар хоёр бие биенээ хараад толгой дохив.

**11 Сарны бодлын шалтгааныг яаж бичсэнээ бодъё.**

**12 Бичсэнээ бодоод гол зүйлийг ойлгоё.**

Гэрэлээ ингэж ойлгосон байна.



**13 Сар нь дэлхийг өдөр харсан бол юу гэж хэлэх бол? Нар нь дэлхийг шөнө харсан бол бас юу гэж хэлэх бол?**

Бат-Эрдэнэ олон янзаар төсөөлөн боджээ.

Дэлхий сайн харагддаггүй.

Дэлхий ногоон өнгөтэй. Хүмүүс ч тийм өнгөтэй.

Дэлхий тэр чигээрээ жижиг гэрлүүд байдаг.

Дэлхий олон өнгөтэй.



14 Нар, сар хоёр шиг өөрийнхөө бодож байгааг зөв гэж ярьдаг хүмүүсийг хараад ямар мэдрэмж төрснөө найзуудтайгаа ярилцъя. Тийм жишээ хэлье.

15 Дараах зохиолыг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

- 1) Баатруудын хэлсэн үгийг ялгаж бич.
- 2) Хэлсэн үгийг бодож баатруудын зан чанарыг тодорхойл.
- 3) Ямар шалтгаанаас юу болсныг тайлбарла.

### Ганц тахиа

Би нэг махны дэлгүүрт сууж байлаа. Эзэн нь их овжин зайтай эр. Бид хоёр эртний танилууд л даа.

Орой болж дэлгүүрээ хаах гэж байтал тахианы мах сурагласан хүн орж ирэв. Хормын өмнө бүх махаа зарж дуусаад, ганц тахиа үлдсэн тухай надад хэлсэн юм. Чингээд царай нь гэрэлтсэн дэлгүүрийн эзэн сүүлчийн тахиагаа жигнүүр дээр тавиад, “Таван рупи” гэв.

Асуулт зохио.

Нөгөө хүн “Өнөөдөр манайх олон зочинтой. Энэ тахиа жижигдэх байх. Арай том алга уу?” гэлээ. Дэлгүүрийн эзэн жаал бодлогоширсноо, тахиагаа аваад цаад өрөө рүүгээ орчхов.

Асуулт зохио.

Би ганц тахиятайг нь мэдэж байгаа болохоор гайхасхийн суулаа.

Асуулт зохио.

Мань эр мөнөөх тахиагаа барьсан чигтээ эргэж ирэв.

Асуулт зохио.

Тэгээд жигнүүр дээр буруу харуулж тавьснаа, жишим ч үгүй “7 рупи” гэвээ.

Асуулт зохио.

Гэтэл нөгөө хүн “За за, би хоёуланг нь авъя” гэж хэлэхэд дэлгүүрийн эзэн ёстой нэг ацан шалаанд орж билээ.

Асуулт зохио.

16 Дараах зүйр цэцэн үгийг ямар баатарт хэлэх вэ? Яагаад?

*Залилах гээд замаа алдана  
Зандрах гээд хүнээ алдана*

*Залхуу хүний толгой өвдөх олон  
Зальхай хүний худлаа хэлэх олон*

*Нэр олох насных  
Нэр хугарах өдрийнх*

17 “Эзэн нь овжин зайтай эр.” гэжээ. Түүнийг яагаад ингэж хэлсэн юм бол? Жишээгээр тайлбарлан бичээрэй.

## 1 Зохиолыг уншиж ойлгоё.

### Хоёр найз

Сохор номин голын нөгөө эрэгт байх нэгэн харанхуй нүхийг анзаарав. Тэр нүхэнд хурц бөгөөд жижигхэн, яг од шиг зүйл гялалзах ажээ. Дахин дахин лавлан харлаа. Энэ бол хэн нэгний нүд ажээ. Жижигхэн царай нь ч харагдлаа.

- Хууз сахалтай, жижигхэн бор царайтай, бяцхан чихтэй, өтгөн сахлаг үстэй амьтан нүхнээс гарч ирлээ. Энэ бол усны харх ажээ. Харх, сохор номингийн анзаараагүй байсан завин дээр суугаад, эрэг өөд сэлүүрдэн хөдөллөө. Завины гадна талыг хөх өнгөөр, дотрыг цагаан өнгөөр будсан байх агаад ердөө хоёр амьтан л багтах зайтай ажээ.

“Бургааасан шугуйн салхи” зохиолоос хэсэглэв.

- 1) Сохор номин юуг олж харсан бэ?
- 2) Тэр харж байх үедээ ямархуу байдалтай байсан бол?
- 3) Ямар гэсэн асуултад хариулж загварыг гүйцээн бичье.



Ямар?

- \_\_\_\_\_ сахалтай
- \_\_\_\_\_ царайтай
- \_\_\_\_\_ чихтэй
- \_\_\_\_\_ үстэй

4) Хархны юуг нь дүрсэлснийг  тэмдэглэв.

зан чанарыг

дотоод байдлыг

гадаад байдлыг

4) Завийг хэрхэн дүрсэлж бичсэнийг хүснэгтэд гүйцээн бичье.



Гаднах тал нь  
(гадаад шинж)

Дотор тал нь  
(дотоод шинж)

.....

.....

## 2 Зохиолыг үргэлжлүүлэн уншъя.


Сохор номин:

- Би сэлүүрдэж үзмээр байна, тэгэх үү?

- Цаг нь арай болоогүй байна, найз минь. Чамд сэлүүрдэх хичээл заасны дараа хийхэд оройтохгүй. Сэлүүрдэнэ гэдэг харагдаж байгаагаасаа хэцүү шүү гэж харх хэлэв. Сохор номин хархыг хараад атаархаж эхлэв. Биеэ тоосон чанар нь түүнд “Чи сэлүүрдэж чадна аа. Маш сайн” гэж шивнэх аж. Харх эргэн тойрон дахь усны мандлыг анхааралтай ажиглан сэлүүрдэнэ. Сохор номин гэнэт хархын дэргэд үсрэн очиж сэлүүрийг шүүрч авахад харх урагшаа унаж, хөл нь агаарт сарвалзав.

- Хүүе! Чи болиоч, одоо живүүлэх нь байна шүү дээ гэж харх хэллээ.

## 3 Баатруудын хийсэн үйлээр зураглал хийе.



4 Хийсэн үйлийг бодож баатрын зан чанарыг дүрсэлж бичье.



.....  
.....  
.....  
.....



.....  
.....  
.....  
.....

1) Дүрслэн бичихдээ дараах үгийг дээрх хоёр амьтанд тохируулан хэрэглэе.

хашир, атаархуу, сониуч, биеэ тоосон, онгироо, анхаарал болгоомжтой, дээрэлхүү, тусархуу

5 Цааш юу болсон бол? Үргэлжлүүлэн бичье.

1 Зохиолыг уншъя.

1) Ямар үг, өгүүлбэр байхыг таамаглан хэлье.

**Муу даа**

Айсандаа үсээ өрвийлгөж, хашааны ёроол руу шигдсэн муурын бяцхан зулзагыг нохой ууртайгаар боргоож байлаа. Муурын зулзага амаа ангайлган ..... орилох ажээ. Хажууханд нь хоёр хүүхэд тэдний яахыг нь сонирхон хүлээнэ.

Гэтэл цонхоор нэг бүсгүй тэднийг харангуут довжоон дээрээ яаран гарч ирээд, нохойг хөөлөө. Чингэснээ хүүхдүүдэд хандан:

- Юу гэж хэлсэн бол таамаглан хэлээрэй. гэж ууртай гэгч хашхирав.
- Юунд санаа зовох гэж! Бид яагаа ч үгүй шүү дээ! гэж тэднийг гайхахад:
- Юу гэж хэлсэн бол таамаглан хэлээрэй. гэж тэр бүсгүй ууртай хэлжээ.

*В.Осеева*

- 1) Эхийг уншаад бүлгийн нүүр хуудас дээрх зурагтай харьцуулан ярилцъя. Чиний өмнөх таамаглалаас юу нь өөр байв?
- 2) Хэрэв чи байсан бол муурын зулзаганд туслах байсан уу?
- 3) “Яагаа ч үгүй байдаг чинь л харин муу байна даа” гэж бүсгүй хэлсний учир юу вэ?

2 “Муу даа” зохиолыг дуурайн зохиож бичье.

- 1) Яаж бичихээ бодож төлөвлөө.
- 2) Бичсэнээ засаж сайжруулъя.
- 3) Бичсэнээ чанга дуугаар уншъя.

## Үгийн утгын тайлбар

Үгс	Толь бичигт тайлбарласан нь	Холбоо үгээр
<b>А</b>		
<b>АД</b>	шоолон дургүйцэх, зэвүүрхэн шоовдорлох;	ад үзэх
<b>АДАСГА</b>	1. турж үхсэн үхэр адууны шир, тугал бярууны арьс; 2. дэвсгэр болгон хэрэглэх үхэр малын хатсан шир, арьс; 3. хүний муухай зан ааш;	адасга дэвсэх
<b>АЗНАХ</b>	байзнах, түдгэлзэх, түр харзнах	намайг идэхээ азна
<b>АРАНЗ</b>	мөрөнд үүрдэг цүнх	... аранзаа мөрөндөө үүрч
<b>Б</b>		
<b>БОРГООХ</b>	нохой ээрэн хоргоож хуцах	ууртайгаар боргоох
<b>БЭЛГЭ</b>	шинж тэмдэг; бэлгэ дэмбэрэл, бэлгэ шинж	ирэх цагийн шувуу бэлгэтэй
<b>Г</b>		
<b>ГАЦАА</b>	гацаа тосгоны ойролцоох хэсэг бүлэг айл	хуучин гацааны хашаа
<b>ГУРИНХЛАХ</b>	өлсөж туранхай болох;	гуринхалж явах
<b>ГУТАХ</b>	буурч доройтон зовних;	өлссөндөө гутах
<b>Д</b>		
<b>ДОВЖОО</b>	байшингийн эх биеэс илүү гарсан суурийн хэсэг;	довжоон дээр гарч
<b>ДОРГО</b>	<u>амьтан</u> суусрын язгуурын араатан; өвөл ичдэг, ойд амьдардаг амьтан	дорго ууль хоёр
<b>ДУРСАХ</b>	дурдан санах, дурдах; эргэн санах	хааяа нэг дурсах
<b>ДӨРТЭЙ</b>	хамрын баганыг цоолон хөндлөн шургуулсан мод; малын хамрын нүхээр оосорлосон оосор;	дөртэй үхэр
<b>Е</b>		
<b>ЕРДӨӨ</b>	1. угтаа, 2. энгийндээ, 3. зөвхөн;	
<b>ЕРТӨНЦ</b>	бидний байгаа газар дэлхийг оршиж байгаа юмны хамт нийтэд нь;	ертөнцийн өнгийг мэдэх
<b>Ж</b>		
<b>ЖИГШИХ</b>	хүний сэтгэлд үл зохилдох зүйлийг ихэд голж зэвүүрхэх санаа төрөх;	жигшигдэн хөөгдөх
<b>ЖИНГЭНЭХ</b>	нарийн шингэн дуугаар удаан дуугарах;	жингэнэтэл дуугарах
<b>З</b>		
<b>ЗАНШИХ</b>	хэвшиж заншил болох;	нэрлэж занших
<b>ЗҮС</b>	амьтны өнгө;	бор халтардуу зүс
<b>М</b>		
<b>МАЛИГАР</b>	нүүр царай халзандуу, тарган махлаг;	малигар хүү
<b>МАНУУЛ</b>	<u>амьтан</u> хээрийн муур, өнгө шаравтархан, бидэртэй;	мануулын тор
<b>МАРУУХАН</b>	муу байх, тааруухан, сул байх	маруухан байв
<b>МЭЛМИЙ</b>	нүдний хүндэтгэл үг	харах мэлмий
<b>Н</b>		
<b>НИРГЭХ</b>	цахилгаан цохих, аянга дайрах;	
<b>НОЦОХ</b>	асах, шатах;	хуурай түлээ ноцох
<b>НӨХӨӨС</b>	нөхөж битүүлж тавих зүйл;	нөхөөс дээлэндээ тустай
<b>О</b>		
<b>ОМГОРХОГ</b>	омогдох байдал бүхий;	ихэрхэг омгорхог болох
<b>ОРГИЛОХ</b>	хүчтэй шахагдан гарах;	оргилж байх
<b>ОТОХ</b>	сэмхэн амдаж хүлээх;	отон хэвтэх

<b>Ө</b>		
<b>ӨӨГШҮҮЛЭХ</b>	амтших, эрэмших;	өөгшүүлж болохгүй
<b>ӨРВИЙХ</b>	өрөвгөр болох;	үсээ өрвийлгөх
<b>ӨРӨВЛӨГ</b>	шувууны өд;	тахиа өрөвлөгтэй
<b>Р</b>		
<b>РУПИ</b>	энэтхэгийн мөнгөн тэмдэгт;	долоон рупи
<b>С</b>		
<b>САМРАН</b>	усанд сэлэх; усанд самрах;	усанд самран сэлэх
<b>САЖЛАХ</b>	алгуур алхаж явах; байн байн сажих;	явган сажлах
<b>СҮЛЭЛДЭХ</b>	холих, холилдох;	гэрэл сүүдэр сүлэлдэх
<b>СЭВЛЭГ</b>	хүүхдийн унаган үс;	сэвлэг үргээх
<b>СЭЛҮҮНД</b>	чөлөөтэй зайтай байх;	хөдөөгийн сэлүүнд
<b>Т</b>		
<b>ТОТГО</b>	гэр, байшингийн хаалганы дээд хэсэг;	гэрийн тотго
<b>ТӨСӨӨРӨХ</b>	мартаж эв дүйгүй болох, төшөөрөх	монгол ахуйгаас төсөөрснөө мэдэх ээж аавдаа тунирхах
<b>ТУНИРХАХ</b>	гоморхох;	
<b>У</b>		
<b>УРЛАН</b>	ур дарх хийх газар, өрөө, тасалгаа;	өвөөгийн урланд очих
<b>УУЛЬ</b>	махчин шувуу;	ууль дорго хоёр
<b>УУР</b>	юм хийж нүдэж нунтаг болгох нүдүүр бүхий сав;	уур нүдүүр
<b>Ү</b>		
<b>ҮЕ</b>	хүний төрөл уламжлалын зэрэг дэс;	үеэ дуустал мартаггүй
<b>ҮЛГЭР</b>	загвар, маяг, дуурайлган хийх хэлбэрийн жишээ;	их гэрийн үлгэрээр хийх
<b>Х</b>		
<b>ХАЛГААХГҮЙ</b>	биеэсээ зайлуулах, ойртуулахгүй;	амьтан хүнийг халгаахгүй
<b>ХАРАНГАДАХ</b>	өлсөж ундаасан үхэтхийн унах;	ботго нь харангадах шахаж
<b>ХИЛЭГНЭХ</b>	уурлах;	хилэгнэх
<b>ХОРГО</b>	юм агуулах жижиг сав;	хоргонд хийх
<b>ХӨДӨС</b>	элдсэн нэхий арьсны хуучирсан хэсэг;	хөдсөн дээлтэй
<b>ХУЛМАЙХ</b>	мал чихээ арагш дарах	хулмайн хэвтэх
<b>ХҮЛЦЭН</b>	ямар нэг хортой муу зүйлийг тэсвэрлэн өнгөрөөх	хүлцэн тэсвэрлэх
<b>ХҮРХРЭЭ</b>	хаднаас хүчтэй урсан буух их ус	Анхель хүрхрээ
<b>ХЭВНЭГ</b>	бороо цасанд өмсөх, нөмрөх хувцас	хэвнэгийн өнгө
<b>ХЯМГАДАХ</b>	юмыг хайрлах хамгаалах	сүүдрээ хямгадах
<b>Ц</b>		
<b>ЦЭЭЛ</b>	урсгал усны гүн гүнзгий газар	цээлийн загас
<b>Ч</b>		
<b>ЧАНД</b>	маш бат, чанга, хатуу;	хашаагаа чанд хатуу манах
<b>ЧАНХ</b>	эгц, цэх	чанх дээр
<b>Ш</b>		
<b>ШОШГО</b>	худалдаалах бараанд зүүдэг танилцуулах цаас;	шошгоны тайлбар
<b>ШУРГАХ</b>	юман доогуур орох	нүхэнд шургах
<b>Э</b>		
<b>ЭЛЭЭХ</b>	хөгшрөх	насаа элээх
<b>Я</b>		
<b>ЯРШИГ</b>	саад, төвөг, ярвиг;	яршиг төвөг болох

# МОНГОЛ ХЭЛ

## III

Ерөнхий боловсролын сургуулийн  
3 дугаар ангийн сурах бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:	Ө.Цэндсүрэн
Гишүүд:	Р.Бигэрмаа П.Жаргалсайхан У.Нямхүү

Редактор:	Ц.Өнөрбаян
Техник редактор:	У.Мягмаржав
Хэвлэлийн эх бэлтгэгч:	Ө.Одонцэцэг
Зураач:	Л.Баярхүү Г.Мөнхжаргал

Формат 84x108/16  
Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м<sup>2</sup>  
Хэвлэлийн хуудас 16 х.х

Хэвлэлийн эхийг “Экимто” ХХК-д бэлтгэж,  
“Битпресс” ХХК-д 10000 хувь хэвлэв.